



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР  
МЕРСИ КОР ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА

# САЙН ЗАСАГЛАМЫН ТӨЛӨӨХ САЙН ТҮРШЛАГА

Улаанбаатар 2014 он



## САЙН ЗАСАГЛАЛЫН ТӨЛӨӨХ САЙН ТУРШЛАГА

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, АНУ-ын ОУХА-ийн санхүүжилтээр Мерси Кор Олон Улсын Байгууллагын хэрэгжүүлж буй “Хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо” (APREAL) төсөлтэй хамтран сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны сайн туршлага, сургамжуудыг нэгтгэн тодорхойлж, “Сайн засаглалын төлөөх сайн туршлага” гарын авлагыг эрхлэн хэвлүүлж нийтийн хүртээл болгож байна.

Энэхүү гарын авлагад сайн засаглалын талаар хийж бүтээж байгаа 20 байгууллагын сайн туршлага санаачлагыг багтаалаа. Сайн засаглалын сургамж, сайн туршлагуудыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, сайн засаглалын зарчим, үзэл баримтлалд тулгуурлан төрийн байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, төрийн байгууллагын удирдлагуудад үйл ажиллагааны гарын авлага болгоход зориулан хэвлэв.

### Боловсруулсан:

Редактор: Н.Баасанхүү  
Сэтгүүлч: О.Болормаа  
Сэтгүүлч: Г.Сонинбаяр

*Энэхүү хэвлэлд тусгасан мэдээлэл нь Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын хөгжлийн Агентлаг болон Америкийн Нэгдсэн Улсын Засгын газарт хамаарахгүй*

*© Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ нь Авлигатай тэмцэх газар, зохиогчдын бүтээл бөгөөд зөвшөөрөлгүйгээр хэвлэх, нийтлэх аль ч хэлбэрээр хуулбарлан олшруулахыг хориглоно.*

*2014 он*

Цаасны хэмжээ: В5  
Хэвлэлийн хуудас: 10 х.х  
Хэвлэсэн тоо: 1500ш  
“Сэлэнгэпресс” ХХК-д хэвлэв

# ГАРЧИГ

1.	ӨМНӨХ ҮГ.....	4
2.	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА .....	5
	САНГИЙН ЯАМ	
	МӨНГӨТЭЙ, БАС МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙЖ	
	ОРОН НУТАГ ХӨГЖИНӨ .....	6
	ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ	
	ШИЛЭН ДАНСТАЙ ЖИЖИГ ДУНДЫНХАН .....	11
	УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР	
	“ГЭРТ ХҮРГЭЭД ӨГЧИХӨӨРЭЙ”.....	15
	УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗАР	
	ӨРГӨДЛӨӨ “УХААЛАГ ЦАГДАА”-Д ӨГЧИХЬЕ .....	23
3.	УЛААНБААТАР.....	25
	УЛААНБААТАР ХОТ БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ	
	ОЛОН ХААЛГЫГ НЭГ ЦОНХ БОЛГОСОН НЬ .....	26
	УЛААНБААТАР ХОТ СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ	
	105 дугаар дунд сургууль	
	АВЛИГАГҮЙ ИРЭЭДҮЙН ЭЗЭД .....	32
	УЛААНБААТАР ХОТ СҮХБААТАР ДҮҮРЭГ	
	АВЛИГАД ХАРШИЛТАЙ ДҮҮРЭГ .....	37
	УЛААНБААТАР ХОТ ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ	
	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА	
	С.ЖАМЪЯНДОРЖ: “ТЕНДЕРТ ИРГЭДИЙН БҮЛЭГ	
	ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ, ЗҮТГЭЛТЭЙ ХАНДДАГ”.....	41
4.	АЙМГУУД .....	48
	АРХАНГАЙ АЙМАГ ЭРДЭНЭБУЛГАН СУМ	
	“МИНИЙ САНАЛЫГ ЗААВАЛ ОРУУЛААРАЙ”.....	50
	ДАРХАН-УУЛ АЙМАГ ХЭВЛЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН	
	ХОЙД БҮСИЙН ТӨВ “ХӨСРИЙН ӨВСГҮЙ ЦЭЦЭРЛЭГ ”.....	54
	ДОРНОД АЙМАГ	
	ДОРНОДЧУУД ТЕНДЕРИЙГ “ТЭНГЭРЭЭС БУУЛГАЖЭЭ”.....	59
	ӨВӨРХАНГАЙ АЙМАГ	
	ТӨРИЙН АЧААГ ХӨНГӨЛСӨН ИРГЭНИЙ НИЙГМИЙНХНИЙ ОРОЛЦОО .....	64
	ӨМНӨГОВЬ АЙМАГ	
	ХУРААР ДУТАВЧ МЭДЭЭЛЛЭЭР ЦАНГАХГҮЙ ӨМНӨГОВЬЧУУД .....	69
	УВС АЙМАГ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА	
	ЦАХИМ ТЕНДЕРЭЭР ЦАХИУР ХАГАЛСАН УВСЫНХАН .....	72
	УВС АЙМАГ	
	ИРГЭНИЙ ГОМДОЛ“ИЛ” ХАРАГДАНА .....	76
	ХОВД АЙМАГ БУЯНТ СУМ	
	ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАСАН БУЯНТ СУМЫН ТУРШЛАГА .....	80
	СҮХБААТАР АЙМАГ ИРГЭНИЙ ТАНХИМ,“ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙН ЭЗЭД” ТББ	
	ИРГЭНИЙ ТАНХИМААС ЗАХИДАЛ ИЛГЭЭЛЭЭ .....	84
5.	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА .....	89
	“АРДЧИЛЛЫН БОЛОВСРОЛ ТӨВ” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА	
	ИЛ ТОД БАЙДАЛД ИРГЭД ДҮН ТАВИНА .....	90
	“ИЛ ТОД БАЙДАЛ САН “ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА	
	“ИЛ ЗАСАГ”-ИЙН ЭРЭМБЭ .....	94
	“МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН “ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА	
	“ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ ӨӨРСДӨӨ ХЯНАЯ”.....	100
	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	107

Монгол Улсын Авлигатай тэмцэх газраас төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн шударга ёсыг бэхжүүлэх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаа, санал санаачилгыг дэмжин, олон нийтэд таниулах, сурталчлах, бусдад үлгэр дуурайл болгох, шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэхийг зорин ажилладаг билээ.

Авлигатай тэмцэх үйл ажиллагааг зөвхөн албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, авлигын гэмт үйлдлийг таслан зогсоох ажлын хүрээгээр явцууруулан харах нь өрөөсгөл юм.

Хээл хахууль, хүнд суртлаас ангид төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд тэгш шударгаар хүргэж байгаа, сайн засаглалыг салбар бүртээ, байгууллагууд дотооддоо нэвтрүүлж байгаа арга туршлагыг авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгон авч үзэх нь зүйтэй.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бууруулж, хариуцлагатай нийтийн албыг төлөвшүүлэх, төрийн үйлчилгээг хүнд суртал чирэгдэлгүй, нээлттэй ил тод хүргэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудаас санаачилан хэрэгжүүлж байгаа шинэлэг ажил арга хэмжээ, арга туршлагаас дээжлэн ярилцлага, нийтлэл хэлбэрээр сурвалжлан танилцуулсан энэхүү гарын авлагыг бэлтгэн гаргаж байна.

Тус гарын авлагад нийт 20 сайн туршлагын санал санаачилгуудыг дурдсан бөгөөд сайн засаглалыг бэхжүүлэх, ил тод хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвхи зүтгэл, хамтын ажиллагааны үр дүнг энэхүү гарын авлагад харуулахыг зорьсон болно.

Энэ гарын авлага нь Та бүхэнд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад шинэ санаа, санаачилгын сэдлийг өгнө гэдэгт илтгэлтэй байна.


“Сайн засаглалын сайн туршлагууд” гарын авлагыг бэлтгэн олны хүртээл болгоход дэмжлэг үзүүлж хамтран ажилласан “Мерси Кор” Олон Улсын байгууллагын хамт олонд талархал илэрхийлж байна.



САЙН ЗАСАГЛАЛЫН ТӨЛӨӨХ  
САЙН ТҮРШЛАГА

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

---



## САНГИЙН ЯАМНЫ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

**САЙН ТУРШЛАГА:** 2013 оноос эхлэн иргэд нийслэл, дүүрэг, аймаг, сумандаа төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх аливаа ажилд санал өгч, хуваарилалт, зарцуулалтад нь идэвхтэй оролцох болсон. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хэрхэн юунд зарцуулахаа иргэд өөрсдөө шийднэ гэсэн үг. Үүнтэй холбоотойгоор мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Сангийн яамнаас Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн системийг бий болгож туршиж эхэлсэн байна. 2013 оны байдлаар тус сангийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжсэн 6462 төсөл, арга хэмжээ, тэдгээрийн санхүүжилтийн байдал, гүйцэтгэгчийн нэр, тендер зарласан байдал зэрэг мэдээллүүдийг системд оруулжээ. Уг ажлыг санаачлан хийсэн нь төсвийн зарцуулалт, хуваарилалтад ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сайн туршлага болж чаджээ.

## МӨНГӨТЭЙ, БАС МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙЖ ОРОН НУТАГ ХӨГЖИНӨ

### Иргэдээс холдсон ил тод байдал

Төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олж авах асуудал хүндрэлтэй, хаалт, хориг, саад бэрхшээл ихтэй байгаа нь нууц биш. Ялангуяа татвар төлөгчдийн мөнгөөр бүрддэг улсын болон орон нутгийн төсвийг хэрхэн захиран зарцуулж байгаа талаар иргэд, олон нийтийн ойлголт, мэдээлэл тун хангалтгүй байгаа. Төсөв төлөвлөх,

батлах, хэрэгжүүлэх, тайлагнах бүхий л үйл ажиллагаанд иргэдийн оролцоо огт байдаггүй. Иргэд мэдээлэл хомсоос болж өөрийн амьдарч буй орон нутагт тулгамдаж байгаа асуудлаа шийдвэрлүүлж чадахгүйд хүрдэг байна. Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас эрхлэн гаргадаг Төсвийн ил тод байдлын 2012 оны судалгаагаар манай улс нийт 100 оноо авахаас 51 оноотойгоор дэлхийн 100 орноос 38 дугаар байр буюу дунд түвшинд

эрэмбэлэгдсэн байдаг. Ийнхүү төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоог хангахтай холбоотой хууль тогтоомж, журмын хэрэгжилт хангалтгүй байгаагийн шалтгаан нь төсвийн орлого, зарцуулалт, мөнгөн гүйлгээ, тайлан үйл ажиллагаа болон өр, зээл, батлан даалт, өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой шийдвэр зэрэг бүхий л үйл ажиллагааг цогц байдлаар олон нийтэд нээлттэй, ил тод, иргэдэд ойлгомжтой, шуурхай мэдээлэх зүйн тогтолцоо бүрдээгүйнх гэж хөндлөнгийн шинжээчид дүгнэдэг.

Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулж батлуулсан Шилэн дансны тухай хууль 2015 оны нэгдүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлснээр дээрх байдал өөрчлөгдөнө гэсэн хүлээлт бий. Харин уг хууль хүчин төгөлдөр хэрэгжихээс өмнө Сангийн яам “Шилэн данс”-нд шилжих шийдлүүдийг санаачлан хэрэгжүүлсний нэг нь эхэнд өгүүлсэн Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн систем юм.

### **Шийдэл нь шууд оролцоо**

УИХ-аас шинэчлэн баталсан Төсвийн тухай хуулийн дагуу 2013 онд Орон нутгийн хөгжлийн санг анх удаа үүсгэн байгуулжээ.

Тус санд 2013 онд 209.0 тэрбум, 2014 онд 282.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна. Өмнө нь орон нутгийн хөрөнгө оруулалтад зориулж 2010 онд аймгуудад дунджаар 500.0 сая, 2011 онд 800.0 сая, 2012 онд 1.0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс хуваарилж байсан боловч энэхүү хөрөнгийн хуваарилалтыг тухайн шатны Засаг дарга, хурал хийдэг байв. Нэг үгээр хэлбэл иргэд өөрсдийн төлсөн татвараас бүрдсэн төсвийг хуваарилах, зарцуулахад ямар нэгэн оролцоо байхгүй, тэр ч байтугай энэ талаарх мэдээлэл хомс байлаа.

Сум, дүүрэгт амьдран суугаа иргэдийн

хувьд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөөг баг, хорооны иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг боловч хийгдэж байгаа ажлын тендер шалгаруулалт, худалдан авалтын байдал, тэдгээрийн хэрэгжилт, явц, санхүүжилтийн талаарх мэдээллийг огт авч чадахгүй, хаалттай, өөрөөр хэлбэл Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд нь хяналт тавих боломж үндсэндээ байсангүй. Харин 2013 оноос эхлэн Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтыг иргэд, олон нийтийн шууд оролцоотойгоор хийх болсон нь шинэлэг шийдэл байв.

### **“Шилэн данс”-нд шилжих мэдээллийн систем**

Төсвийн тухай хуулийн 12.1.19, 20.1 дэх заалтаар төсвийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мөн бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлэх чиг үүргийг Сангийн яам хариуцахаар хуульчилсан байдаг.

Харин шинээр бий болсон Орон нутгийн хөгжлийн сангийн тухайд тус сангийн төсвийн гүйцэтгэл, тайлагналтын мэдээллийн нэгдсэн тогтолцоо огт бүрдээгүй байв. Түүнчлэн, Төсвийн тухай хуулийн 6.5.3, 6.5.4 дэх заалтаар төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих, мөн төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах үүргийг Төсвийн захирагч нарт хүлээлгэсэн байдаг ч, Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээлэл, тайлагналтын нэгдсэн тогтолцоо

байхгүйгээс Төсвийн захирагч нарт хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломж үндсэндээ байхгүй байв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны зургадугаар сарын 10-ны өдрийн Засгийн газарт чиглэл өгөх тухай 88 дугаар захирамжид улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарцуулалт болон тайлагнах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх “шилэн данс”-ны тогтолцоонд шилжихийг даалгасан юм.

Иймээс Сангийн яам Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигыг хэрэгжүүлэх, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн системийг яамны мэргэжилтнүүдийн тусламжтайгаар боловсруулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн системийг анх санаачилж, ажлын даалгаврыг боловсруулан, туршилт тохируулга хийх ажлыг Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтсийн дарга М.Батгэрэл болон тус хэлтсийн мэргэжилтнүүд гардан хийж гүйцэтгэжээ. Тус хэлтсээс мэдээллийн системийнхээ талаар

Монгол Улсын хэмжээнд холбогдох бүх албан тушаалтнуудад сургалт зохион байгуулсан байна.

Мэдээллийн системийн программ хангамжийг боловсруулсан Сангийн яамны Санхүүгийн мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн Д.Энхмандах, З.Батгэрэл нараас зарим зүйлийг тодруулсан юм.

“Би жирийн иргэний хувьд орон нутагтаа ОНХС-гаас хэрэгжүүлж буй төсөвт ажлуудын талаарх мэдээллийг хэрхэн олж авах вэ” гэсэн асуултад маань тэд тун дэлгэрэнгүй хариулт өглөө. Нэг ёсондоо зааварчилгаа ч гэж болно.

**Мэргэжлийн хүмүүсийн энэ зөвлөгөөг уншигч тантай хуваалцъя.**

**Төсвийн талаарх мэдээллийг төвөггүй авна**

Орон нутгийн хөгжлийн сан		Хөвсгөл									
		Сангийн яам									
Нүүр	Өнгөдөл	Хэлбэр барих	Тухай	Гарах							
Өнгөдөл	Төлөвлөсөн шилжүүлэг										
Төлөвлөсөн шилжүүлэг	Сумын ОНХС-н шилжүүлгийн нийлбэр аймгийн дүнгэй тэнцүүлж байна!										
Санхүүжилт	Сум, дүүрг	Нийт	1-Р САР	2-Р САР	3-Р САР	4-Р САР	5-Р САР	6-Р САР	7-Р САР	8-Р САР	9-Р САР
Бичиг дүнгээр	Хөвсгөл	11,138,150,020.0	0.0	523,758,830.0	459,759,740.0	903,393,490.0	1,356,887,950.0	942,300,000.0	843,300,000.0	931,600,000.0	931,600,000.0
ХО-ын нөхцөл	Хөвсгөл аймгаг-сум	4,435,400,000.0	0.0	0.0	0.0	956,722,500.0	349,080,000.0	407,680,000.0	308,680,000.0	396,980,000.0	396,980,000.0
ХО-ын төлөрийн ялгагч	Мөрөн сум	1,518,400,000.0	0.0	0.0	0.0	318,864,000.0	121,472,000.0	121,472,000.0	121,472,000.0	121,472,000.0	121,472,000.0
ОНХС-ийн мэдээлэл	Алтан-Эрдэнэ сум	193,200,000.0	0.0	0.0	0.0	40,572,000.0	15,456,000.0	15,456,000.0	15,456,000.0	15,456,000.0	15,456,000.0
	Арбулаг сум	189,200,000.0	0.0	0.0	0.0	39,732,000.0	15,136,000.0	15,136,000.0	15,136,000.0	15,136,000.0	15,136,000.0
	Баянхүү сум	204,500,000.0	0.0	0.0	0.0	42,945,000.0	16,360,000.0	16,360,000.0	16,360,000.0	16,360,000.0	16,360,000.0
	Бүрэнгогтох сум	208,800,000.0	0.0	0.0	0.0	43,848,000.0	16,704,000.0	16,704,000.0	16,704,000.0	16,704,000.0	16,704,000.0
	Галт сум	243,200,000.0	0.0	0.0	0.0	51,072,000.0	19,456,000.0	19,456,000.0	19,456,000.0	19,456,000.0	19,456,000.0
	Даргалант сум	224,500,000.0	0.0	0.0	0.0	47,145,000.0	17,960,000.0	17,960,000.0	17,960,000.0	17,960,000.0	17,960,000.0
	Пнь-Уул сум	211,200,000.0	0.0	0.0	0.0	44,352,000.0	16,896,000.0	16,896,000.0	16,896,000.0	16,896,000.0	16,896,000.0
	Рашаант сум	198,600,000.0	0.0	0.0	0.0	41,706,000.0	15,888,000.0	15,888,000.0	15,888,000.0	15,888,000.0	15,888,000.0
	Ревчиншүрбэ сум	290,200,000.0	0.0	0.0	0.0	60,942,000.0	23,216,000.0	23,216,000.0	23,216,000.0	23,216,000.0	23,216,000.0
	Тарваан сум	260,200,000.0	0.0	0.0	0.0	54,642,000.0	20,816,000.0	20,816,000.0	20,816,000.0	20,816,000.0	20,816,000.0
	Тосоншигэл сум	187,600,000.0	0.0	0.0	0.0	39,396,000.0	15,008,000.0	15,008,000.0	15,008,000.0	15,008,000.0	15,008,000.0
	Төмөрбулаг сум	186,300,000.0	0.0	0.0	0.0	39,123,000.0	14,904,000.0	14,904,000.0	14,904,000.0	14,904,000.0	14,904,000.0
	Түгэл сум	186,950,000.0	0.0	0.0	0.0	39,259,500.0	14,956,000.0	14,956,000.0	14,956,000.0	14,956,000.0	14,956,000.0
	Угсаа-Уул										

Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн систем нь цахим хандалтат системтэй бөгөөд бүх төрлийн интернэт хөтөч дээр ажиллах боломжтой, төрийн сангийн сүлжээ орсон бүх аймаг, нийслэл, сум,

*Зураг: Цахим хуудасны харагдах байдал*



Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн төлөвлөгөө » Улаанбаатар » Улаанбаатар хот-Сум »				
Барилга байгууламж, төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2014 оны төлөвлөгөө	Санхүүжилт	Бусад мэдээлэл
2 дугаар байрны хойд талбайн усан оргилуур /БГД, 5-р хороо/	20,000,000	20,000,000	0	Дэлгэрэнгүй
23 дугаар байрны урд Гэрэлтүүлэг болон бусад ажил /СБД, 5-р хороо/	18,600,000	18,600,000	0	Дэлгэрэнгүй
23 дугаар байрны урд иж бүрэн хүүхдийн тоглоомын тоног төхөөрөм	19,200,000	19,200,000	0	Дэлгэрэнгүй
23 дугаар байрны урд ногоон байгууламж /СБД, 5-р хороо/	20,000,000	20,000,000	0	Дэлгэрэнгүй
23 дугаар байрны урд сандал, хогийн сав, чийрэгжүүлэлтийн тоглоом	17,400,000	17,400,000	0	Дэлгэрэнгүй
23 дугаар байрны урд тоглоомын талбайн резин, сүүдрэвч /СБД, 5-р	15,200,000	15,200,000	0	Дэлгэрэнгүй
23 дугаар байрны урд явган хүний зам II хэсэг /СБД, 5-р хороо/	19,200,000	19,200,000	0	Дэлгэрэнгүй
42 дугаар байрны талбайд иж бүрэн тоглоомын талбайн гэрэлтүүлэг	15,000,000	15,000,000	0	Дэлгэрэнгүй
"Байгууламж" СӨХ-ны 5 дугаар байрны дээврийн засвар /СБД, 7-р х	59,400,000	59,400,000	0	Дэлгэрэнгүй
"Бат-Өргөө" СӨХ-ны 11 дүгээр байрны 3,4 -р орчны дээврийн засвар	40,900,000	40,900,000	0	Дэлгэрэнгүй
"Баян булаг" СӨХ-ны 28 дугаар байрны фасад /ЧД, 2-р хороо/ 2320 м	104,400,000	104,400,000	0	Дэлгэрэнгүй
"Бид" СӨХ-ны 26 дугаар байрны дээврийн засвар /СБД, 6-р хороо/ 10	69,300,000	69,300,000	0	Дэлгэрэнгүй
"Бат" СӨХ-ны 18 дугаар байрны дээврийн засвар /СБД, 8-р хороо/ 1	47,300,000	47,300,000	0	Дэлгэрэнгүй

Зураг: Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн төлөвлөгөө

дүүрэгт ашиглах боломжтой, хэрэглэгчийн компьютерт тусгайлан суулгах шаардлагагүй, хэрэглэгчийн компьютерийн гацалтаас үл хамааран Сангийн яамны серверт тасралтгүй ажилладаг систем юм.

Системд өөрчлөлт, шинэчлэлт оруулан нэвтрүүлэхэд хялбар бөгөөд бүх хэрэглэгч дээр очиж дахин суулгах, тохируулах шаардлагагүй, аймаг, сумдын оруулсан мэдээллийг нэгдсэн өгөгдлийн санд хадгална. Аймаг, сумд мэдээллийг тус тусад нь бэлтгэн зөөж, нэгтгэх шаардлагагүй. "Хадгалах" товч дарахад л системд мэдээлэл орж, Сангийн яам болон бусад хэрэглэгч мэдээлэл авах боломжтой болдог байна.

Сангийн яам аймгуудын ОНХС-гийн төлөвлөгөө болон санхүүжилтыг сар бүрээр гаргадаг бол аймаг бүр сумдаа хуваарилсан ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөгөө болон санхүүжилтийг мөн сар бүрээр, харин аймаг болон сумд нь аймаг, сумдад хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг цаг тухайд нь оруулдаг ажээ.

Системд Сангийн яам буюу админ, Аймаг, нийслэл, сум, дүүрэг гэсэн үндсэн гурван төрийн хэрэглэгч ажилладаг.

Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн системээс дараах мэдээллүүдийг авч болно.

Үүнд, ОНХС-гийн орлогын шилжүүлгийн мэдээлэл. Энэ нь Сангийн яамнаас аймаг, нийслэлд олгосон хөрөнгө, аймаг, нийслэлээс сум, дүүрэг олгосон хөрөнгө төлөвлөгөө, гүйцэтгэлээрээ уг мэдээллийн системд байрших болжээ.

Түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын ажлын талаарх бүх мэдээлэл орон нутгийн иргэдэд нээлттэй болсон байна. Тухайлбал, ажлын нэр, хүчин чадал, байршил, төсөвт өртөг, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний үнийн дүн, тухайн оны төлөвлөгөө, олгосон санхүүжилтийн дүн, иргэдийн санал авсан хэлбэр /цахим хуудсаар, бичгээр, санал асуулгаар гм/, иргэдийн саналын тоо, тендер зарласан огноо, гэрээ байгуулсан болон гэрээ дуусгавар болох хугацаа, төлбөрийн дүн, төлбөр төлсөн огноо, төлбөрийн агуулга, ажлын явц, гүйцэтгэлийн үр дүнг харуулсан зураг, иргэдийн хурлын шийдвэрийн дугаар

зэргийг энэхүү мэдээллийн системийг ашиглан авч болох юм.

Үүнээс гадна Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл, сангийн үлдэгдлийн дүн, иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын дүн зэрэг нь уг мэдээллийн санд хадгалагддаг байна.

Мэдээллийн системд нэвтрэх хаяг буюу системийн домайн нэр нь **tusuv-oronnutag.mn** бөгөөд үүнийг **zasag.mn**-тэй холбосон ажээ. Интернэтэд байнга холбогдох боломжгүй иргэдийн хувьд сангийн мэдээллийг “хэвлэх” товч ашиглан А4 хэмжээний цаасан дээр буулгаж авч болно. Мөн сум дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчлэн байршуулж байхыг Сангийн яамнаас тусгайлан зааварчилж үүрэг болгосон юм байна.

### **Мөнгөний бас мэдээллийн сан**

Сангийн сайдын 2014 оны гуравдугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар тушаалаар Орон нутгийн хөгжлийн сангийн зааврыг баталж, тус сангийн мэдээллийн системд хэрхэн бүртгэл, хяналт, санхүүжилт, тайлагналтын үйл ажиллагааг тусгахыг зохицуулжээ.

Түүнчлэн, Сангийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний 3.8-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн системд оруулах ажлыг зохион байгуулж, сангийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн явц байдалд иргэд, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлнэ” гэж, мөн гэрээний 4.3-т “Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийн системд оруулах мэдээллийг бүрэн оруулсны дараа Орон нутгийн хөгжлийн сангаас аймаг, нийслэлд олгох орлогын шилжүүлгийг орлогын эх үүсвэртэй нь уялдуулан сар бүр шилжүүлнэ” гэж тусгасан байна.


Энэхүү гэрээний дагуу аймаг, нийслэлийг холбогдох мэдээллээ бүрэн оруулсны дараа Сангийн яамнаас олгосон орлогын шилжүүлгийн дүнг, сум, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн төрийн сан дахь дансны үлдэгдэлтэй тулгасны үндсэн дээр санхүүжилтийг нь олгож байгаа аж. Мэдээллийн системд цаг тухай бүр холбогдох мэдээллээ бүрэн оруулж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт Сангийн сайдын албан тоотыг жил бүр илгээж байгаа гэнэ. Ийнхүү орон нутгийн иргэд өөрсдийн амьдарч байгаа орчноо сайжруулахад зориулагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжихээс нь өмнө саналаа нээлттэй өгөхөөс гадна ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлэлтэй болж эхэлжээ.

Уг сангийн хөрөнгийн зарцуулалтад иргэд хяналт тавих эрхтэй. Засаг дарга нар иргэдийг мэдээллээр хангах үүрэгтэй. Иргэд ОНХС-гийн талаарх мэдээллийг авснаар сангийн үлдэгдэл хөрөнгө, хэмнэлт зэргийг хянах боломжтой болж байгаагаас гадна энэхүү сангаа арвижуулах талаар санал бодлоо илэрхийлж болно. ОНХС-гийн хөрөнгийг зөв зүйтэй, оновчтой зүйлд зарцуулж хэмнэлт гаргаж чадах юм бол уг үлдэгдэл хөрөнгийг улсын төсөвт эргүүлэн таталгүй санд нь үлдээдэг.

Энэ нь арвижсаар тухайн орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах бүтээн байгуулалтын ажилд зарцуулагдах хуримтлал үүсэх боломжтой. Мэдээлэлтэй иргэд хүчирхэг гэдгийн учир энэ. Мэдээллийг баялаг болгож болдгийг ч бас энэхүү ОНХС-гийн мэдээллийн систем харуулж байна.

### **Холбоо барих:**

Сангийн яам.Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн хэлтэс  
Улаанбаатар хот - 15160 Чингэлтэй дүүрэг.С.Данзангийн гудамж 5/1,  
Засгийн газрын 2 дугаар байр  
Утас:264237,267207



## ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САН

**САЙН ТУРШЛАГА:** Хөдөлмөрийн яамны харьяа Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан нь дотоодын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн төр засгийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Энэ үйл ажиллагааны хүрээнд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгож буй зээл, эх үүсвэрийн зарцуулалт, төслийн сонгон шалгаруулалтыг ил тод болгосон нь Авлигатай тэмцэх газраас “Авлигаас ангид, сайн засаглалын туршлага-2013” өргөмжлөл хүртсэн байна.

## ШИЛЭН ДАНСТАЙ ЖИЖИГ ДУНДЫНХАН

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан анх 1994 онд АНУ-ын ард түмний хандив тусламжаар үүсэн байгуулагдсан байна. Зах зээлийн эдийн засагт дөнгөж хөл тавиад байсан монголчуудад жижиг дунд үйлдвэр эрхлэхэд нь тусалж санхүүгийн дэмжлэг туслалцаа олгохыг тухайн үед АНУ-ын Засгийн газар чухал гэж үзсэн хэрэг. Энэ сан ч шилжилтийн он жилүүдэд үр дүнгээ өгч олон арван жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг хөл дээрээ босоход дэмжлэг үзүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас уг сангийн үйл ажиллагааг дэмжин, зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой хэмжээнд шийдэх болсон байна.

Анх Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох нийт зээлийн хэмжээ тун бага байв. Улсын хэмжээнд жилд нэг тэрбум төгрөгийн зээлийг олгодог

байсан үе саяхан. Жилээс жилд энэ хэмжээ нэмэгдсээр 2009 он гэхэд 30 тэрбумд хүрчээ.

Өнөөдөр уг хэмжээ гурав дахин нэмэгдэж жилд 100 орчим тэрбум төгрөгийг жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд олгож байгаа ажээ. Тус сангаас олгох нийт санхүүжилтын хэмжээ нэмэгдэхийн хэрээр төслийн сонгон шалгаруулалт, зээл олголт зэргийг олон нийт илүүтэй сонирхох болсон байна.

Зээлд хамрагдах гэсэн иргэд, аж ахуйн нэгжүүдийн тоо ч нэмэгдэж. Тэр хэрээр өрсөлдөөн бий болсон байна. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж бүхэнд хүрч ажиллаж, тэднийг мэдээллээр хангана гэвэл тус сангийн ажилтнуудын цаг зав, бололцоо хаанаа ч хүрэхгүй. Тиймээс Хөдөлмөрийн яамны дэргэдэх Жижиг

дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан өөрсдийн бүхий л үйл ажиллагаа, үйлчилгээ болон үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээлийн эх үүсвэрийн зарцуулалт, төслийн сонгон шалгаруулалт зэргийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж байх тогтолцоог бий болгожээ.



***Энэ ажлынх нь талаар Хөдөлмөрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал Б.Баттүвшинтэй ярилцлаа.***

**-Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа. Аж ахуйн нэгжүүдэд дээд тал нь хэдэн сая төгрөгийн зээл олгож байгаа вэ?**

-Өмнө нь нэг аж ахуйн нэгжид олгох зээлийн дээд хэмжээ гэж байгаагүй. Манай сан Хөдөлмөрийн сайдын мэдэлд, Хөдөлмөрийн яамны харьяанд ирээд энэ дээд хэмжээг тогтоосон. Тэгэхгүй бол тухайн жилийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг цөөхөн хэдэн компани хуваагаад авчих магадлалтай. Тиймээс нэг аж ахуйн нэгжид олгох зээлийн дээд хэмжээг тогтоосноор Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох зээл олон нийтэд хүртээлтэй болсон. Одоогоор зээл олгох дээд хэмжээ 2 тэрбум төгрөг байгаа.

**-Хэдэн жилийн өмнө жижиг дунд**

**үйлдвэр гэсэн ангилалд багтахгааргүй "Гачуурт" зэрэг том компаниуд танай сангаас зээл авсан гэдэг нь тогтоогдож байсан. Одоо ийм байдал арилсан уу?**

-Тийм зөрчил илэрч байсан. Одоо бол өөр болсон. Бүх мэдээлэл ил тод, нээлттэй.

**-Иргэд мэдээлэл бага учраас харддаг. Танай Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан ил тод байдлыг сайн хангасан туршлагаараа ижил төрлийн бусад сан болон төрийн байгууллагуудад үлгэр жишээ болж байгаа. Энэ ажлынхаа талаар тодруулна уу?**

-Аливаа юмыг чимээгүй хийх, нууж хийх, хүнд харагдуулахгүй байх гэдэг өөрөө хардалт дагуулдаг. Дээрээс нь муу юм руу, буруу зүйл рүү, таагүй жишиг рүү тухайн байгууллагад ажиллагсдыг түлхдэг.

Бүх юм нээлттэй байх нь ажиллаж байгаа хүмүүстээ амар шүү дээ. Ажлаа бүтээх гэж яваа иргэд, ААН-ийнхэнд ч амар. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд энэ жил тэдэн төгрөг төвлөрсөн байна. Түүнийг ийм ийм компаниудад өгсөн гээд л бүх мэдээллийг цахим хуудаснаас харчихна. Эсвэл бүгд жагсч зогсоод л, шалгаруулалтад ороод авч чадах нь аваад чадахгүй нь үлддэг. Тэр бүхэнд нуугаад байх юм байхгүй.

**-Нэг аж ахуйн нэгжид дээд тал нь 2 тэрбум төгрөгийн зээл олгоно гэдэг бол их том тоо. Их мөнгө гэдэг эрсдэл дагуулна. Мэдээллийг ил тод болгоход энэ талаас нь, зээлдэгчийн аюулгүй байдлыг хангах асуудлыг тооцсон уу?**

-Болгоомжлох асуудал бол энэ байсан. Сангаас зээл авна гэдэг нэг хэрэг. Зохих хэмжээгээр хөрөнгө мөнгөтэй холбоотой учир хувь хүний нууц гэж байна. Банкны хууль талаас нь аваад үзсэн ч нэг хүн зээл авсан байхад түүний аюулгүй байдлын асуудал хөндөгдөнө. Тиймээс Жижиг дунд үйлдвэрийг



хөгжүүлэх сангийн бүх мэдээллийг ил тод болгоход зээлдэгчдэд ямар эрсдэл үүсч болзошгүй вэ гэдгийг бид судалсан. Энэ тал дээр би болгоомжилж байсан. Тэгээд зээлдэгчидтэйгээ зөвшилцөх нь зөв юм байна гэж үзсэн. Харин жижиг дунд үйлдвэр эрхлэгчид, зээлдэгчид маань бидний саналыг их сайхан хүлээж авсан. Ер нь энэ сангийн зээлийн зарцуулалт, сонгон шалгаруулалтыг ил болгох нь зөв юм байна гэдэгтэй тэд санал нэгтэй байсан. Тиймээс төрөөс Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаар дамжуулан хийж байгаа энэ хөрөнгө оруулалтыг ил болгох нь айдасгүй, аюулгүй гэж бид үзсэн.

**-Сангийнхаа үйл ажиллагааг байнга мэдээлж байхын тулд хэр зардал гаргаж байна вэ?**

-Нэг их биш ээ. Бид өдөр бүр шийдвэрлэж байгаа асуудлуудаа л цахим хуудсан дээрээ тавиад байгаа. Энэ бол төрийн байгууллага, төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байгаа байгууллагын хувьд хийх ёстой л ажил. Манай сангийнхны хувьд ил тод байдлыг хангаж үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг интернэтэд байршуулна гэдэг өдөр тутмын ажил болсон. Архангай аймгийн Цэнхэр суманд нэг эсгийний үйлдвэр зээл авсан бол бид тэр мэдээллийг дор нь цахим хуудсандаа оруулах жишээтэй.

**-Тэгвэл бусад ийм сангууд танай энэ сайн туршлагыг аваад үйл ажиллагааны мэдээллээ нээлттэй болгох боломжтой юм байна?**

-Тийм боломж байгаа. Яваандаа бүх төрийн байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод болох байлгүй. Энэ бол хөгжлийн үндэс шүү дээ.

**-2014 онд танай сан хэчнээн тэрбум төгрөгийн санхүүжилт авч жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд хуваарилав?**

-2014 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд 100 тэрбум төгрөг

төвлөрүүлсэн. Үүнээс 28.8 тэрбум төгрөгийг хөдөө орон нутаг, аймаг, дүүргүүдэд өгсөн. 71.2 тэрбумыг нь экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр шалгаруулсан төслүүдэд олгосон. Энэ нь импортыг орлох 888 төсөл гэж байгаа. Энэ шугамаар шалгарсан төслүүдэд бид зээл олгоод байна.

**-Төслийн сонгон шалгаруулалт болон зээлийн зарцуулалт, эргэн төлөлт зэрэгтэй холбоотой санал гомдол иргэдээс хэр ирдэг вэ?**

-Манай мэдээллийг үзчихээд эргээд санал хүсэлт тавьдаг. Гомдол, санал, шүүмжлэл, талархал бүгд л бидэнд ирдэг. Амьдрал сайнтай, муутайгаа сав дүүрдэг хойно. Гэхдээ гомдол, шүүмжлэл харьцангуй цөөн ирдэг. Бид юм хийх гээд байгаа хүнд л энэ зээлийг аль болох хүргэхсэн гэж боддог. Тийм хүмүүс зээл авч чадвал төрийн үйлчилгээ зөв газартаа очлоо гэсэн үг.

**-Зээлийн эргэн төлөлт хэр байна вэ?**

-Манай сангийн зээлдэгчид маш найдвартай. Татвар төлөгчдийн мөнгө баталгаатай эзэддээ очсон гэж хэлж болно. Зээлийн эргэн төлөлтийг банк хариуцдаг. Манайхаас шууд өгдөг жижиг зээл бас байдаг. Гэхдээ бид зээлээ аль болох банкаар дамжуулан олгохыг хичээдэг.

**-Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар цаашид ямар ажил төлөвлөж байна вэ?**

-Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн мэдээллийг олон нийт нээлттэй авдаг, шинэ мэдээллийг нь хүлээдэг ийм жишиг тогтчихлоо. Сангийн хувьд цаашид ард иргэд, ААН, компани, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бүх мэдээллээ ил тод, нээлттэй байлгана. Өнөөдөр хүрсэн энэ түвшингээ ахиулж, ил тод байдлаа улам чанаржуулна. Гол юмаа бол хийчихсэн гэж ойлгож байна. Ил тод байдлыг хангах ажлыг орон нутгийн сүлжээгээрээ дамжуулан хийнэ

гэж төлөвлөж байгаа. Жишээлбэл, бүх аймагт манай Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн хэлтсүүд байгаа. Тэдгээр хэлтсүүд аймгийн хэмжээнд хэдэн төгрөгийн зээл жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр хуваарилагдан, түүнийг хэрхэн зарцуулсан, ямар аж ахуйн нэгжүүд ямар шалгуураар уг зээлд хамрагдав гэдгийг ил тод зарладаг байх ёстой. Энэ ажлыг бид ойрын үед хийж хэрэгжүүлнэ.

Дүгнэлт: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийнхан ийнхүү өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгосон нь сайн засаглалын төлөөх сайн туршлагаар шалгарчээ.

Тус сангийнхны туршлагад үндэслээд дүгнэхэд нэг талаас мэдээллээ тогтмол шинэчилж байх, нөгөө талаар олон нийтэд хүргэх мэдээллээ төрөлжүүлэн ангилж, гол, чухал гэснийгээ нийтэлж байх нь иргэдийн хувьд хэрэгтэй мэдээллээ хайхад дөхөмтэй болж өгөх давуу талтай ажээ. Түүнчлэн хэрэглэгчид, үйлчлүүлэгдийнхээ хүрээг өргөжүүлэх чиглэлээр анхаарч, хөдөө орон нутгийн интернэт хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой санаачилга гаргах боломж ч бий.

Хүн бүхэн гар утсаараа интернэтэд холбогдох боломжийн аймаг, сумдын төвд бий болгох юм бол төрийн байгууллагуудын цахим мэдээллүүдийг цаг тухайд нь хүлээн авах болно. Энэ бол өнөөдөр тийм ч хүндрэлтэй асуудал биш. Энэ мэтээр иргэдийн интернэтийн хэрэглээг өргөжүүлэн, энэ талын боловсролыг нэмэгдүүлэх юм бол Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийнхны сайн туршлага аль ч салбарт үр дүнгээ өгөх болно.

### **Холбоо барих:**

Б.Баттүвшин Хөдөлмөрийн яамны Жижиг дунд  
үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал  
Утас: 99119717

Хаяг: Улаанбаатар хот-210349, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө-16  
Засгийн газрын IX байр,



## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ГАДААДАД ЗОРЧИХ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

**САЙН ТУРШЛАГА:** Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, түргэн шуурхай хүргэх, үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг багасгах зорилгоор 2014 оны нэгдүгээр сард Улсын Бүртгэлийн Ерөнхий газар, Монгол шуудан ТӨХК, Голомт банк хамтран үндэсний энгийн гадаад паспортыг иргэний өөрийн хүссэн баталгаат, буухиа шуудангаар дамжуулан хаягаар нь гараас гарт хүргэх ажлыг зохион байгуулахаар гурван талт гэрээ байгуулж, энэ үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байна.

## “ГЭРТ ХҮРГЭЭД ӨГЧИХӨӨРЭЙ”

...“Зуун айл руу” явж бичиг баримт хөөцөлдөнө гэдэг нэг их хүсээд байх ажил биш. Бөөн түгжээн дунд уур уцаараа барсаар, очоод хаана хэнд хандахаа мэдэх гэж будилсаар арай хийж учраа олтол, бөөн дараалал.

За тэгээд тэдийд ир, төдийд ир гэнэ. Эргэж ирж бичиг баримтаа авч, буцах гэсээр мунгинаж хайран цагаа бардаг даа. Хөдөөнөөс ирсэн бол бичиг баримтаа автлаа наад тал нь гурав хоног хүлээх ч хэрэг гарна. УБЕГ, Монгол шуудан ТӨХК, Голомт банк хамтран үндэсний энгийн гадаад паспортыг гараас гарт хүргэх баталгаат, буухиа шуудангийн гурвалсан үйлчилгээг нэвтрүүлжээ. Гадаад паспортын үйлчилгээний танхимд байрлах хүлээн авах цонхны нэгэнд нь Монгол шуудан ТӨХК-ийн итгэмжлэгдсэн ажилтан ажиллаж байна.

Тэрбээр үйлчилгээний талаарх нөхцлийг тусгасан баримтад паспортаа хаягаараа авахыг хүссэн нэгэн иргэнээр гарын үсэг зуруулж, гадаад паспортын мэдүүлэгт бар код нааж, шуудангаар хүргүүлэх хаягийг дугтуйд хийж байв.



**Шинэ нэвтрүүлсэн үйлчилгээний талаар тодруулахаар Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн хэлтсийн дарга Л.Энхбаяртай ярилцлаа.**

**-Зуун айл руу олон дахин ирнэ гэдэг үнэндээ хэцүү шүү. Үйлчлүүлэгчид гомдол их гаргадаг уу?**

- Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын үйлчилгээний байрууд “Зуун айл” дахь худалдаа, үйлчилгээний хэт ачаалал, төвлөрөлтэй газар байрладаг, мөн замын түгжрэлээс болоод энд ирэх гэж хүмүүс маш их цаг алддаг. Ирээд дараалалд зогсоно. Дараа нь буцаж ирж, бичиг баримтаа авах гэж бас их цаг хугацаа алддаг. Үүнээс үүдэлтэй иргэдийн бухимдал, санал гомдол гардаг тохиолдлууд цөөнгүй байсан.

**-Буухиа шуудангийн шинэ үйлчилгээ нэвтрээд байдал ямар болов доо?**

-Энэ байдлыг бага ч болов халах үүднээс Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, түргэн шуурхай хүргэх, үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг багасгах зорилгоор 2014

оны нэгдүгээр сард Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар, Монгол шуудан ТӨХК, Голомт банк хамтран үндэсний энгийн гадаад паспортыг иргэний өөрийн хүсэлтээр баталгаат, буухиа шуудангаар дамжуулан хүссэн хаягаар нь гараас гарт хүргэх ажлыг зохион байгуулахаар гурван талт гэрээ байгуулж, энэ үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байна.

Иргэний баримт бичгийг гараас гарт хүргэх үйлчилгээ нь нийслэлийн бүх дүүрэгт байршил харгалзахгүй 24 цагийн дотор хүргэгдэж байгаа.

Харин орон нутагт 72 цагийн дотор хаяг, байршлаар нь хүргэх юм. Үйлчилгээ нэвтрүүлсэн энэ хугацаанд 3200 гаруй иргэн энэ үйлчилгээгээр үйлчлүүлсэн. Цаг зав, мөнгөө хэмнэх үүднээс энэ үйлчилгээг сонгох иргэдийн тоо сар бүр нэмэгдсээр байгаа.

Энэ үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд төдийгүй УБЕГ-ын албан хаагчдын ажлын ачааллыг ч тодорхой хувиар бууруулж, магадгүй төрийн байгууллагын хүнд суртлыг бага ч гэсэн багасгасан арга хэмжээ болсон гэж үзэж байна. Иргэд ирж, очих, дугаарлаж зогсох цаг заваа хэмнэж байна.

**-Иргэдэд бичиг баримтын хүргэлтийг хамгийн анх яаж шийдье гэж төлөвлөж байсан вэ?**

Бид судалгаа хийж энэ үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөсөн. Иргэдийн материалыг шууд цахим хэлбэрээр хүлээж аваад, эндээ хэвлээд, хэвлэсэн паспортыг хаягаар нь хүргэж өгдөг больё, иргэдийг энд ирүүлж, чирэгдүүлэхгүй байя гэж анх төлөвлөж байсан.

**-Асуудлыг арай өөрөөр шийджээ?**

- Ингэвэл илүү шуурхай болно. Гэвч цахимаар илгээсэн тохиолдолд тухайн компьютерийн цаана ямар хүн байна, паспортын жинхэнэ эзэн мөн үү гэдгийг далдаас хянах боломжгүй учраас, аюулгүй байдлын үүднээс эрсдэл учруулахгүйн тулд иргэн бичиг





Зураг: Иргэний хурууны хэзгээр цахим бүртгэлийг баталгаажуулж байгаа нь.

баримтаа өөрийн биеэр авчирч бүртгүүлэх шаардлагатай гэж үзсэн.

Ирсэн иргэний хурууны хэзг программаар уншуулаад мэдээлэл нь автоматаар бүртгэгддэг болсон.

**-Одоогийн байдлаар энэ үйлчилгээг хэдэн аймагт нэвтрүүлээд байна вэ.Төлбөрийн талаар сонирхвол ?**

-Тухайн иргэн гадаад паспорт захиалчихаад өөрийн хүсэлтээр хүргэлтийн үйлчилгээг сонгосон бол хүргэлтийн үйлчилгээний хураамжийг төлнө. Тэгээд хүссэн хаягтаа хүлээж авах боломжтой.

Үйлчилгээний хөлс Улаанбаатарт 3500 төгрөг, Хөдөө орон нутагт бол хол ойр гэлтгүй бүх аймагт адилхан 5500 төгрөгийн хураамжтай. Шуудангаар хүргэх үйлчилгээний хураамжийг иргэдэд дарамт учруулахгүй байх зорилгоор аль болох бага байлгах шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Замын хүнд бичиг баримтаа дайдаг байсан цаг өнгөрч, баталгаат шуудангаар үйлчлүүлдэг болсноор илүү найдвартай болсон. Буух эзэнтэй, буцах хаягтай хариуцлага тооцох боломжтой гэсэн үг.

**-Хэрэв хүргэлт саатсан тохиолдолд хаана хандах вэ?**

-Энэ тохиолдолд шуудан лавлах буюу 1800-1613, Монгол шуудан компанийн 70078920, 70078913 тоот утсаар лавлах боломжтой юм. Үүнээс гадна [www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn) гэсэн цахим хуудсаар орж шуудангаа хаана явааг хянах, мэдээллээ шалгах боломжтой.

**-Буухиа шуудангаар гараас гарт хүргэх үед хаягийн эзэнд нь хүргэж чадаагүй тохиолдол гарч байв уу ?**

-Энэ үйлчилгээ эхэлсэн цагаасаа өнөөдрийг хүртэл үйлчилсэн 3200 иргэнээс нэг ч гомдол ирээгүй.

Мөн шуудангаар хүргэх үйлчилгээтэй холбоотой ирсэн өргөдөл, гомдол санал хүсэлтийг тодорхой хугацаагаар нэгтгэн Улсын бүртгэлийн байгууллагад танилцуулах үүрэгтэй.

Тайлангаа бидэнд тогтмол ирүүлдэг. Монгол шуудан ТӨХК гадаад паспортыг УБЕГ-аас хүлээн авснаас хойш иргэнд олгох хүртэлх хугацаанд бүрэн бүтэн байдлыг нь хариуцаж, гэмтээлгүйгээр иргэдэд олгох үүрэгтэй.

Монгол шуудан ТӨХК хүргэлтийн үйлчилгээн дээрээ гэрээний үүргээ сайн биелүүлж байгаа.

**-Баталгаат шуудангаар паспортаа авахыг хүсвэл ямар журмаар үйлчлүүлдэг вэ?**

- Иргэн бичиг баримтаа бүрдүүлээд өөрийн биеэр УБЕГ-т ирж, хурууны хээгээ уншуулна. Хурууны хээ уншуулдаг программыг нэвтрүүлснээр анкет бөглөж суудаг ажлыг халсан.

Ингээд хүсвэл паспортаа өөрийн хүссэн хаягаар буухиа шуудангаар хүлээн авч болно. Олгох хуудсаа Монгол шуудангийн УБЕГ дээрх салбарын ажилтанд төлбөрөө төлөөд үлдээдэг. Паспорт бэлэн болсны дараа бүртгэлийн ажилтан шууданд шилжүүлээд, шуудангаар дамжин эзэндээ 24-72 цагийн дотор хүрдэг.

**-УБЕГ-ийн бүртгэлийн нэг ажилтанд өдөрт дунджаар хэдэн үйлчлүүлэгч ноогдож байна. Ажлын ачаалал ямар байдаг вэ?**

- УБЕГ байнгын ачаалалтай байдаг. Тэр дундаа зун, намрын улиралд иргэдийн гадаадад аялах оргил үе таардаг учраас их ачаалалтай үед өдөрт 1500 орчим хүнд гадаад паспорт олголт хийдэг. Энэ нь нэг бүртгэгчид өдөрт 100 орчим хүн ноогдож байна гэсэн үг.

Оргил ачаалалтай үед цагаа сунган ажиллахаас өөр аргагүй үе бий. Гэхдээ илүү цагийн хөлс ажилтнуудад маань олгогддоггүй. Хүмүүс бухимдаад зогсчихдог. Гадаад паспорт авахаар ирж байгаа иргэд голчлон яарсан сандарсан, гадагшаа явах цаг хугацаа нь тулчихсан байдаг.

Иргэд паспортын хугацаагаа дууссанаа мэдсэн байсан ч, тоолгүй байж байгаад, хаа нэг тийшээ гэнэтхэн явахаар болж, визэнд орохынхоо өмнөхөн л сунгуулахаар яарч,сандардаг. Цагийг нь тулгаж ирээд сандарсан хүмүүсийн дарааллаар дүүрчихдэг гэмээр юм уу.

**-Иргэний бүртгэл дээр бичиг баримтаа хурдан гаргуулж авахаар ирсэн хүмүүс "арын хаалга" хайгаад давхичихдаг тал ажиглагддаг байсан.**

-Паспорт бичиг баримтаа яаралтай гаргуулж авахын тулд хүмүүс ирчихээд, хэнд хэлбэл болох билээ, хэнтэй уулзвал бүтэх билээ гэж бодоод ийш тийш ярьж, таньдаг хүнээ хайж давхисаар бараг бүртгүүлээд авчих цагаа алддаг.

Яаралтай сунгалт хоёр, ба дөрвөн цагийн дотор гардаг болчихсон шүү дээ. Шинээр гадаад паспорт авахад энгийнээр 10 хоногт, яаралтай бол нэмэлт төлбөр төлөөд гурав хоног, паспортын хугацаа сунгахад ажлын найман цагийн дотор хийгддэг. Орон нутагт гадаад паспортыг долоо хоногийн дотор бүртгэлийг хийгээд олгодог болсон.

**-Ер нь ингэхэд гадаад паспортын шинэ олголт нь яагаад гурав ба 10 хоног, сунгалт хоёр, дөрөв, найман цагийн дотор гэсэн ялгаатай байдаг вэ. Энийг хүмүүс хүнд суртал ч гэдэг юм уу буруугаар ойлгох тал бий юу ?**

-Цаг хугацааны хувьд бид санаанаасаа зохиосон юм биш ээ. Хэвлэх үйлдвэрийн ачаалал, ажлын тоног төхөөрөмж нөөц бололцоо, ажлын ачаалал зэргээс шалтгаалж наад зах нь ажлын гурав хоногт гарна гэж тооцоолсон. Бүх хүний бичиг баримтыг өдөрт нь хурдан гаргаж өгнө гэдэг одоогийн байдлаар маш хэцүү.

Иргэдээс хүлээж авсан материалаа дахин шалгаж, хянана. Бүртгэнэ. Хэвлэнэ. Хэвлэсний дараа ялгана, баталгаажуулна. Ийм дарааллаар явдаг.

Зарим улсад, тухайлбал ОХУ-д шинэ паспорт захиалахад сарын хугацаа ордог. АНУ, Канадад ч мөн адил юм билээ. Манай улсын хувьд бусад орныг бодвол харьцангуй хурдандаа ордог.



**-Тийм үү, манайд бол сар байтугай гурав хоногт олгоно гэдэг урт хугацаа санагддаг. Ялангуяа яарсан үед?**

- Тийм шүү. Ажлын гурван хоногт яаралтай паспорт гарна гэхэд тэрнээс хурдан гарах тал байна уу гэж лавладаг шүү. Гадаад паспорт үйлдвэрээс өдөртөө хоёр удаа ирдэг. Нэг удаа ирэхдээ 500-1000 орчим гадаад паспортыг хэвлэн авчирдаг. Тухайн паспортуудыг ангилан ялгаж, гарын үсэг зурахад гурван цаг орчим хугацаа зарцуулдаг.

Шуудангаар аль болох хурдан хүргэхийн тулд шуудангаар хүргэгдэх паспортуудыг түрүүлж ялган гарын үсэг зуруулж баталгаажуулах, үйлдвэр рүү явуулахдаа тусад нь ялган хүлээлгэн өгөх зэргээр шийдвэрлэж байна.



**-Энэ хугацааг илүү хурдавчлах арга зам бий юу?**

-Илүү хурдавчлахын тулд улс даяар нэгдсэн цахим бүртгэлтэй байх юм бол энэ хугацааг нааш татах боломжтой. Бид иргэдээс материалыг нь хүлээж аваад шалгаад, хэвлэх үйлдвэр рүү тээврийн хэрэгслээр хүргүүлдэг.

Эргүүлээд мөн тээврийн хэрэгслээр татаж авдаг. Үүнийг эндээс бид өгөгдлийг нь цахимаар дамжуулаад өгчихдөг болчихвол ажил илүү хурдавчлах боломж бий.

**-Энэ туршлагаас ямар санаа авсан бэ. Цаашид ямар үйлчилгээг нэвтрүүлэхээр зэхэж байна вэ?**

-Эд хөрөнгийн улсын бүртгэлийн үйлчилгээ дүүргүүдэд шилжсэн. Дүүргийн бүртгэлийн газруудад шуудангийн салбарыг байршуулаад шуудангаар дамжуулж авах боломжийг гаргаж өгөх боломжтой.

Цаашид Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, цахим үнэмлэх зэрэг олон төрлийн бичиг баримтыг Монгол шуудан ТӨХК-ийн үйлчилгээгээр иргэний хүсэлтийн дагуу хаягаар нь хүргэхээр төлөвлөж байна.

Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр иргэдийн цаг завьг хэмнэх болсонд үйлчлүүлэгчдийн зүгээс ам сайтай байгаа. Гадаад паспортыг заавал өөрийн биеэр захиалах боловч авахын тулд ажил, цагаа бараад байх шаардлагагүй болсонд үүний давуу тал болж байгаа юм.

***Монгол шуудан ТӨХК-ийн ажилтан Б.Батчимэгтэй ярилцвал:***

-Манай үйлчилгээний талаар хүмүүс ам сайтай байгаа. Үйлчлүүлэгчид өөрсдийн цаг зав, такси унааныхаа мөнгөө ч хэмнэх юм байна гэж таатай хүлээж авдаг. Ялангуяа хөдөө орон нутагт өдөр бүр хүргэлт хийгддэг учраас иргэд дуртай байдаг.

Цаг хугацааны хувьд тухайн өдрийн 11 цагаас өмнө Монгол шуудан ТӨХК-ийн итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэн өгснөөр шууданг өдөртөө, 11 цагаас хойш хүлээн авсан шууданг маргааш өдрийн 11 цагаас өмнө тухайн паспорт тэр өдөртөө иргэдэд очих боломжтой.

Иргэний бүртгэлийнхэн ч бидний ажлыг их дэмждэг.

Үндэсний энгийн гадаад паспорт нь Монгол улсын төрийн өмч тул бүрэн бүтэн байдлыг нь сайтар ханган гэмтээлгүйгээр иргэдэд олгох, гадаад паспортыг иргэдэд хүргэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууц, хувь хүний талаарх мэдээллийг бусдад задруулахгүй байхад анхаарч ажиллах үүрэгтэй хариуцлагатай ажил.



Энэ үйлчилгээний талаарх сурталчилгаан дээр анхаарах хэрэгтэй байгаа. Энэ ажлыг манайх хариуцдаг л даа. Энийг л илүү эрчимжүүлвэл үйлчлүүлэх хүмүүсийн тоо ч нэмэгдэнэ.

**Иргэдийн сэтгэгдлийг сонсохоор Иргэн Д.Пүрэвжаргалтай уулзлаа.**

-Би өмнө нь зуун айл руу ирж, очих бичиг баримтаа бүрдүүлж авах гэж лав хоёр өдрийн ажлаа алддаг байсан. Унаа унаш, дараалалд зогссоноо бол ярих ч юм биш. Харин өнөөдөр ирээд баталгаат шуудангаар паспортаа хүлээж авдаг болсныг дуулаад үйлчлүүлэх гээд зогсож байна. Эргэж ирэхгүй амар юм байна хэмээн өгүүлсэн юм.

**Лавлагаа холбоос:**

<http://www.burtgel.mn/>  
[www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn)

**Холбоо барих:**

**Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар.  
Гадаадад зорчих эрхийн  
бүртгэлийн хэлтэс**

Бүртгэлийн лавлах:1800-1890, 70114596

Факс:976-11-350072

Электрон шуудан:

contact@registrationmongolia.com

Хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг Цагдаагийн гудамж.

Улсын бүртгэлийн ерөнхий газар.

Үйлчилгээний I байр

**Монгол шуудан ТӨХК**

Утас: 70078920, 70078913

Лавлах 1800-1613





## УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

**САЙН ТУРШЛАГА:** Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Цагдаагийн байгууллагад өгөх өргөдөл, гомдлыг цахим хэлбэрт оруулах, иргэд өөрийн өгсөн өргөдөл, гомдлын явц, шийдвэрлэлтийн үр дүнг интернэтийн орчинд хянах бололцоог хангах зорилгоор “SMART POLICE” буюу “Ухаалаг Цагдаа” цахим өргөдөл, гомдлын нэгдсэн системийг шинээр ашиглалтад оруулжээ.


## ӨРГӨДЛӨӨ “УХААЛАГ ЦАГДАА”-Д ӨГЧИХЬЕ

**Ж**илийн өмнө охин маань сургуулийнхаа үүдэнд утсаа алдчихаад уйлаад, найзууд нь дагуулаад сургуулийн ойролцоох хэсгийн цагдаагийн байранд очоод цоожтой хаалгыг нь мөргөсөн юмдаг.

Долоо хоногийн дараа дахиад л утсаа алдсан гэсэн уравгар юм ороод ирсэн тул хэсгийн цагдааг зорьж уулзлаа. Та дүүргийн цагдаагийн газрын “тэр” мөрдөгчтэй уулзсан дээр байх аа гээд утсыг нь өглөө. Мөнөөх утас руу хоёр гурван удаа залгаад хэдийд уулзах боломж байгааг лавласан ч завгүй байна, гадуур явж байна гэсэн хариулт хөвөрсөөр. Тэгсгээд энэ явдал замхарлаа. Би ч энэ тухай мартчихаж.

Саяхан санамсаргүйгээр НЦГ-ын цахим хуудаснаа “Ухаалаг цагдаа” нэртэй өргөдөл гомдол хүлээн авах тусгай хэсэгтэй болсныг хараад мөнөөх явдлаа

гэнэтхэн саналаа. Үүнийг мэдэж байсан бол аль эрт өргөдөл бичээд л илгээчихэд болох байжээ гэж.



Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Цагдаагийн байгууллагад өгөх өргөдөл, гомдлыг цахим хэлбэрт оруулах, иргэд өөрийн өгсөн өргөдөл, гомдлын явц, шийдвэрлэлтийн үр дүнг интернэтийн орчинд хянах бололцоог хангах зорилгоор “SMART POLICE” буюу “Ухаалаг Цагдаа” цахим өргөдөл, гомдлын нэгдсэн системийг

шинээр ашиглалтад оруулжээ. Энэхүү цахим системд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд дүүргүүд дэх Цагдаагийн хэлтсийн иргэд хүлээн авах хүлээлгийн танхимд байрлуулсан мэдрэгчтэй дэлгэцээр өөрийн биеэр очиж өргөдөл, гомдол өгөх, шийдвэрлэлтийн явцыг хянахаас гадна интернэтийн орчинд хаана байгаа газраасаа [www.smartpolice.mn](http://www.smartpolice.mn) буюу “Ухаалаг цагдаа” цахим хуудсаар дамжуулан хандах боломжтой аж.



***Ингээд энэ ажлыг санаачилсан Улаанбаатар хотын цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн цахим мэдээлэл хариуцсан мэргэжилтэн дэслэгч М.Зоригтбаатартай уулзлаа.***

**-Улаанбаатар хотын цагдаагийн газар “Ухаалаг цагдаа” өргөдөл гомдлын цахим программ нэвтрүүлснээр ажилд ямар өөрчлөлт гарав?**


-“Ухаалаг ЦАГДАА” Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн программыг

ажиллагаанд оруулсанаар иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг удирдлагын зүгээс хянах, мэдээ мэдээллийг түргэн хугацаанд харьяалалын дагуу шилжүүлэх, шийдвэрлэлтийн явцыг өргөдөл, гомдол хариуцсан алба хаагч тэмдэглэж, өргөдөл, гомдол гаргасан иргэнийг мэдээллээр хангах, иргэд гар утаснаасаа ч гэсэн интернетэд холбогдон өргөдөл, гомдол өгөх, шийдвэрлэлтийн явц, үр дүнг харах боломжтой болсон. Өргөдөл, гомдлын хугацаа оруулсан өдрөөсөө автоматаар тоологдох тул хугацаа алдахгүй.

Мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай хүргэх, иргэдээс цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой мэдээ, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн талаар өргөдөл, гомдлыг хүлээн авах цахим орчинг бий болгож өгсөнөөр иргэд цагдаагийн байгууллагад өргөдөл, гомдол өгөхөөр очиж хугацаа алдахгүй, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, үр дүнтэй холбоотой мэдээллийг интернэтийн орчинд хянах бололцоотой болсон.

Мөн байгууллагын албан ёсны олон нийтийн сүлжээ хуудсаар гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг цагдаагийн байгууллага хүлээн авч шалгахад тухайн өргөдөл, гомдол өгсөн иргэний мэдээлэл хуурамч, холбоо барихад хүндрэлтэй байдаг тул [www.smartpolice.mn](http://www.smartpolice.mn) цахим хуудсаар мэдээлэл авах нь илүү ач холбогдолтой болсон.





**-Иргэн Цагдаагийн газарт өргөдөл гаргахын тулд "далан булчирхайгаа" тоочих хэрэгтэй болдог. Тэр мэдээлэл нь цахимаар ил харагдах вий гэхээс эмээх явдалгүй гэсэн үг үү. Мэдээлэл өгсөн болон өргөдөл хүсэлтээ илгээсэн иргэний нууцлал, аюулгүй байдлыг яаж хангадаг вэ?**

-Гэр бүлийн хүчирхийлэл, хүчингийн хэрэг, болон байцаагчид тэр бүр нүүр тулж ярихаасаа санаа зовсон, цэрвэдэг асуудлаар болон цагдаагийн албан хаагчтай холбоотой өргөдөл гомдлыг иргэд цахим хуудсаар түлхүү өгдөг нь ажиглагдсан. Иргэдийн хувийн мэдээлэл, цагдаагийн байгууллагын өргөдөл гомдлын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалалтын өндөр түвшинд хийгдсэнээрээ энэхүү программ давуу талтай юм.

Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн программд иргэд интернэтийн орчинд [www.smartpolice.mn](http://www.smartpolice.mn) цахим хуудсанд хандан: электрон шуудангийн хаяг, нууц үг, төрсөн он сар, хүйс зэрэг үндсэн дөрвөн мэдээллийг үнэн зөв бөглөснөөр цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой мэдээ, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн талаар өргөдөл, гомдлыг цагдаагийн байгууллагад өгөх боломжтой юм.

**-Одоо өргөдөл гомдлын шийдвэрлэлт ямар түвшинд хүрсэн бэ?**

-Энэ үйл ажиллагаа нэвтэрснээр цагдаагийн байгууллагад бичгээр, амаар, утсан харилцаагаар, цахим хэлбэрээр ирсэн дуудлага мэдээлэл,

өргөдөл, гомдол тус бүр хяналтын хуудастай болсон.

Иргэд [www.smartpolice.mn](http://www.smartpolice.mn) "Ухаалаг цагдаа" цахим өргөдөл, гомдлын нэгдсэн программд нэвтрэн өөрийн өгсөн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, үр дүн хариуцан шалгаж буй цагдаагийн алба хаагчтай холбоотой мэдээллийг интернэтийн орчинд хүлээн авч харах, шийдвэрлэлтийн үр дүнг татах, хадгалах боломжтой.

Мөн энэхүү цахим өргөдөл, гомдлын нэгдсэн программ дээр түшиглэн цагдаагийн байгууллагад ирж буй дуудлага бүрийг хяналтын хуудастай болгож, хяналт тавих нөхцөл бүрдүүлсэн. Миний өргөдөл юу болсон бэ гэж энд ирж цагаа алдахгүй болсон гэсэн үг.

**-Ажилтнуудын ачаалал багасч чадсан уу, ямар нэг бэрхшээл учрав уу?**

-Энэхүү цахим өргөдөл, гомдлын системийг шинээр ажиллагаанд оруулсанаар цагдаагийн байгууллагын нэгдсэн дотоод сүлжээнд холбох, дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн мэдээлэл судалгааны ахлах байцаагчид өргөдөл, гомдлын нэгдсэн болон [www.smartpolice.mn](http://www.smartpolice.mn) программтай давхар ажиллах зэрэг хүндрэл гарсан.

Энэ хүндрэлүүдийг шийдэх, цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалалыг бууруулах зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл, судалгаа, технологийн төвтэй хамтран цагдаагийн байгууллагын нэгдсэн дотоод сүлжээтэй [www.smartpolice.mn](http://www.smartpolice.mn) цахим өргөдөл, гомдлын нэгдсэн программыг холбох чиглэлээр хамтран ажиллаж байна.

**-Программ шинээр ажилд оруулах ажлаа хэдийнээс төлөвлөж, эхэлсэн бэ?**

-2014 онд эхэлсэн. Программыг шинээр ажиллагаанд оруулахаас өмнө дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн мэдээлэл судалгааны ахлах байцаагчдын санал

хүсэлтийг авч, иргэд болон программыг ажиллуулах цагдаагийн алба хаагчид ашиглахад хялбар байдлаар шийдэж өгсөн.

Улаанбаатар хотын цагдаагийн газраас “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх” тухай хуулийн хэрэгжилтийг хангах, дүүргүүд дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн иргэд хүлээн авах хүлээлгийн танхимд байршуулсан мэдрэгчтэй дэлгэцийг бүрэн ажиллагаанд оруулах, программ хангамжийг хөгжүүлэх зорилгоор “Ухаалаг цагдаа” цахим өргөдөл, гомдлын нэгдсэн программыг шинээр ажиллагаанд оруулсан.

### **“Ухаалаг цагдаа” гол зорилгодоо хүрч чадсан гэж үздэг үү?**

Энэхүү “Ухаалаг цагдаа” цахим өргөдөл, гомдлын нэгдсэн программын зорилго нь цагдаагийн байгууллага, алба хаагчтай холбоотой мэдээ, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн талаарх өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр авах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд шуурхай хүргэх, ил тод байдлыг хангах зорилготой. Цаашид, дуудлага бүрийг бар кодтой болгохоор зорьж байна.

### **-Энэ ажлаа цаашид хэрхэн сайжруулж боловсронгуй болгох вэ, бусад орон нутгуудад энэ сүлжээгээ хэдийд нэвтрүүлэх вэ, төлөвлөж байгаа ажлынхаа талаар дурьдвал?**

-Энэхүү программыг хөгжүүлэх, цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, түргэн шуурхай болгох зорилгоор өргөдөл,

гомдол гаргасан иргэний гар утсанд хүлээн авсан шийдвэрлэлттэй холбоотой мэдээллийг мессэж хэлбэрээр хүргэх үйлчилгээг 2015 оны нэгдүгээр улиралд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

### **-“Ухаалаг цагдаад” энэ хугацаанд нийт хэчнээн иргэн өргөдөл, хүсэлтээ ирүүлэв. Шийдвэрлэсэн байдал нь...**

-2014 оны долдугаар сараас иргэдээс 100 гаруй өргөдөл гомдол хүлээн авч, харьяалалын дагуу шилжүүлсэн. Шийдвэрлэлт 75%-тай, үлдсэн нь шийдвэрлэлтийн шатандаа явж байна.

### **-Цахим өргөдөл хүлээж авахад учирдаг бэрхшээл?**

-Иргэдээс ирүүлсэн зарим өргөдөл, гомдлыг шалгахад гомдол гаргагч хувийн мэдээллээ худал бөглөсөн тохиолдолд өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шалгах ажиллагаанд хүндрэлтэй байдаг тул өргөдөл, гомдол гаргаж буй иргэд мэдээллээ үнэн зөв бөглөснөөр шийдвэрлэх ажиллагаанд саад учрахгүй гэдгийг зөвлөж байна.

**Лавлагаа холбоос:**  
[www.smartpolice.mn](http://www.smartpolice.mn)

### **Холбоо барих :**

М.Зоригтбаатар.Улаанбаатар хотын  
Цагдаагийн Газрын Урьдчилан  
сэргийлэх хэлтсийн цахим мэдээлэл  
хариуцсан мэргэжилтэн  
Утас: 89292400

Албаны лавлах: 94945490, 88221122,  
96167716, 93022510

Электрон шуудан: [ubpolice@gmail.com](mailto:ubpolice@gmail.com)

САЙН ЗАСАГЛАЛЫН ТӨЛӨӨХ  
САЙН ТҮРШЛАГА

УЛААНБААТАР ХОТ

---





## БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**САЙН ТУРШЛАГА:** 1992 оны наймдугаар сарын 18-ны өдрийн УИХ-ын 18-р тогтоолоор “Улаанбаатар хотын район, хороог татан буулгаж шинээр дүүрэг байгуулах тухай” шийдвэр гарснаар Багахангай дүүрэг засаг захиргааны хоёр хороотойгоор байгуулагджээ. Улаанбаатар хотоос 90 км зайд оршдог нийслэлийн алслагдсан дүүргүүдийн нэг юм. 2013 оны жилийн эцсээр 20199 толгой мал, 1065 өрхийн 3806 хүн ам тоологдсон.

Малчин өрх олонтой бөгөөд хүн ам нь дүүргийн нутаг дэвсгэрт тархан суурьшдаг онцлогтой. Тиймээс тус дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ”-г зохион байгуулдаг болсон нь төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэхэд чиглэсэн сайн туршлага болжээ.

## ОЛОН ХААЛГЫГ НЭГ ЦОНХ БОЛГОСОН НЬ

### Асуудлаар дүүрэн хотын хөдөө

Багахангай дүүрэг бол жинхэнэ бутгаараа хотын хөдөө. Улаанбаатар хотоос 90 километр алслагдсан тус дүүргийн хүн амын тоо нийслэлийн төвийн дундаж хорооны оршин суугчдаас ч цөөн. Харин нутаг дэвсгэрийн хэмжээ нь 14 мянган га.

Малчин өрхүүд нь дүүргийнхээ нутаг дэвсгэрт баригдалгүйгээр төвөөсөө 70 километр хүртэл хол газар нутагладаг байна. Үүнээс гадна Багахангай дүүргийн хүн амын 40 гаруй хувь нь төмөр замын өртөө, зөрлөг, замын хэсгүүдэд

аж төрдөг онцлогтой. Үндсэндээ тус дүүргийн хүн амын 50 гаруй хувь нь төр захиргааны байгууллага, суурьшлын бүсээсээ алс зайдуу таруу аж төрдөг гэсэн үг.

Ийм нөхцөлд иргэддээ төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэнэ гэдэг амаргүй. Зах хязгаарын буйдхан сумын төвд л ийм бэрхшээл хүндрэл тулгардаг.

Гэтэл нийслэл хотын нэг эд эс болсон алслагдсан дүүрэгт нүүдэлчин амьдралын хэв шинж хэвээр хадгалагдан үлдсэнээс үүдэн төв

суурин нь эзгүйдэн, иргэд нь төрийн үйлчилгээний гадна хоцрох болжээ. Хэн нэгэн даргаар албан бичигт гарын үсэг зуруулж, тамга даруулахын төлөө, эсвэл халуурч бүлээрсэн хүүхдэдээ эм авах гэж 10-20 бүр 50-60 километрын цаанаас дүүргийнхээ төвд ирнэ гэдэг цаг, мөнгө хоёрт халгаатай. Тэтгэврийн хэдэн төгрөгөө авахаар 70 километр холоос ирсэн малчин өвгөн замын унааны хөлс, бензин шатахуун, хоол ундандаа авсан мөнгөнийхөө бараг тэн хагасыг зарцуулчихаад буцах нь энүүхэнд.

Өөр нэг хүндрэл нь Багахангайнхан Улаанбаатар-Сайншанд, Улаанбаатар-Багануурын чиглэлийн суудлын галт тэргээр гол төлөв зорчдог. Ингэсэн тохиолдолд галт тэрэгнээс буугаад дүүргийн төв хүртэл зургаан км газар явган алхдаг байна. Ийнхүү зорьж ирээд төрийн үйлчилгээ авахын тулд олон байгууллагын хаалга онголзуулж, албан тушаалтны өрөөний үүдэнд цаг заваа үрэн дугаарлана. Энэ мэтээр хотын хөдөө хүндрэлтэй асуудлаар дүүрэн...

Хүнд суртлын энэ тогтолцоог халж, төвөөс алслагдмал аж төрдөг хүн амынхаа талаас илүү хувьд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэхийн тулд Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газраас "Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ"-г эдүгээгээс таван жилийн өмнө буюу 2009 оноос эхлэн нэвтрүүлжээ.

Иргэд төрийн үйлчилгээ авахаар олон хаалганы гадна дараалалд зогсож, ажлын 2-3 өдөр буюу 16-32 цаг зарцуулдаг байсан бол "Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ"-ний багийн хамт олон суурин, тосгон, айл өрх, иргэн бүрт хүрч нэг хаалгаар нэг цэгээс богино хугацаанд олон төрлийн үйлчилгээг хүргэх болсон байна. Ийнхүү Багахангай дүүргийн төр захиргааны байгууллагынхан иргэдийг чирэгдүүлж бухимдуулдаг олон хаалганы үйлчилгээг нэг цонхонд багтааж, явуулын хэлбэрт оруулжээ.

## Шинэ биш ч шилдэг шийдэл

Дараалалд дарагдсан олон хаалгыг халж "Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ"-г нэвтрүүлсэн Багахангай дүүргийнхний шийдэл шинэ юм биш. Гэхдээ шилдэг туршлага яах аргагүй мөн.



*Зураг: "Төрийн явуулын үйлчилгээ"-нийхэн малчны хотыг зорих замдаа*



*Зураг: Бүх асуудлыг нэг дор шийднэ*

Шинэ биш гэдгийг учир нь дүүргийн хүн амын таруу оршин суудаг онцлогт тохируулан төрийн үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх санаачилга эдүгээгээс 17 жилийн өмнө гарч байжээ.

1997 оны нэгдүгээр сард Багахангай дүүргийн хоёрдугаар хорооны Засаг дарга Н.Зина анх "Засаг даргын явуулын өрөө"-г санаачилсан байна. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн цаг хугацаа, зардал мөнгийг хэмнэх зорилготой энэ санаачилгыг тухайн үед Багахангай дүүргийн Засаг даргаар ажиллаж байсан Ц.Батбаяр ихээхэн дэмжсэн гэдэг. Ингээд Багахангай дүүрэгтээ төдийгүй нийслэлд анхны гэж болох "Засаг даргын

явуулын өрөө” төмөр замын “Хоолт”, “Цагаанхяр”, “Хангай”, “Мааньт”, “Агуйт”, “Булагтай”, “Хайрхан” зэрэг өртөө, зөрлөгийн замчид болон малчдын хотонд зочилжээ. Ийнхүү тус дүүрэгт анх удаа төрийн нэг цэгийн үйлчилгээг амжилттай туршсан байна.

Тухайн үед “Засаг даргын явуулын өрөө” улиралд нэг удаа дүүргийнхээ нутаг дэвсгэрээр тойрч, 5-8 төрлийн үйлчилгээг үзүүлдэг байв. Төрийн үйлчилгээг хүргэх зориулалтын авто машин, тоног төхөөрөмж дүүргийн төр захиргааны байгууллагад байсангүй. Тиймээс Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн тасаг болон Хоёрдугаар хорооны микро автобусыг хөлөглөн төрийн үйлчилгээг малчны хот, төмөр замчдын ажлын талбар, өрх нэг бүрт хүргэж, үйлчилж байжээ.

Шинэ тулгар ажилд саад бэрхшээл, сорилт аль аль нь тулгардаг хойно. “Засаг даргын явуулын өрөө”-г аялуулахад шатахууны зардал, үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдын хоолны мөнгийг шийдэхээс эхлээд хүндрэлүүд тулгарч байсан гэдэг.

Тиймээс 2009 оны хоёрдугаар сард Багахангай дүүргийн ИТХ-ын 23-р тогтоолоор төрийн явуулын үйлчилгээний үйл ажиллагаа хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэхээр “Төрийн


явуулын үйлчилгээ”-ний журам, үзүүлэх үйлчилгээний төрлийг албажуулан баталжээ.

Ингэснээр дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороод, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгал, Татварын хэлтэс, Боловсролын байгууллагууд, Бүртгэлийн хэлтэс, Газрын алба, хүн, малын эмч, банкны салбарын ажилтнууд багтсан өргөн бүрэлдэхүүнтэйгээр төрийн үйлчилгээг хүргэх болов. “Төрийн явуулын үйлчилгээ”-ний цар хүрээ өргөжсөнөөр зориулалтын авто машин, техник, тоног төхөөрөмж, төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага урган гарсан байна.

### Арван зургаан үйлчилгээтэй нэг цонх

2009 оны арваннэгдүгээр сард Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн нэг цонхны үйлчилгээний төслийн багт Багахангайнхан явуулын нэг цонхны үйлчилгээ үзүүлэх санал, судалгаа, төслөө хүргүүлжээ.

Энэхүү саналын дагуу 2011 оны гуравдугаар сард Швейцарын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжаар манай улсад хэрэгжүүлж байгаа “Нэг цонхны үйлчилгээ”-ний төслийн шугамаар 49 сая төгрөгийн үнэ бүхий “Hyundai starex” маркийн авто



Сүүлийн гурван жилд “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ” үзүүлсэн байдал



машин, түүнд нэмж суурилуулсан тоног төхөөрөмжийг Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газарт буцалтгүй тусламж болгон хүлээлгэн өгсөн байна.

“Төрийн явуулын үйлчилгээ” ийнхүү “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ” болон өргөжиж, 16 төрлийн үйлчилгээг нэг цэгээс авах боломжтой таатай, тухлаг орчин бүрджээ. Дүүргийн Засаг даргын захирамжаар явуулын нэг цонхны үйлчилгээг зохион байгуулах ажлын хэсэг, зарцуулагдах төсөв, үйлчилгээний маршрутыг батлуулж, төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн, үйлчилгээг улирал тутам буюу жилд дөрвөн удаа зохион байгуулах болов.

“Засаг даргын явуулын өрөө”-нөөс “Төрийн явуулын үйлчилгээ”, “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ” хүртэлх 17 жилийн хугацаанд дүүргийн төвөөс алслагдсан өртөө зөрлөгүүд шинээр байгуулагдаж, дүүргийн хүн ам өсөн нэмэгджээ. Үүнийг дагаад тэдэнд үзүүлэх төрийн үйлчилгээний ачаалал ч нэмэгдсээр ирсэн байна.

Дүүргийн төвөөс алслагдан оршдог өртөө зөрлөгийн замчид, хөдөлгөөнчид, мал бүхий иргэдэд түргэн шуурхай хүрч үйлчлэх болсноор төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирчээ.



*Зураг: Төмөр замын өртөө, зөрлөг, малчны гэрт “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ” хүрдэг.*

Нэг үйлчилгээний олон хаалгыг олон үйлчилгээний нэг хаалгаар солих эрхэм зорилгоо Багахангай дүүргийн засаг захиргааны байгууллага ийнхүү бүрэн

дүүрэн хэрэгжүүлсэн байна.

Тус дүүргийн алслагдсан хорооны иргэд гэртээ сууж байгаад л нийгмийн халамж, нийгмийн даатгал, эрүүл мэнд, мал эмнэлэг, газрын алба, иргэний бүртгэл, нотариат, хууль зүй, номын сан, соёл, банк, цэцэрлэг зэрэг төрийн үйлчилгээг нэг дороос авдаг болжээ. Түүнчлэн “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ”-нийхэн иргэддээ олон талын мэдээллийг хүргэдэг байна. Нэг сумаар хэд хэдэн туулай буудаж байгаа гэсэн үг. Дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, дүүргийн тухайн оны дэвшүүлсэн зорилго зорилт, нийгэм эдийн засгийн зорилт, төлөвлөгөөний биелэлтийн явц, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд хийгээд цаг үеийн бусад мэдээ мэдээлэл гэдэг төв суурингаас алслагдсан иргэдэд ангасан цөлд цангаа тайлахтай л адил хэрэг.

Батлагдсан график, маршрутын дагуу ажлын хоёр хоногт 1200 хүртэлх километр зам туулан, жилд давхардсан тоогоор 200-400 гаруй иргэнд үйлчилж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэн ажилдаа тусган хэрэгжүүлэх болсноор чанарын өөрчлөлт гарч, төр захиргааны байгууллага, иргэдийн уялдаа холбоо сайжирсан байна. Иргэдийн хувьд ч гэсэн санхүү, цаг хугацаа хэмнэж, сэтгэл ханамж нэмэгджээ. Төр, иргэн хоёр аль аль нь хожсон гэсэн үг.

Эргэх дөрвөн улиралд 24 цагаар галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр замын тээврийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж буй төмөр замчид болон байгаль, цаг агаарын эрхшээл дор нүүдэллэн аж төрж байгаа малчид, тэдний гэр бүл, шинээр төрсөн бяцхан хүүхдээс эхлээд ахмад буурал хүртэлх иргэн бүрт төрийн олон талт үйлчилгээг нэг цэгээс хүртээмжтэй, нэг бүрчлэн хүргэж байгаа энэ шийдэл бол яах аргагүй үйлчилгээний дэвшилтэт хэлбэр.

“Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангаснаар төр захиргааны байгууллагаас гаргасан тогтоол шийдвэр, иргэдэд нээлттэй ойлгомжтой болж, төрийн бус байгууллагуудын оролцоо нэмэгдэн, хамтран ажиллаж, мэдээллийг харилцан солилцон, төр, иргэдийг холбох гүүр болон ажиллаж байна” хэмээн “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ”-нийхээ тухай Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын тайланд дурджээ. Цаашид энэхүү үйлчилгээний тасралтгүй үйл ажиллагааг хангах, үйлчилгээ үзүүлэх төсөв хөрөнгийг жилийн төсөвт тусгах, үйлчилгээ хариуцсан ажилтнуудыг сургаж бэлтгэх нь зэрэгт дүүргийн удирдлагууд анхааран ажиллаж байгаа гэнэ.

Аливаа байгууллага өөрсдийн хийж байгаа ажлынхаа талаар нааштай, сайн мэдээлэл өгөх нь мэдээж. Тиймээс “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ”-ний чанар, хүртээмжийн талаар хамгийн бодитой мэдээлэл өгөх хүмүүс бол Багахангай дүүргийн жирийн иргэд. Энэ бодлын үүднээс зарим иргэний сэтгэгдлийг сонссон юм.

#### **Нэгдүгээр хорооны иргэн М.Дагвадорж:**

-Энэ үйлчилгээ чанаржиж, машин, техник хэрэгсэлтэй болсноор хүссэн үйлчилгээгээ гэртээ авч байгаад баярлаж байна. Би байнгын асаргаанд байдаг өвчтөн асардаг. Манай хөгшин даралт ихтэй, харваад зургаан жил хэвтэрт байгаа хүн. Би байнгын хажууд нь сахидаг болохоор төв орж үзүүлж чаддаггүй. Сар бүр эмч ирж үзэж байгаад талархаж байна. Миний цаг болон эдийн засагт маш их хэмнэлт гарч байна.

Сая явуулын үйлчилгээ ирэхэд нь тэтгэвэр тогтоолгох бичиг баримтаа бүрдүүлж өглөө. Манайх дүүргийн төвөөсөө 15 километр зайтай амьдардаг. Явуулын үйлчилгээгээр цээж зураг авдаг болсон гэсэн. Одоогоор үйлчлүүлээгүй

байна. Гарын авлагыг маш их хэрэгтэй зүйл гэж бодож байна. Цаг завтай үедээ гарын авлагыг судалж, хэрэгцээт зүйлсээ мэдэж авдаг. Мөн миний сайн нөхөр, хань гэж хэлж болно шүү. Явуулын нэг цонхны үйлчилгээнд явдаг хүмүүсээ таньдаг болохоор илүү нээлттэй, харьцахад амар байдаг юм. Урьд нь эдгээр хүмүүс нэг машинд олуулаа чихцэлдэж явдаг, их хэцүү харагддаг байсан. Одоо сайхан болжээ. Өмнөх сард ирэхэд нь би газрын албаны мэргэжилтнээс хүссэн мэдээллээ авч, өмчлөх газраа сонгосон.

#### **Хоёрдугаар хорооны иргэн Б.Батмөнх:**

-Манайх дүүргийн төвөөс 20 километр хол байдаг. Эхнэр бид хоёр өндөр настай хүмүүс учраас байнга даралт ихэсдэг. Мөн олон малтай учраас хүн, малын эмч аль аль нь нэн шаардлагатай байдаг. “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ” үзүүлдэг хүмүүсийг сайн таньдаг, ах дүү шиг болсон тул харьцахад хүндрэл гардаггүй. Бүх хүмүүсийн утасны дугаар ч бий. Ирэх болгондоо л нэг асуудлыг маань шийдэж өгдөг.

Сая нотариатын үйлчилгээ авлаа. Сэтгэгдэл өндөр байна. Машин, техник хэрэгсэлтэй болсонд нь баярлаж байна. Явуулын үйлчилгээний багийн хамт олондоо ажлын амжилт хүсч, энэхүү ажлаа өргөжүүлэн, иргэдийн сайшаалыг хүртэж яваарай гэж хүсье.

#### **Нэгдүгээр хорооны иргэн С.Сүх:**

-Энэ үйлчилгээний багт баярлаж байна. Манайх төвөөс 40 гаруй километр зайтай. Хөгжлийн бэрхшээлтэй гурван хүүхэдтэй, 80 гарсан настай ээжтэйгээ ам бүл тавуулаа амьдардаг. Айлын мал хардаг болохоор хүссэн үедээ дүүрэг рүү орж чаддаггүй. Заримдаа алхаж ордог байсан.

Харин одоо явуулын үйлчилгээ сар болгон ирж байгаа учраас тэгж явган алхах шаардлагагүй боллоо. Сая ээж

маань таяг, нүдний шил, ахмадын баярт зориулсан гарын бэлгээ гардан авлаа. Бас ээжийн бичиг баримтанд итгэмжлэл хийлгэж, хүүхдүүдийнхээ бичиг баримтыг канондуулж авсан. Маш том ажил амжууллаа. Ийм сайхан үйлс хийж яваа явуулын үйлчилгээнийхэндээ баярлалаа.

Эндээс харахад дүүргийн иргэд “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ”-ний талаар ам сайтай байна. 2004 оноос хойших статистикийг харахад явуулын нэг цонхны үйлчилгээний давтамж болон үйлчилгээний нэр төрөл байнга нэмэгдэж, хамрагдсан иргэдийн тоо ч өссөөр ирсэн байна.

Тухайлбал, 2004 онд дөрвөн удаа, долоон төрлийн үйлчилгээг 150 иргэнд хүргэсэн бол 2011 онд найман удаа, 11 төрлийн үйлчилгээг 217 иргэнд хүргэж ажиллажээ. 2013 онд “Төрийн явуулын нэг цонхны үйлчилгээ”-ний нэр төрөл 34-д хүрсэн бөгөөд нийт 289 иргэнд үйлчилсэн байна. 2014 оны эхний гурван улирлын байдлаар 57 төрлийн үйлчилгээг 460 иргэнд хүргэсэн гэсэн дүн мэдээ байна.

**Лавлагаа холбоос:**

[www.bagakhangai.ub.gov.mn](http://www.bagakhangai.ub.gov.mn)

**Холбоо барих:**

Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, Захиргаа, хуулийн хэлтэс  
Утас: 99092619, 96585812

**Ц.Дэнсмаа** Захиргаа, хуулийн хэлтсийн дарга

Электрон шуудан:  
[densee\\_nhh@yahoo.com](mailto:densee_nhh@yahoo.com)

**Б.Гэрэлцолмон** Захиргаа, хуулийн хэлтсийн мэргэжилтэн  
Утас: 70491011

Электрон шуудан:  
[geetsoo0421@yahoo.com](mailto:geetsoo0421@yahoo.com)

Байршил:

БХД, 1-р хороо, ЗДТГ-ын байр, 3 давхар, 303 тоот



## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 105 ДУГААР СУРГУУЛЬ

**САЙН ТУРШЛАГА:** Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн хошой тэргүүний 105 дугаар дунд сургууль 1997 онд байгуулагдсан. Тус сургууль Авлигатай тэмцэх газраас хүүхэд, өсвөр үе залуучуудад шударга ёсны үзлийг төлөвшүүлэх чиглэлээр Ерөнхий боловсролын сургуулийн түүх, нийгмийн ухааны багш нарыг сургагч багшаар бэлтгэснээс хойш сурагчдад шударга ёсны чиглэлээр нөлөөлийн сургалт, сурталчилгааны материал бэлтгэн хүргэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, сурагчдад хичээл бэлтгэж хүргэхээс өмнө болон хүргэсний дараа хийсэн сургалтын үр дүнгийн харьцуулалтыг санаачлан хэрэгжүүлсэн нь үр дүнтэй алхам болжээ. Тиймээс төр, иргэний нийгмийн байгууллагуудын дунд зарласан “Авлигаас ангид, сайн засаглалын туршлага-2013” үйл ажиллагааны хүрээнд “Авлигаас ангид, сайн засаглалын туршлага-2013” өргөмжлөл хүртсэн байна.

## АВЛИГАГҮЙ ИРЭЭДҮЙН ЭЗЭД

### Нийгмээ анагаах “эмч” болно

“...Ирээдүйд авлига гэдэг зүйл ор мөргүй алга болсон байна. Дайн байлдааны тухай бид номоос уншиж, киноноос үзэж л төсөөлөл авдаг шиг авлига гэдэг энэ зүй бус үзэгдлийн талаар бидний хүүхдүүд номоос л унших болов уу.

Гэхдээ энэ нь сайны жишээ биш болохоор ирээдүйн хүүхдүүд авлигыг яагаад ч ойлгохгүй. Тэр үед би хүүхдэдээ энэ талаар ойлгуулах гэж Отгоо багш маань өнөөдөр бидэнд “Авлига уу, бэлэг үү” гэдэг хичээл заахын тулд яаж хичээж, сонирхолтой арга хэлбэрийг сонгох гэж хөдөлмөр зарцуулж байгаа шиг л багагүй ажил болох байх. Гол нь

бидний үр хүүхдүүд авлигыг мэдэхгүй, хор уршгийг нь амсахгүй өснө гэдэг юутай сайхан бэ...”

Арваннэгдүгээр ангийн сурагч охины бичсэн зохион бичлэгийн нэгээхэн хэсгийг та уншлаа. Хэрсүүхэн байгаа биз. Ирээдүйд зохиолч, сэтгүүлч болохыг мөрөөддөг сурагч охин авлигын тухай ийм бодолтой, ирээдүйдээ итгэх гэгээн итгэлтэй явна.

“Ээж нь, эсвэл аав нь хүнд өвчин туссан хүүхэд ирээдүйд эмч болно гэж мөрөөдөж байгаа тухай нэг бус кинонд гардаг. Би түүн шиг л авлигаар өвчилсөн нийгмээ аврахын тулд сэтгүүлч, зохиолч болохоор шийдсэн. Хүмүүсийн оюун санаанд авлигыг жигшин зэвүүцэх үзэл

төрүүлж чадвал нийгэм маань сайхан болно. Арын хаалга бүхэн хаагдана...” Сурагч охины зохион бичлэг ийн үргэлжилнэ.

Сонгинохайрхан дүүргийн хошой тэргүүний 105 дугаар сургууль дээр хагас өдрийг өнгөрүүлэхдээ тус сургуулийн сурагчдын бүтээл, хичээлийн тэмдэглэл сэлттэй танилцсан маань энэ. Тус сургуулийн захиргаа сурагчдынхаа авлигын эсрэг боловсролыг нэмэгдүүлэх талаар цөөнгүй ажил санаачлан хэрэгжүүлжээ.

Энэ бол бяцхан иргэдийнхээ оюун сэтгэлгээнд авлигын эсрэг дархлаа тогтоож байгаа хэрэг юм хэмээн тус сургуулийн түүх, нийгмийн багш С.Отгонбаяр хэлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын явцад хүүхдийн ёс суртахуун, хүмүүжил ялангуяа авлигын эсрэг боловсрол, авлигыг үл тэвчих үзэл хандлага төлөвшдөг. Гэсэн хэдий ч өнөөгийн манай сургалтын агуулга, хөтөлбөр нь шинжлэх ухааны мэдлэгийг шүтсэн, сурагчдад шударга ёсны тухай ойлголт үнэт зүйлсийг өөриймшүүлэн төлөвшүүлэх агуулга арга зүй сул, мөн багшийн хэрэглэх сургалтын хэрэглэгдэхүүн арга зүйн зөвлөмж хангалтгүй байдаг.

Энэхүү байдлыг харгалзан Авлигатай тэмцэх газар хүүхэд өсвөр үе залуучуудад шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр олон ажил хийдгийн нэг нь ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан сургалт юм.

С.Отгонбаяр багш 2012 онд Азийн сан, АТГ-ын хамтарсан сургалтад хамрагдаж сургагч багш болсон юм байна. “Авлигын эсрэг боловсрол” сэдэвт энэхүү сургалтад суусны дараагаар тэрээр өөрийн сургуулийн сурагчдад шударга ёсны үзэл төлөвшүүлэхийн тулд юу хийх ёстой вэ гэж нэлээд боджээ. Ингээд сургуулийнхаа захирал, сургалтын менежерүүдтэй зөвлөсний эцэст хэд

хэдэн ажил хийхээр төлөвлөсөн байна. Сурагчдын дунд авлигын талаарх мэдлэг тун хомс байгааг ч тэрээр ажигласан байна. Авлига гэж юу вэ гэдэг асуултад бүрэн дүүрэн хариулах сурагч ахлах ангийнхан дунд ч гэсэн цөөхөн байв. Тэд ихэвчлэн авлига гэдгийг багш нар сурагчдаасаа, эмч нар өвчтөнүүдээсээ авдаг бэлэг сэлт, зөөлөн чихрийн цуглуулга төдийгөөр л төсөөлөх нь түгээмэл байжээ. Энэ бүхэн дээр үндэслээд сурагчдынхаа энэ ойлголтыг өөрчлөх, авлигын эсрэг боловсролыг нь дээшлүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ гэдгийг 105 дугаар сургуулийнхан тодорхойлж авсан байна.

### Авлигын эсрэг иргэний боловсрол

105 дугаар сургуулийн ахлах, дунд ангийнхны Иргэний боловсролын хичээлийн хөтөлбөрт нэгэн шинэ сэдэв нэмэгдсэн нь авлигын эсрэг боловсрол байв. “Бэлэг үү, авлига уу”, “Авлигын индексийг хэмжих нь”, “Шударга ёс нөхөрлөл хоёр”, “Монголын хутагтын дуртгал дахь авлига” зэрэг 10 гаруй хичээлийн хөтөлбөр боловсруулан сургуулийнхаа 6-11 дүгээр сангийн сурагчдад заажээ. Дээрх хичээлүүдийг Монголын болон дэлхийн түүх, нийгэм, иргэний боловсрол хичээлийн цагууд дээр орох боломжтой гэж үзсэн байна.

Ингээд сургууль дээрээ хэрэгжүүлсэн “Шударга нийгмийн төлөө хамтдаа” төслийн хүрээнд С.Отгонбаяр багш “Бэлэг үү, авлига уу”, “Ажилд авахад юуг гол шалгуур болгодог вэ”, “Мөнгөний үнэ цэнэ” сэдвээр, Ж.Уранчимэг багш “Нөхөрлөл шударга ёс хоёр”, “Шударга ба шударга бус зүйлийн ялгаа” зэрэг сэдвүүдээр нийт 10 удаа хичээл заасны хоёр нь нээлттэй хичээл байжээ.

Эхний удаа “Авлигын индексийг хэмжих нь” сэдэвт хичээлд сургалтын менежер С.Алимаа, нийгмийн ажилтан н.Энхтуул нар болон бусад багш нар суусан



байна. Дараагийн нээлттэй хичээлд Боловсролын хүрээлэнгийн ажилтан У.Туяа, Л.Алтанзаяа нар сууж хичээлд анализ хийн сурагчдад зөвлөгөө өгчээ. Хичээлээс хичээлд багшийн арга барил ч сайжирч, сурагчдын мэдлэгийн хүрээ тэлж байв.

Авлигын талаар хичээл орохоос өмнө болон хичээл орсны дараа авсан судалгааны харьцуулалтаас үүнийг харж болох юм. Сурагчдаас “Авлигын талаар сонсож байсан уу”, “2006 онд Авлигын эсрэг хууль батлагдсаныг мэдэх үү”, “Авлигатай тэмцэх газар байдгийг мэдэх үү” гэх мэт 10 асуултаар санал асуулгыг хичээл заахаас өмнө авсан бөгөөд хичээлээ заасны дараа дахин 10 асуултаар санал асуулга авчээ. Ингээд дүнг нэгтгэж үзэхэд хичээл заасны дараа сурагчдын авлигын талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн нь ажиглагдсан байна.

### ***С.Отгонбаяр багштай авлигын эсрэг боловсрол олгох хичээлийнх нь талаар ярилцлаа.***

-Цаашид хүүхдүүдийн дунд авлигын эсрэг, авлигыг үл тэвчих үзэл төлөвшүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй байна вэ?

-Сурагчдад иргэний боловсрол хичээлээр дамжуулж авлигыг үл тэвчих ухамсар суулгаж өгснөөр насанд хүрэхдээ авлигаас ангид байж сурах, зөв дадалтай иргэн болж төлөвших сайн талтай. Тиймээс аль болох багаас нь энэ талын мэдлэгийг олгож, авлигын эсрэг үзлийг төлөвшүүлэх хэрэгтэй.

### ***-Авлигын эсрэг боловсрол олгох хичээлийн цаг хангалттай байж чадаж байна уу?***

-Ер нь хангалттай биш. Гэтэл дараа жилээс нийгмийн ухааны хичээлийн цагийг бүр багасгах сурагтай. Хүнийг хүн болгодог хичээлийн цагийг багасгаад байгаа нь авлигын эсрэг боловсрол олгоход хүндрэлтэй л болж байна.

### ***-Танай сургуулийн хувьд энэ хичээлүүдээ цаашид үргэлжлүүлнэ биз дээ?***

-Энэ бол манай сургуулийн уламжлалт ажил учир таслалгүй үргэлжлүүлэн аваад явна. Харин хичээлийн цаг багасвал авлигын эсрэг боловсрол орох хичээлийн агуулга багасах байх. Гэхдээ сурагчдадаа авлигыг үл тэвчих хүмүүжил олгох талаар аль болох анхаарна.

### ***-Монголын хутагтын дуртгал дахь авлига гэдэг хичээл заадаг юм байна. Энэ юуны тухай хичээл вэ?***

-Энэ хичээлээр 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнг 1919 онд устгах гэсэн оролдлогыг таслан зогсоох үед Шанзув Бадамдорж сайд авлигад автан улсаа худалдсан тухай түүхийг заадаг юм. Энэ жишээнд тулгуурлан авлига нь улс орны тусгаар тогтнолыг хүртэл устгадаг аюултай зүйл гэдгийг сурагчдад ойлгуулдаг.

### ***“Ван ханд өгсөн авлига”***

Хүүхэд бол нийгмийн толь. Тэд орчин тойрныхоо эд юмс, үйл явдал, томчуудын зан авирыг тэр чигт нь дууриадаг. Өөрөөр хэлбэл хүүхэд аливааг шууд хүлээн авдаг гэсэн үг. Тиймээс тэдэнд авлигын эсрэг боловсрол олгохын тулд аль болох амьдарч буй орчинд нь ойр, энгийн байдлаар таниулга, сурталчилгаа хийхийг чухалчилсан байна. Тухайлбал, 105 дугаар сургуулийнхан сургуулийнхаа анги танхимуудад Авлигатай тэмцэх газраас гаргасан зурагт хуудас, тараах материал, хаалган дээр наадаг санамж зэргийг байршуулжээ.

Сургуулийн орох хаалга болон зарим ангиудын хаалган дээр “Авлигыг түлх” санамжийг нааж, зарлалын самбарт авлигын эсрэг мэдээлэл бүхий зурагт хуудас байршуулсан байна.

Ингээд 10 хоногийн дараа “Авлигын эсрэг хамтдаа” тэмцээн зохион байгуулахад сурагчид авлигын талаар мэдээлэл өгөх утсыг сайн мэдэж байсан гэнэ. Түүнчлэн

зурагт хуудсуудаар илэрхийлсэн санаа, тэдгээрт агуулагдсан мэдээллүүдийг сурагчид сайн тусгаж авсан байв.

Тус сургууль 2009 оноос 10 дугаар ангийн сурагчдынхаа дунд “Авлигын эсрэг хамтдаа” тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулж ирсэн туршлагатай. Энэ тэмцээний зорилго нь сурагчдад авлигын хор уршгийн талаар мэдээлэл олгох, өөрсдийн хэмжээнд авлигаас хэрхэн ангид байх ёстой зэргийг ойлгуулж мэдүүлэхэд чиглэдгээрээ онцлог юм. Таван жилийн өмнөөс уг тэмцээнийг тогтмол зохион байгуулсан тул багш, сурагчид хэн хэн нь багагүй туршлага хуримтлуулжээ.



*Зураг: Сурагчид “Авлигын эсрэг хамтдаа” тэмцээн бэлтгэж байгаа нь”*

Тэмцээн гэрийн даалгавраар авлигын хор хөнөөлийг харуулсан ханын

самбар хийх, мэндчилгээ, жүжигчилсэн тоглолт, урлагын номер, багуудын болон багийн ахлагчийн асуулт хариулт гэсэн хэсгүүдтэй. Сүүлийн жилүүдэд 105 дугаар сургууль АТГ-тай хамтран ажиллах болсноор 2012-2013 оны хичээлийн жилд зохиогдсон “Авлигын эсрэг хамтдаа” тэмцээнд тус газрын Соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Б.Нанжидгүндэлмаа шүүгчээр ажиллаж, тэмцээний дараа сурагчдад Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа болон авлигын хор уршгийн талаар мэдээлэл хийсэн байна.

С.Отгонбаяр багшаас “Авлигын эсрэг хамтдаа” тэмцээнд хүүхдүүдийн идэвх оролцоо хэр байдаг талаар тодруулахад, “Сурагчид маш идэвхтэй оролцдог. Жүжигчилсэн тоглолт, зурагт хуудас зэрэгтээ маш их сэтгэл гаргаж, хөдөлмөр зарцуулдаг. Жишээ нь, нэг удаагийн тэмцээн дээр сурагчид дундад эртний үед ч авлига байсан гэдэг санааг гаргахдаа Тэмүүжиний Ван хан Тоорилд булган дах бэлэглэсэн үйл явдлыг жишээ болгосон байсан.

Мэдээж авсан жишээ нь оновчгүй байж болно. Гэхдээ л хүүхдүүд авлига гэдэг зүйл нийгэмд, хүмүүст хор хөнөөлтэй



гэдгийг маш сайн ойлгож, энэ бол шударга ёс, ил тод байдал, ардчилал, сайн сайхан амьдрал зэрэг хүний нийгмийн үнэт зүйлийн эсрэг сөрөг үзэгдэл гэдгийг мэдэж авдаг” хэмээсэн. С.Отгонбаяр багшийн нэг шавь “Авлига агаарын бохирдлоос ч илүүгээр хүмүүс биднийг хордуулж байна. Энэ утааг хөөж зайлуулаад гэгээн тунгалаг цэвэр агаараар амьсгалахын тулд хүн бүр зөв, шударга байх хэрэгтэй” хэмээн бичжээ.

105 дугаар сургуулийнхан ийнхүү сурагчдадаа авлигын эсрэг боловсрол олгох талаар олон төрлийн арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулснаар тэдэнд авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлж чадсан байна. Тухайлбал, сурагчид хэн нэгэнд талархсан сэтгэлээ илэрхийлэхдээ заавал бэлэг дурсгал, эд зүйлс өгөх биш сайхан инээмсэглэл, халуун дотно үгээр чин сэтгэлийн талархлаа илэрхийлж болдог гэдгийг ойлгож авчээ.

Энэ мэтээр энгийнээс нарийн хүртэлх нийгмийн бүхий л харилцаанд авлигаас ангид байх чадвар, ёс зүйн дархлааг сурагчдад олгох нь ерөнхий боловсролын сургуулийн багш нарын үүрэг. Түүх, нийгэм, иргэний боловсролын хичээлээр зөвхөн мэдлэг олгохоос гадна сурагчдадаа зөв төлөвшил хүмүүжил суулгаж байгаа 105 дугаар сургуулийнхны сайн туршлага тэдэнд бэлэн жишээ болох болов уу.

Хүүхэд багачууд авлигын эсрэг боловсрол эзэмшинэ гэдэг Монголын ирээдүйн эзэд авлигагүй нийгэмд аж төрөхийн баталгаа юм.

### **Холбоо барих:**

С.Отгонбаяр Нийгмийн ухааны багш.  
Улаанбаатархот.Сонгинохайрхан дүүрэг.  
105-р дунд сургууль.  
Утас: 98880919

Хаяг: Сонгинохайрхан дүүрэг, 11-р хороо,  
(Хөтөлийн автобусны 112-р буудлын урд)  
Утас: 306077, 306087





## СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**САЙН ТУРШЛАГА:** Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар нь авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр дүүргийн Засаг даргын дэргэдэх харьяа газар, хэлтэс, албадын 14 багийн 140 гишүүн, 600 гаруй албан хаагчдыг хамруулан “Дэвжээ” тэмцээнийг “Сүхбаатарчууд бид авлигын эсрэг хамтдаа” сэдвийн дор зохион байгуулсан нь хууль тогтоомжийг сурталчлах шинэлэг арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлсэн нөлөөллийн үр дүнтэй арга хэмжээ болсон. Мөн дүүргийн хэмжээнд ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь сайн туршлага болсон тул Авлигатай тэмцэх газраас “Авлигаас ангид, сайн засаглалын туршлага-2013” өргөмжлөлөөр шагнажээ.

## АВЛИГАД ХАРШИЛТАЙ ДҮҮРЭГ

**Х**отжилтын өвчин гэгддэг харшил хамрын ханиад шиг ихэсч байгаа нь эмч нарын санааг зовоож байна. Харшил гэдэг бол гадны хүчин зүйлийн үйлчлэлийг бие махбодь байвал зохих хэмжээнээс илүү хэт эмзэг, хүчтэй хүлээн авч хариу үзүүлэхийг хэлдэг. Амьтан, ургамал, тоос шорооноос эхлээд хоол унднаасаа хүртэл харшилдаг хүн бий.

Нийгмийг нэг цогц махбодь гэж үзвэл түүнийг нэг л зүйлээс харшилтай болгочихмоор санагдана. Тэр нь авлига.

Авлигыг нийгмийн эд эс хүлээж авмагцаа хүчтэй цочрол өгч, хариу үйлдэл үзүүлдэг болчихвол тун сайн. Ямар ч байсан нийслэлийн Сүхбаатар дүүргийнхэн авлигад харшилтай. Муу зүйлээс харшилтай байна гэдэг сайн хэрэг. Авлигын эсрэг ийм дархлааг тогтоохын тулд дүүргийн засаг захиргааны байгууллага багагүй

хүчин чармайлт гаргажээ. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар үйл ажиллагааны болон хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр дэвшилттэй ажлууд санаачилсан байна.

Дүүргийн цахим хуудаснаа бүх төрлийн мэдээллийг байршуулан, байнга шинэчилж байдаг бөгөөд Засаг даргын Тамгын газар дээр мэдээллийн самбар гаргажээ. Гэхдээ энэ удаа тус дүүргийн засаг захиргааны байгууллагуудын ажилтан албан хаагчдынхаа авлигын эсрэг боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлыг онцолж байна.

### “Дэвжээ-1”

Сүхбаатар дүүргийн Засаг Даргын Тамгын газар Авлигатай тэмцэх газартай хамтран 2013 оны аравдугаар сард анх удаа төрийн албан хаагчдын

дунд Авлигын эсрэг хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх, авлигын нийгэмд учруулах хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, энэ зүй бус үзэгдлийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх зорилгоор “Сүхбаатарчууд бид авлигын эсрэг хамтдаа” сэдэвт “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулжээ.

Энэ тэмцээнд дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, тасаг болон Тамгын газар, хороодын ажлын албаны төрийн албан хаагчдаас бүрдсэн нийт 14 баг оролцож мэндчилгээ, эрх зүйн бодлого, жүжигчилсэн тоглолт буюу гэрийн даалгавар, багийн ахлагчийн тэмцээн, шүүгчдээс өгөх асуулт зэрэг таван даалгавраар өрсөлдсөн байна.



Багууд Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн талаар асуудал хөндсөн нийтлэг зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх арга замын талаар шинэлэг ойлгомжтой хэлбэрээр үзүүлж, хөгжөөн дэмжигчдэд дээрх хууль тогтоомжуудын талаар мэдээлэл сурталчилгаа хийн өрсөлджээ.



Тэмцээний ерөнхий шүүгчээр Авлигатай тэмцэх газрын ахлах ажилтан, комиссар Д.Мөнхжаргал, ажилтан, комиссар А.Дэлгэрбаяр, Сүхбаатар дүүргийн Шүүхийн Тамгын албаны дарга Э.Батмөнх, Дүүргийн прокурор, Хууль цаазын зөвлөх Б.Энхтулга, Монгол улсын гавьяат жүжигчин, бүжиг дэглээч, найруулагч Ч.Долгормаа нар ажилласан байна.

Багийн нийлбэр дүнгээр дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын ажлын албаны хамтарсан “Сүлд” баг тэргүүн байр эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд болсон бол Мэргэжлийн хяналтын хэлтсийн “Түмний элч” баг дэд байр, Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн “Цэвэрлэгч” баг удаах байр, Татварын хэлтсийн “Эсрэг гурвалжин” баг тусгай байр тус тус эзэлжээ.

Ийнхүү Сүхбаатар дүүргийнхэн авлигын эсрэг тэмцэх “Дэвжээ”-г анх удаа засчээ. Энэ дэвжээн дээрээс богино хугацаанд авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаарх хууль эрх зүйн мэдлэгийг олон хүнд түгээж чадсан нь онцлог болсон юм. Ер нь эрх зүйн мэдлэгийг танхимд суугаад судлах нэг өөр. Хөгжөөнт уралдаан, тэмцээн хэлбэрээр, энгийн бөгөөд хялбаршуулсан байдлаар олгох нь нэг өөр. Тэмцээн уралдааны хувьд илүү олон хүнд хүртээмжтэй, үр дүнтэй байдгийг Сүхбаатарчуудын туршлага харуулжээ.



“Сүхбаатарчууд бид авлигын эсрэг хамтдаа” сэдэвт “Дэвжээ” тэмцээнд 14 багийн 140 төрийн албан хаагч оролцсон бөгөөд 600 гаруй иргэд,

төрийн албан хаагч хөгжөөн дэмжигчээр ирж, уг тэмцээнийг үзжээ. Тэгэхээр 740 гаруй төрийн албан хаагч авлигын эсрэг боловсрол, хууль тогтоомжийн мэдлэгээ дээшлүүлэхийн зэрэгцээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, өөрсдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх боломжийг энэхүү дэвжээ тэмцээн олгосон байна.



Ийм олон хүнд нэг дор хууль эрх зүйн сургалт семинар явуулсан бол хэдий хэр хөрөнгө зарцуулах вэ. Үр дүн нь ямар байх вэ. Тийм ч нааштай үзүүлэлт гарахгүй л болов уу. Харин 740 гаруй албан хаагч "Дэвжээ" тэмцээний туршид оролцогч багуудыг дэмжин уухайлж, хууль эрх зүйн бодлого, асуултуудад тэдний өмнөөс хариулах гэж хичээн маш идэвхтэй байжээ. Тайзан дээр өрсөлдсөн 14 багийн 140 хүнээс илүү танхимд суусан 600 гаруй үзэгч, хөгжөөн дэмжигч хоорондоо өрсөлдөн, энэ үйл явцдаа эрх зүйн мэдлэгээ тэлж байсныг тэмцээн зохион байгуулагчид онцолж байв.

Багуудад Авлигын эсрэг болон бусад холбогдох хуулиудаас сэдэвлэн кейс хэлбэрээр бэлтгэсэн бодлого бодуулж, мөн зохих хуулиудтай холбоотой сэдвээр асуудал хөндсөн, аливаа зөрчил дутагдлыг харуулсан жүжигчилсэн тоглолтыг шинэлэг санаа, сонирхолтой, хөгжилтэй, ойлгомжтой хэлбэрээр бэлтгэсэн нь шүүгчид болон үзэгчдээс өндөр үнэлгээ авчээ.

2013 оны сүүлчээр Засгийн газар, Хууль зүйн яам, Авлигатай тэмцэх газар хамтран "Шударга нийгмийн

төлөө хамтдаа" авлигын эсрэг хууль тогтоомжийг шинэлэг арга замаар сурталчилсан байгууллага тодруулах ёслолын арга хэмжээг зохион байгуулсан юм. Уг арга хэмжээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар "Сүхбаатарчууд бид авлигын эсрэг хамтдаа" сэдэвт "Дэвжээ" тэмцээнийг зохион байгуулж авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан "Сайн туршлага"-ын эзэн байгууллагаар өргөмжлөгдсөн юм.

### "Дэвжээ-2"

"Сүхбаатарчууд бид авлигын эсрэг хамтдаа" сэдэвт "Дэвжээ" тэмцээн 2014 онд хоёр дахь жилдээ зохион байгуулагджээ. Энэ удаа тэмцээний зохион байгуулалт өмнөхөөс улам боловсронгуй болсон байна.

Тэмцээн хоёр үе шаттай зохион байгуулагдсан бөгөөд эхний шатанд дүүргийн төр захиргааны байгууллагын алба хаагчид Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хүрээнд эссэ бичлэгийн болон илтгэл бичиж өрсөлджээ.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын харьяа 22 хэлтэс, нэгжүүдээс эссэ бичлэгийн тэмцээнд 50 гаруй албан хаагч, илтгэлийн тэмцээнд 30 гаруй албан хаагч тус тус оролцож тэмцээний нэгдүгээр шатны тэмцээнээс шалгарсан шилдэг зургаан оролцогч хоёрдугаар шатанд илтгэх ур чадвараараа өрсөлдөж шилдгүүдээ тодруулсан юм.



Тэмцээний ерөнхий шүүгчээр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан Д.Мөнхжаргал, АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Д.Цэнд-Аюуш, "Их засаг" их сургуулийн Хууль зүйн багш, өмгөөлөгч Я.Батханд нар ажиллажээ.

Илтгэлийн тэмцээнд нийлбэр дүнгээрээ Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтсийн мэргэжилтэн Б.Булгантамир "Авлига түүнийг үүсгэгч анхдагч хүчин зүйлүүд түүнийг арилгах арга зам" илтгэлээр тэргүүн байр, Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн А.Бакыт "Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, арга зам" илтгэлээрээ хоёрдугаар байр, Худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Б.Жаргал "Авлига нийгэмд тулгамдаж буй том асуудлын нэг" илтгэлээр гуравдугаар байр тус тус эзэлжээ.

Эссэ бичлэгийн төрөлд Мэргэжлийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн Б.Энхцолмон "Өөрөөсөө эхэлье" эссэгээр тэргүүн байр, Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн Б.Доржсугар "Сүхбаатарчууд бид авлигын эсрэг хамтдаа" эссэгээр хоёрдугаар байр, Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Б.Өлзийхутаг мөн "Сүхбаатарчууд бид авлигын эсрэг хамтдаа" эссэгээр гуравдугаар байр тус тус эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан байна.

Ийнхүү Сүхбаатар дүүргийнхний авлигын эсрэг хамтдаа хийж буй тэмцэл жилээс жилд өргөжиж, улам чанаржин, хэлбэр агуулга нь шинэчлэгдэн боловсронгуй болсоор байна. Эхний жил авхаалж самбаа, мэдлэг сорих уралдаант "Дэвжээ" тэмцээнийг өргөн хүрээнд зохион байгуулж, төр захиргааны байгууллагын албан хаагчдынхаа хууль эрх зүйн мэдлэгийн дээшлүүлсэн бол хоёр дахь жилдээ тэд авлигын шалтгаан нөхцөлийг таслах арга замыг эрэлхийлсэн, нөхцөл шалтгааныг

нь тодорхойлохыг эрмэлзсэн, нийгэмд тулгамдаж байгаа асуудлуудыг олон талаас нь судлан шинжилсэн илтгэл болон эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулжээ. Нэг үгээр хэлбэл энэ удаад тэд оюуны "Дэвжээ"-г засч шинэ санаа, бодлогын өрсөлдөөн өрнүүлжээ.

Сүхбаатарчуудын санаачлан зохион байгуулсан авлигын эсрэг хамтдаа тэмцэх энэхүү "Дэвжээ" цаашид улам өргөжсөөр байна. Авлига хэмээх зүй бус үзэгдлийг үл тэвчих үзлийг суулгаж, оюуны дархлаа тогтоож чадсан Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрынхны шилдэг санаачилга, сайн туршлага төр захиргааны бусад байгууллагуудад үлгэр дууриал болох биз ээ.

#### **Лавлагаа холбоос:**

[www.sbd.ub.gov.mn/](http://www.sbd.ub.gov.mn/)

<https://www.facebook.com/Neelttei.Sukhbaatar>

Sukhbaatar

#### **Холбоо барих:**

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар. Иргэдэд үйлчлэх төв байр

Хаяг: Улаанбаатар хот-14192, Сүхбаатар дүүргийн 7-р хороо Денверийн гудамж  
Утас:70070113

Факс:976-70070113

Электрон шуудан : info@sbd.gov.mn

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Захиргаа, хуулийн хэлтэс, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба  
Утас: 70070116, 99767480





## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА

**САЙН ТУРШЛАГА:** Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба Нийслэлийн хэмжээнд анх удаагаа иргэдийн бүлэг оролцсон худалдан авах ажиллагааны тендерийг амжилттай зохион байгуулсан, ажлын даалгавар, тоо хэмжээ, зураг төслийг бие даан хийсэн, худалдан авах ажиллагааг гомдол маргаангүй зохион байгуулсан, захиалагчийн хяналтыг ажлын гүйцэтгэлийн явцад тогтмол хийдэг, ажил хүлээлцэхдээ иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч хэвшсэн, ААН, иргэдийн бүлэг, иргэдэд худалдан авах ажиллагааны талаарх сургалт зөвлөгөөг тогтмол өгдөг, нээлттэй мэдээлэлтэй ажилладаг зэрэг сайн туршлагаараа тус алба шалгарсан юм.

## С.ЖАМЪЯНДОРЖ: "ТЕНДЕРТ ИРГЭДИЙН БҮЛЭГ ИДЭВХТЭЙ ОРОЛЦОЖ, ЗҮТГЭЛТЭЙ ХАНДДАГ"

Өнгөрсөн оноос эхлэн нийслэлээс дүүргийн хэмжээнд хийгдэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадад шилжүүлсэн. Худалдан авах ажиллагааг хэр шударга зохион байгуулсан, хийгдсэн ажлынх нь чанар хэр зэрэг болсноос тухайн дүүргийн нүүр царай тодорхойлогдох болж байгаа юм.

Нийслэлийн хэмжээнд анх удаа олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулсан, ажлын даалгавар, тоо хэмжээ, зураг төслийг бие даан хийсэн, худалдан авах ажиллагааг гомдол маргаангүй

зохион байгуулсан Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны ажилтай танилцахаар зорилоо.

Чингэлтэй дүүрэг 2014 онд улс, нийслэл, дүүргийн төсөв, ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар нийт 7,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагааны 100 ажлын шалгаруулалтыг зохион байгуулжээ. Эдгээр хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 97.1 хувьтай зохион байгуулжээ. Хийж дууссан ажлын гүйцэтгэл 86 хувьтай байна.

2014 оны хөрөнгө оруулалтын ажлын дөрөв нь улсын төсвийн хөрөнгө



оруулалтаар, 12 нь нийслэлийн төсвийн болон нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар, 84 нь дүүргийн төсвийн болон дүүргийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар санхүүжжээ.

Салбараар нь ангилж үзвэл барилга угсралтын зургаа, тохижилтын 48, гэр хорооллын гэрэлтүүлгийн 19, бусад 27 гэрээт ажил хийгдэж байна. Эдгээрээс тохижилтын ажлын явц 91 хувьтай байна.



### **Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны дарга С.Жамъяндоржтой ярилцлаа.**

**- Худалдан авах ажиллагааны алба байгуулагдахаас өмнө тендерийн мэдээлэл нэлээд хаалттай, шалгаруулалтын журам ойлгомж муутай байсан юм шиг санагддаг.**

- Тендерт оролцогчийг шалгаруулах шаардлага үзүүлэлт, тавигдах шаардлага нь ойлгомжтой байх, өрсөлдөөний тэгш байдлыг хангах явдал их чухал. Тендерийн шаардлага ерөнхий, хэт бөөрөнхий байх зэргээр өрсөлдөөнийг хязгаарладаг байсан явдал худалдан авах алба байгуулагдан ажиллаж эхэлснээр дуусгавар болсон гэж хэлж болно.

**-Тендер зарлах процедур ил тод нээлттэй байх нь авлига үүсэхээс сэргийлэх нэг чухал хүчин зүйл. Иймд тендерийн зар мэдээлэл нийтэд хүртээмжтэй байдлаар хүрч**

### **чадаж байгаа юу ?**

-Тухайн онд тухайн аймаг, дүүрэгт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөв батлагдсанаас хойш 30 хоногийн дотор олон нийтэд ил тод мэдээлэх талаар хуульчлан заасан байдаг.

Бид дүүргийнхээ Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүх худалдан авалтын төлөвлөгөөг Сангийн яам, дүүргийн цахим хуудас болон өдөр тутмын "Өдрийн сонин", "Нийслэл таймс" зэрэг хоёроос доошгүй сонинд нийтлүүлдэг.

Түүнчлэн Худалдан авах албанаас зарлаж байгаа бүх нээлттэй, болон харьцуулалтын аргаар зарлаж байгаа тендерийн урилга, зар мэдээллийг мөн дээрх байдлаар олон нийтэд хүргэдэг.

Ингэснээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд тухайн дүүрэгт хэдэн төгрөгний төсөвт өртөгтэй, ямар хөрөнгө оруулалтын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн нь ил тод нээлттэй болж байгаа юм.

### **-Энэ онд дүүргийн хэмжээний тендерт хичнээн ААН оролцов?**



*Зураг: Чингэлтэй дүүрэгт 2013 онд гэр хорооллын гэрэлтүүлэггүй гудамжинд шинээр 1632 шар өнгийн лед гэрэл суурилуулжээ.*

- Манай албанаас зарласан худалдан авах ажиллагаанд 2013 онд 286 ААН, 2014 онд 351 ААН тендерт оролцсон. 2014 онд нэгж тендерт оролцогчдын тоо 28 хувиар нэмэгдсэн. Цаашид ил

тод байдлыг нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа сулруулахгүй байхад анхаарч байгаа.

**-Үнэлгээний хороог ямар бүтэц бүрэлдэхүүнтэй байгуулдаг вэ, мөн энд ажиллаж байгаа төлөөллийг ашиг сонирхлын зөрчилд орохоос хэрхэн сэргийлдэг вэ?**

- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэний болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллөөс тогтмол оруулж, хяналт тавих нөхцлийг бүрдүүлэн ажилладаг. Иргэний хяналтыг илүү бодитой болгохын тулд хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ хийгдэх тухайн хорооны оршин суугч иргэнийг үнэлгээний хороонд оруулдаг болсон.

Иргэд үнэлгээний хороонд орсноор тендерт оролцогч аж ахуйн нэгж компаниудыг сонгон шалгаруулахад

санал өгөх тэгш эрхийг эдэлдэг. Гэхдээ үнэлгээний хороонд орох эрхтэй болохын тулд иргэд Сангийн яамнаас зөвшөөрөлтэй сургалтын байгууллагуудын сургалтанд хамрагдаж шалгалт өгөөд, АЗ сертификат авах шаардлагатай. Үнэлгээний хороонд олон нийтийн төлөөллөөр ажиллаж байгаа иргэдийн хариуцлагыг дээшлүүлэх, үүргээ биелүүлэхгүй байгаа иргэнийг дахин үнэлгээний хороонд ажиллуулахгүй байх үүднээс хурлын ирц, идэвхийн судалгаа гаргадаг.

Чингэлтэй дүүрэгт 2014 онд хийж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд орж ажиллах иргэний төлөөллийг хангахын тулд дүүргийн ИТХ-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газартайгаа хамтран иргэдэд худалдан авах ажиллагааны



Зураг: Чингэлтэй дүүргийн Иргэдийн бүлгийн хийсэн ажлаас. Зам тавьж байгаа нь



Зураг: Чингэлтэй дүүргийн Иргэдийн бүлгийн хийсэн ажлаас. Гэр хорооллын гудамж дахь далан дээрх явган хүний шат

суурь мэдлэг олгох сургалтыг дүүргийн хэмжээнд хоёр удаа зохион байгуулж, 60 иргэн хамруулснаас 14 иргэн АЗ гэрчилгээ эзэмшиж үнэлгээний хороонд ажиллаж байна.

**-Иргэдийн оролцоо гэдэг нэрийн дор иргэдийн нэрийг барьж хэн нэг этгээд өөрийн эрх ашгаа хамгаалах тал байх уу?**

-Үнэлгээний хороог авлигаас ангид байлгах нь бүтэц бүрэлдэхүүнийг томилох асуудлаар дуусахгүй. Тэндээс шударга, зөв шийдвэр гарч буй эсэхийг хянах процессийг бий болгож, үнэлгээний хорооны шийдвэрийг хуулийн хүрээнд хянаж, баталгаажуулдаг байнгын хяналтын комисс ажиллуулдаг.

Нөгөө талаас шалгарсан компанитай гэрээ байгуулахаас өмнө бусад шалгараагүй дүгнэлт, үндэслэлийг дээрх комиссоор хянан баталгаажуулсны дараа хуулийн үндэслэлийн хамт тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж зүй бус шийдвэрээс эрх ашгаа хамгаалах боломжийг нээлттэй болгодог.

**-Гадуур явж байхад, зарим хөрөнгө оруулалтын ажлыг иймхэн юмыг энэ их мөнгөөр хийлээ гэж үү хэмээн иргэд хардах явдал ажиглагддаг. Ялангуяа тохижилтын ажлын хувьд.**

- Тендерт шалгарсан ААН-үүдийн хувьд гарах зардал маш их байдаг. Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд ажилчдын цалин хөлс, татвар шимтгэл, техник тоног төхөөрөмжийн зардал гээд олон зарлага шингэсэн байдаг гэдгийг бас зөв ойлгуулах хэрэгтэй гэж бодож байна.

**-Тендерт ялагдссад байнга л гомдолтой байдаг байх даа. Шударга бус байлаа гэж. Яаж хүлээж авдаг вэ. Зөрчилдөөн гарах уу ?**

- Бид тендерийн материалыг хүлээн авмагц нэг удаагийн лацаар лацаддаг.

Энэ нь тендерийн материалыг солих будлиантуулах байдлаас хамгаалдаг. Тендерийн материалаа өгсөн этгээд лац хүлээлцэх актад гарын үсэг зурж баталгаажуулдаг.

Тендерт ялагдсан ААН-үүд мэдээж бүгд л гомдолтой гардаг. Хардаж сэрдэх нь ч бий. Бид энэ дээр анализ хийж тухайн ААН тендер шалгаруулалтад яагаад амжилтгүй оролцож байгаа тал дээр анхаарч зөвлөдөг. Материалаа дутуу буруу бүрдүүлэх, эсвэл үнэхээр үйл ажиллагаа нь шалгуурт тэнцэх эсэх талаарх зөвлөгөөг оролцохоос өмнө нь ч, шалгаруулалтын дараа ч бид ойлгуулж зөвлөдөг. Танай компаний материал ийм байсан байна үүн дээрээ анхаараачээ гэж. Тендерт оролцох ААН, иргэдэд энэ талаарх мэдлэг мэдээлэл хангалттай биш байдаг. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан худалдан авах ажиллагааны талаарх хоёр удаагийн сургалтанд дүүргийн 20 гаруй ААН-үүдийг хамруулсан.

Салбарын болон дүүргийн нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр бид иргэдэд худалдан авах ажиллагаа, тендерийн талаарх мэдээлэл зөвлөгөөг түлхүү хүргэхийг хичээж ажилладаг.

**-Хар жагсаалт буюу тендерт оролцох эрхийг хязгаарлах талаар дүүрэгт ямар ажил хэрэгжиж байгаа вэ ?**

-Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг чанаргүй гүйцэтгэх, дуусгалгүй орхих, улсын комисст хүлээлгэж өгөхгүй байх зөрчлүүдийг таслан зогсоож, төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах, хөрөнгө оруулалтын ажлыг чанартай хийлгэхийн тул тендерийн үнэлгээ хийхдээ анхаарч хариуцлагатай туршлагатай аж ахуй нэгжийг сонгон шалгаруулах нь зүйтэй.

Ингэснээр тендерийн ажлыг гүйцэтгэх үе шатанд ажлаа орхиж явах, гэрээг ноцтой зөрчих, хугацааг сунжруулах зэрэг ноцтой алдаа зөрчил арилж

байна. Захиалагчийн хяналтыг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Дүүргийн Засаг даргын Тамгын газар тавьж ажлын гүйцэтгэлийн үед зураг төслийн дагуу биш чанаргүй, шаардлага хангахгүй материалаар тухайн ажлыг хийж гүйцэтгэж байвал түүнийг таслан зогсоодог.

Аж ахуйн нэгжүүдийн хариуцлага бас их дээшилж хийж гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлээ чанартай, гэрээнийхээ хугацаанд хийж дуусгадаг болж байна.

Тендерт шалгарчихаад гэрээнийхээ үүргийг биелүүлээгүй зөрчил гаргасан аж ахуйн нэгжийг дараа дараагийн тендерт оролцвол шалгаруулалтаас татгалцах улмаар эрх бүхий дээд байгууллагад гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжийн жагсаалтад оруулах саналаа хүргүүлнэ.

**-Захиалагчийн хяналтыг, гүйцэтгэлийн явцад хэрхэн хийдэг талаар тодруулмаар байна?**



*Зураг: Чингэлтэй дүүргийн 1-р хорооны 1,3,12-14-р байрны дундах хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил эхлэхийн өмнө хорооны засаг дарга, дүүргийн мэргэжилтнүүд, иргэдийн төлөөлөлтэй хамтран ярилцаж байгаа нь. Энд "Богд идэр гол" ХХК бүтээн байгуулалт хийв.*

-ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас өмнө бүтээн байгуулалтын

ажлын талбай дээр тухайн хорооны Засаг дарга, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, ИНХ-ын дарга, ЗДТГ-ын холбогдох хэлтсийн мэргэжилтнүүд иргэдийн саналыг сонсож ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг гаргаж хамтран ажилладаг.

Захиалагчийн хяналтыг ажлын гүйцэтгэлийн явцад хийж, тухайн ажлыг шаардлага хангахгүй материалаар хийсэн нийлүүлсэн байвал санхүүжилтийг зогсоох хүртэл арга хэмжээ авч, ажлаа сайжруулах, нөхөн гүйцэтгэх шаардлага тавьдаг.

ААН-ийн хийж буй ажилтай танилцаж, техник тоног төхөөрөмжийг шалгаж, ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажлын зураг авдаг. Санхүүжилтээ бүрэн авахын тулд ААН-үүд ажлаа чанартай хийхийг зорьдог. Чанаргүй хийсэн бол санхүүжилтийг өгөхгүй гэдэг шаардлага тавьдаг. Захиалагчийн хяналтыг өндөр түвшинд хийдэг гэж хэлж болно.

Төсвийн хөрөнгийг зөв зүйтэй зүйлд зарцуулж байна уу, хийгдсэн ажил чанартай болж уу, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна уу гэдгийг иргэдийн сэтгэл ханамжаас авсан судалгаагаар харагддаг. Энэ тал дээр иргэд, хорооны засаг дарга нар хяналтыг сайн тавьдаг болсон. Бидний ажлын үнэлгээг тэд тавьдаг гэсэн үг.

**-Танай дүүргийн тендер шалгаруулалтад ААН-үүдээс гадна иргэдийн бүлгүүд их идэвхтэй оролцдог болсон байна. Иргэдийн бүлгийн ажлын талаар сонирхье.**

-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болно гэж заасан байдаг.

Явган хүний зам тавих, үер усны суваг,



далан барих, мод арчилгаа зэрэг ажлыг тухайн хорооны иргэдийн бүлгээр хийлгэж болох тухай журам бий.

Дүүргийн 19 хороонд иргэдийн 32 бүлэг байгуулагдсан. 28 бүлэг нь тендерт шалгарч ажил хийсэн. Иргэдийн бүлэгт тендерт хэрхэн оролцох талаар дөрвөн удаа сургалт зохион байгуулсан.

Нэг тендер дээр дунджаар 7-8 иргэний бүлэг өрсөлддөг. Урьд нь нэгдэж, хамтарч ажилласан түүхгүй, дадлага туршлагатай эсэх нь тодорхойгүй, аж ахуйн нэгж биш иргэдийн бүлэгт л төсвийн хөрөнгийг найдаж олгох гэж байгаа хэрэг шүү дээ.

Иргэд маань маш их нийгмийн идэвхтэй, юм хийе гэсэн эрмэлзэлтэй, чин сэтгэлээсээ хариуцлагатайгаар ажиллаж, хороонд маань үнэхээр энэ дутуу байгаа шүү гэж хандаад хийж байгаад нь баярладаг. Тэд төсөлд тусгагдаагүй ажлыг ч гэсэн санаачилгаараа нэмж хийсэн нь бий. Авсан мөнгөнийхөө ажлыг л хийнэ гэлтгүй, энд бид амьдардаг учраас орчноо сайхан болгочихвол бидэнд хэрэгтэй гэдэг үүднээс сэтгэл гаргаж ажилладаг иргэдийн бүлгүүд бий.

Манай дүүргийн 17 дугаар хорооны “Бүтээлч үйлс” гэдэг иргэдийн бүлгийнхэн явган хүний гүүр барилаа. Аль нэг барилгын компаниар хийлгэсэн юм шиг үнэхээр чанартай, сайхан гүүр болсон шүү. Ямар нэг ажил хийхэд тухайн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй байдаг шүү дээ. Гэтэл иргэдэд маань тийм мэргэшил, зөвшөөрөл байхгүй атлаа гар нийлж, маш сайн ажилласан.

ААН-үүдээс дутахгүй чадавхжсан иргэдийн бүлгүүд олон бий. Өөрсдийн амьдардаг хороо гудамжиндаа хийсэн бүтээлээ арчлах хамгаалах тал дээр тэд хэнээс ч илүү.



*Зураг: Чингэлтэй дүүргийн 17 –р хорооны “Бүтээлч үйлс” иргэдийн бүлгийн хийсэн явган хүний гүүр*

### **-Ийм шаардлага хангасан бүлгээр ажил хийлгэхээр боллоо гэдэг мэдээллийг иргэд яаж олж авсан юм бол?**

- Энэ жил дүүргийн ЗДТГ, ИТХ болон хороодтой хамтран ажилласан. Бүлэг байгуулж хорооны ажил хийлгэнэ гэдэг мэдээллийг хороогоор дамжуулж түгээсэн. Эргээд тэднээр дамжуулж дүүргийн Засаг даргын Тамгын газарт бүртгүүлж, албан ёсоор бүлэг байгуулагддаг. Бүлгийн хувьд гурваас дээш гишүүнтэй, гишүүд нь тухайн хорооны юм уу дүүргийн харьяалалтай оршин суугч байх ёстой. Мөн бүлгийн ахлагчаа сонгож, харилцан итгэлцлийн гэрээ байгуулсан байх ёстой.

### **-Иргэдийн бүлэгт урьдчилгаа төлбөр олгогдох уу. Тэд ажлаа яаж зохион байгуулж байсан бэ?**

-Гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нь төлбөр тооцоо авч ажилладаг. Иргэдийн бүлгийнхэнтэй дөрвөн удаа зөвлөгөөн хийх үед ахлагч, гишүүд цалингаа яаж авах вэ, мөнгөгүйгээр яаж ажлаа хийх



вэ гэж асууж байсан.

Дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтнүүд зөвлөгөө өгч, ажиллахад нь тусалсан. Нэгэнт хууль байгаа, түүнийг зөрчиж болохгүй учраас иргэдийн бүлгүүд ойлгож хүлээн авч, ажилласан. Тэгээд харьцангуй сайн, 100 хувь гүйцэтгэлтэй дуусгадаг. Газрын гэрчилгээ, машинаа барьцаалж зээл авсан нь ч бий. Хорооны иргэд бас ажилтай орлоготой болж байгаадаа сэтгэл хангалуун байдаг. Бид иргэдийн бүлгийн хийсэн ажилд сэтгэл хангалуун байгаа.

**-Цаашид худалдан авалт, тэр дундаа үнэлгээний процесс дахь хүний оролцоог багасгах зорилгоор мэдээллийн технологид суурилсан "Ухаалаг тендер"-ийг нэвтрүүлж, автомат үнэлгээний системд шилжүүлэхээр төлөвлөж байгаа ажил чинь юу болж байна.**

-Дүүргийн хэмжээнд явагдах цахим худалдан авалтын бэлтгэл ажил хийгдэж байгаа. Ирэх оноос тендер шалгаруулалтын 50 хувийг цахим худалдан авалтаар явуулахаар төлөвлөж байна.

Нэг тендер дээр 10 ААН оролцдог байсан бол шууд цахимжихаар оролцогчийн тоо багасч хязгаарлагдчих гээд байгаа тал бий. Тэгэхээр ААН-үүдийг цахим тендерийн аргачлалд урьдчилан сайн сургах шаардлагатай байна.

**- Үнэлгээний хорооны хурлыг тусгай тоноглон өрөөнд хийж, дуу, дүрсний архивтай болохоор зорьж байгаа гэсэн. Хийхээр төлөвлөж байгаа ажлаасаа дурьдвал...**

Үнэлгээний хорооны хурлын протоколыг бичлэг хийж архивладаг. Ирэх жилээс дуу дүрсний тоноглогдсон өрөөтэй болохоор зорьж байна. Бид цаашид ажлаа эрчимжүүлэх, шинээр хийхээр төлөвлөж байгаа олон ажил бий.

СУРВАЛЖЛАГЫН ЯВЦАД ажиглахад Нийслэлийн хэмжээнд тэргүүний ажиллагаатайгаараа шалгарсан тус дүүргийн Худалдан авах албаныхан одоогийн байдлаар давчуухан жижиг өрөөнд долоо наймуулаа зэрэгцэж ажилладаг, архивын өрөөгүй учраас бичиг баримт нь хамаг зайг нь эзлээд ажлын тав тух хэцүүхэн харагдаж байлаа. Иймээс дүүргийн ЗДТГ тус албаны ажлын байрны асуудлыг нь даруйхан шийдэх шаардлагатайг уламжилъя.

Дүүргийн хэмжээнд ААН, иргэдэд тендерийн талаарх сургалт мэдээллийг давтамжтай явуулах шаардлагатай бөгөөд, энэ тал дээр дүүргээс төсвийн асуудлыг нь шийднэ гэдэгт найдаж байна.

**Лавлагаа холбоос:**

[www.chingeltei.gov.mn/](http://www.chingeltei.gov.mn/)  
<https://www.facebook.com/chingeltteiduureg>

**Холбоо барих:**

Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба  
Утас:11-328558, 70110769

Хаяг: Чингэлтэй Дүүргийн Засаг даргын тамгын газар. Худалдан авах ажиллагааны алба 206 тоот өрөө



САЙН ЗАСАГЛАЛЫН ТӨЛӨӨХ  
САЙН ТҮРШЛАГА

## ОРОН НУТАГ

---



## ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**САЙН ТУРШЛАГА:** Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын жагсаалтыг гаргах, иргэдээс санал авах, эрэмбэлэх үйл ажиллагааг Иргэний нийгмийн байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэв.

Энэ нь иргэдээс ирүүлсэн саналд тулгуурлан төсвийн хөрөнгийг үр өгөөжтэй зарцуулах боломжийг бүрдүүлж, аливаа сонирхлын зөрчилтэй шийдвэр гарах нөхцлийг хязгаарлахад сайн туршлага болж чаджээ.

## “МИНИЙ САНАЛЫГ ЗААВАЛ ОРУУЛААРАЙ”

Архангай аймгийн Эрдэнэбулган сумынхан “Ногоон дэд бүтэд, эдийн засгийг хөгжүүлсэн, цэвэр тунгалаг устай, агаарын бохирдолгүй, сайн засаглалтай, ухаалаг иргэнтэй, цэцэрлэгжсэн ногоон хөгжлийн хотыг цогцлооно” гэж эрхэм зорилгоо тодорхойлжээ.

Зорилгодоо хүрэхийн тулд Сумын ЗДТГ, ИТХ, иргэний нийгмийн байгууллагуудтай хүч хавсран ажиллав.

2012 оны сүүлчээр шинэхэн Засаг дарга Э.Оюунчимэг томилогдон ажлаа эхлэв. 2013 оны сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын талаар иргэдээс санал авах, саналыг эрэмбэлүүлэх ажил тулгамдсан асуудал болсон байлаа.

Ингээд Сумын Засаг даргын нөөц сангаас 1,5 сая төгрөг шийдвэрлэн, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын

талаар иргэдээс санал авах ажлыг төрийн бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх саналыг шинэ оны зааг дээр гаргаж, иргэний нийгмийн байгууллагын сүлжээнд хандснаар ажил ундарч эхэллээ.

Баг тус бүр дээр нийгмийн бүхий л бүлгүүдийн оролцоог хангахыг Засаг даргын зүгээс зөвлөж, ТББ-ын сүлжээ удирдамжаа гарган, гэрээ байгуулав. Багийн засаг дарга нар иргэдээ цуглуулан оролцуулж, шинэ арга зүйгээр, өөрөөр хэлбэл төрийн оролцоогүйгээр асуудлыг гаргаж эрэмбэлүүлсэн байна.

Сумын иргэдийг шийдвэр гаргахдаа төрөөс хараат бус, нөлөөнд автахгүй байх нөхцлийг хангах зорилгоор уг ажлыг нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, идэвхтэй, төрийн бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлж чаджээ.

## **Хөгшөөн, багийн хуралдаа ирээрэй**

2013.01.03-08 Эрдэнэбулганыхан баг, багийнхаа хуралдаа оролцохоор сумын төв рүү айсуй. Энэ удаа өмнөх хурлуудаасаа харьцангуй сайн ирцтэй байлаа. Нэгдүгээр багт 110 хүн цуглав. Харин дөрөвдүгээр багийн хуралд 170 хүн оролцжээ.

Багийн иргэд дотроо хэд хэдэн бүлэгт хуваагдан, багийн нутаг дэвсгэрт байрлах бүх л байгууллага, өрхийн эмнэлэг, сургууль, цэцэрлэг, төрийн бус байгууллага, усан сан, үйлчилгээний газрууд халуун ус, гэр хороолол, орон сууц гээд бүгдийг нь нэг бүрчлэн шахам байршиж байгаа газрыг нь дүрслэн багийн зураглал гаргаж амжлаа.

Багийн зураглал гаргахад баг тус бүр дээр Мэдлэгийн сүлжээ, Залуучуудын холбоо, Мэдээлэл гэгээрлийн АЙ-ИСИ төв, Хоршооны сургалт мэдээллийн төв, ЛЭОС ТББ-ууд хамтран оролцов.

Дараа нь багийн зураглал дээрээ эдгээр байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг “юу нь болж байгаа, юу нь болохгүй байгаа тухай” “зад” шүүмжлэв. Бас заримыг нь сайшаав. Багийн иргэд ингэж нэг дороо цуглан, хоорондоо танилцаж, үнэн сэтгэлээсээ маргалдав. Нэн шаардлагатай, сайжруулах шаардлагатай үйлчилгээ гэж ялган гаргаж, төр, хувийн хэвшлийнхэн, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд юу хийх, ямар оролцоотой байхаа хамтран тодорхойлж чадлаа.

Хурлын удирдагч буюу Иргэний нийгмийн байгууллагынхан бүх иргэдийн тэгш оролцоог хангаж, хуралд ирсэн бүх хүнээр ямар нэгэн санал хэлүүлж чадсан байна.

“Иргэний нийгмийнхэн” фокус бүлгийн ярилцлага хийж, үйлчилгээний чанар хүртээмжийг яаж сайжруулах талаар харилцан ярилцаж саналаа жагсаан, хурлын шийдвэрээ гаргалаа.

Багийн хурлыг орон нутгийн телевизээр дамжуулсан болохоор өөрсдийн хийж байгаа зүйл, түүнчлэн ярилцлага нь гарсан иргэд баг, сум, аймаг орон нутгийн хөгжилд миний оролцоо, санал чухал юм байна гэдгийг илүү сайн ойлгож, өөрийн гаргасан саналдаа хяналт тавьж эхэлсэн байна.

Орон нутгийн телевизийн үзэгчдийн тоо ч нэмэгдэж, санал, шүүмжлэл хэлдэг хүмүүсийн тоо эрс өслөө.

Багийн иргэдийн нийтийн хурал зохион байгуулалтынхаа арга барилыг өөрчилж, хуралд ирээрэй гэж урьдаг байсан бол, одоо иргэдэд тухайн хэлэлцэх асуудлынхаа талаар урьдчилан мэдээлж, ойлгуулснаар хурлын ирц хоёр дахин нэмэгдэж, цагтаа цуглардаг болжээ.

Багийн иргэдийн нийтийн хурлын ирц бүрдэхгүй байдаг муу дадал, зуршилаас ангижирч байна.

Багийн иргэдийн нийтийн хуралд багийнхаа хэрэгцээ тодорхойлоход





оролцож хараахан амжаагүй иргэдэд зар тараан урилга хүргүүлэв.

Тэгээд жагсаасан саналаа танилцуулж саналыг нь авав. Бүх саналаа эрэмбэлэн нэгтгэж, сумын ЗДТГ-т хүргүүлэв. Санал хураалтанд нийт зургаан багийн 690 гаруй хүн оролцов. Баг бүр 13-15 асуудлыг багцлан эрэмбэлжээ.

Иргэд ингэж асуудлаа тодорхойлох шатнаас нь эхлэн оролцоод ирэхээр нутгийн удирдлагынхандаа итгэх итгэл нь нэмэгдэж, үйл ажиллагаанд оролцох хүмүүсийн тоо өсчээ.

Багийн Засаг дарга нарын эрх мэдэл дээшилж, багт бага хэмжээний мөнгө ОНХС-гаас тавигдснаар багийн иргэд, иргэдийн бүлгүүд чадавхиж эхлэв. Багтаа хэрэгцээтэй зүйлээ хамтран шийдвэрлэдэг болсноор багийн тулгамдсан асуудал цөөрч, хийж байгаа зүйлдээ хяналт тавих хэмнэх асуудалд иргэд санаачилгатай оролцдог болов. Хандлага ч өөрчлөгдөж эхлэв.

ЗДТГ-аас ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал асуулгыг иргэдээс түүврийн аргаар авсан санал асуулгатай нэгтгэн засаг даргад танилцуулан, Сумын ИТХ-аар оруулан батлуулав.

Иргэд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажилд оролцож, хяналт тавьдаг болсон. Аймгийн болон сумын мэдээллийн нээлттэй утсанд холбогдож, санал хүсэлтээ илэрхийлэх нь нэмэгджээ. Ингэж, 2013 оны сумын ОНХС-гийн санхүүжилтээр хийгдэх ажлууд амжилттай "тодорлоо". Төрийн бус байгууллагынхан хийсэн ажлын тайлангаа гаргаж өгөв.

Хуралд оролцож байгаа зарим иргэд нийтийн эрх ашиг ярихаасаа илүү хувийн ашиг сонирхлоо тэргүүнд нь тавьж байсан хандлага ажиглагдсан. Иргэний нийгмийн байгууллагынханы зөвлөх үйлчилгээний хөлс бага, ихэнхийг цайны зардалд зарцуулаад таарсан. Хугацаа богино байсан болохоор ТББ-уудын өөрсдийнх нь

ОНХС-гийн санхүүжилтээр хийгдэж болох, болохгүй ажлын талаарх болон дүрэм журмын талаарх ойлголт бага байсан талаараа тэд тайландаа илэн далангүй дурьдсан байна.

### **Манай багт ямар ажил хийгдэх нь вэ ?**

2013 онд НЭГДҮГЭЭР БАГТ нэг асуудал буюу гэрэлтүүлэг нийт 57.000.000 төгрөгийн санхүүжилт, ХОЁРДУГААР БАГТ хоёр асуудал буюу Бурхан багшийн сэрэг дүрийн засвар үйлчилгээ 6.249.666 төгрөг, Төв гудамжны нийтийн эзэмшлийн зам талбай, хайс шинэчлэл 75.947.132 төгрөг, ГУРАВДУГААР БАГТ гудамжны гэрэлтүүлэг 34.000.000 төгрөг, Хүүхэд залуучуудын төв талбайн тохижилт 259.800.000 төгрөг, ДӨРӨВДҮГЭЭР БАГТ гудамжны гэрэлтүүлэгт нийт 73.000.000 төгрөгийн санхүүжилт, ТАВДУГААР БАГТ гэрэлтүүлэг, ЗУРГААДУГААР БАГТ нийтийн халуун ус, ахуйн цогцолбор үйлчилгээ зэрэг ажлыг хийхээр төсвийг хуваарилав.

2014 оны хувьд бүх багийн хог ачих, тээвэрлэх устгах зориулалтын хогны дөрвөн машин, нийтийн бие засах газар барих (багийн хурал болгон дээр гардаг санал) зэрэг асуудлыг хийхээр шийдвэрлэв.

Сумын ЗДТГ-ын хамгийн том худалдан авалт болох сургуулийн үдийн цай, сургууль, цэцэрлэгийн дотуур байрны хоолны зардалд жилдээ 650.000.000 төгрөгт эргэлддэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тухай хуулийн хэрэгжилт, төсвийн шинэ хуулийн хэрэгжилтийг хангуулж, орон нутгийн иргэд, иргэдийн бүлэг, хоршоо нөхөрлөлүүд хөгжих, өрсөлдөх боломжийг олгож, тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг болсон.

Энэ нь орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж,

бүлгүүдийн тоо нэмэгдэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хүртээмж сайжрах, боломжтой болсон.

Жишээ нь: 2013 онд махны чиглэлээр гурван ААН,иргэд оролцож байсан бол 2014 онд 13 ААН, иргэн, сүү сүүн бүтээгдэхүүн хийдэг хоёр ААН,бүлэг байсан бол ес болж өссөн. Жил ирэх тусам жижиг бүлгүүд нэгдэж том үйлдвэрлэл эрхлэх боломж бүрдэж байна.

Сумын төвийн гудамжны мэдээллийн том самбараар болон, орон нутгийн сонин, телевизээр, байгууллагын урсдаг зарын самбараар тендерт шалгарсан байгууллага,мөнгөн дүн, хийж байгаа гүйцэтгэлийн явцын талаар мэдээлэл бэлтгэж орон нутгийн иргэдэд мэдээлэл хүргэснээр, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажил,ажлын төсөв, санхүүжилт, тендерт шалгарч гүйцэтгэж байгаа байгууллага иргэдэд ил тод боллоо.



### **“Дугтарвал хүч” нэг буюу ажлын үр дүн гарч эхлэв.**

2014 оноос эхлэн багийн засаг дарга иргэдийн бүлэг, иргэдтэйгээ хамтран тулгамдсан асуудлаа шийдвэрлэж байхаар ЗДТГ-аас баг тус бүрт 9,5 сая төгрөгийг олгожээ.

Гуравдугаар багынхан малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор Хөвсгөлөөс төл мал хуц,ухна авчирч нутагшуулж байна.

Дөрөвдүгээр багийн гэр хорооллынхон хад чулуу ихтэй, хатуу хөрстэй газар нутагладаг. Тэд чулуурхаг газраа ухаж

дийлэхгүйгээс муу усны цооног гаргаж чадахгүй, угаадсаа ил задгай асгадаг байсан бол сумын ОНХС-аас 9,5 сая төгрөгөөр газар ухдаг хоёр компрессор авч иргэддээ үйлчилдэг болсоноор иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломж бүрдсэн.

Нэг, тавдугаар багийнхан хаягжилт, хоёрдугаар багийнхан хоёр гудамжинд гэрэлтүүлэг, зургаадугаар баг болон хөдөөгийн багт мал угаах хоёр ванн авчээ.

Зургаадугаар багт хүүхдийн цэцэрлэгийн халаалтыг шийдвэрлэснээр хүүхдүүд цэцэрлэгтээ дуртай явдаг, аймгийн төвөөс хүүхдээ өгөх хүний тоо нэмэгдэж, эцэг,эх багш, хүүхдүүд сэтгэл ханамжтай үйлчилгээг хүртэж байна.

ОНХС-гийн хөрөнгө оруулалт бий болсноор орон нутгийн эрх мэдэл, оролцоо нэмэгдэж, орон нутгаа хөгжүүлэх боломж бий болж эхэллээ. Иргэд олноороо цуглараад тулгамдсан асуудлаа яриад гарцаа тодорхойлдог болж байна.

Хийж байгаа ажлыг нутгийн удирдлагатай хамтрагч хянадаг болж байна. Иргэд өөрсдөө оролцоод бүтээлч харилцаа үүсээд ирэхээр орон нутаг хөгжих боломж бүрддэгийн жишээг Архангайн Эрдэнэбулганыхан харууллаа.

### **Лавлагаа холбоос:**

arkhangai.gov.mn  
www.arkhangai.mn

### **Холбоо барих:**

Ц.Нарантуяа Архангай аймгийн  
Эрдэнэбулган сумын ЗД-ын туслах,  
хэвлэл мэдээлэл, сургалт хариуцсан  
ажилтан  
Утас: 99853664  
Электрон шуудан:  
tsetserleg\_city@yahoo.com  
tuya9966@yahoo.com

## ДАРХАН-УУЛ АЙМАГ



### ХЭВЛЭЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ХОЙД БҮСИЙН ТӨВ

**САЙН ТУРШЛАГА:** Хэвлэлийн хүрээлэнгийн хойд бүсийн төв, мэдээллийн “Орхон XXI” төв хамтран “Ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэхэд иргэдийн оролцоо” радио хэлэлцүүлгийг 2013 оны эхний улирлаас 2014 оны гуравдугаар улирлыг дуустал Дархан-Уул аймгийн Дархан сумын иргэдийн дунд зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн сэдвээр радио цуврал 10 бүлэгт нэвтрүүлэг бүтээж, “Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай”, “Авлигын эсрэг хууль”-ийн бүх бүлэг заалт бүрээр мэргэжилтнүүд оролцон иргэд олон түмэнд ойлгомжтой энгийн хэллэгээр хуулийг тайлбарлажээ.

## “ХӨСРИЙН ӨВСГҮЙ ЦЭЦЭРЛЭГ”

Судалгааны багийн ажилтнууд Дархан сумын “Мангирт” багийн иргэдийн нийтийн хуралд оролцоод, тэндээсээ хуучин Дарханы “Тосгон” багт хүрч очив. Тосгоноос цаашлан “Ширээ нуруу”-ны айлуудаар оров.



Иргэн Ж.Ням-Очир хэлэхдээ “Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийг сайн сурталчилмаар байна. Тэгвэл бид чинь өөрөө мэдэхээс гадна бусад хүмүүст хэлж туслах нь чухал” гэж байхад иргэн Б.Алтанзул “Иргэдэд хууль ойлгуулах ажлыг төр, хуулийн байгууллага хангалтгүй хэрэгжүүлж байгаа үед төрийн бус байгууллага, хэвлэлийнхэн л шүүрч авч хиймээр байна” гэлээ.

Иргэн Г.Номин “Иргэд бид чинь өөрсдөө авлигатай тэмцэх хуулиа мэдэхгүй бол хүнд сурталтнуудад дээрэлхүүлсээр байгаад, хашаагаа цэвэрлэхгүй, зэрлэг хөсрийн өвсөндөө даруулчихсан аятай л болно” гэсэн юм.





“Тосгон”-ны нэгдүгээр багийн иргэн О.Цэцэгмаа “-Авлигын эсрэг хуулийг олон нийтэд радиогаар нэвтрүүлэн сонсож хэлэлцүүлгийн аргаар сурталчилвал илүү үр дүнтэй” гэсэн бол 13-р багийн иргэн С.Бямбаа “-Хөдөлмөрийн хууль, нийгмийн даатгал, халамжийн тухай хуулиудыг урьд нь радиогаар нэвтрүүлсэн нь олон хүнд хүрсэн. Энэ аргыг ашиглахыг санал болгов.

Шинэ Дарханы 13-р багийн иргэн Ж.Оюутбилэг хэлэхдээ “Манай Дарханыхан урьд нь “Эзэн суух эрх” гэсэн радио жүжиг сонссон. Авлигын эсрэг сэдэвтэй тун сонирхолтой жүжиг. “Орхон-106” радио үүнийг явуулсан. Ийм туршлагатай радиогаар авлигын эсрэг хуулийг нэвтрүүлмээр байна” хэмээв. Хуулийг радиогаар нэвтрүүлэх нь зүйтэй хэмээн нийтдээ 124 хүн санал гаргажээ.

Хүрээлэнгийн ажилтнууд “Ашиг сонирхлын зөрчил, авлигын эсрэг хууль”-ийг Дархан сумын иргэдэд мэдээллийн хамгийн шуурхай хэрэгсэл болох FM радиог ашиглан түгээхийн зэрэгцээ сонсогчдын дунд дээрх хуулиудаар хэлэлцүүлэг өрнүүлэх зайлшгүй шаардлагатай гэж тогтон ажлын баг бүрдүүлэв.

Хэлэлцүүлгийн багтаа судлаач, эрх зүйч, хуульч, сэтгүүлчдийг оруулжээ. Багаараа бүтэн сар хэлэлцэж

байж үйл ажиллагааны иж бүрэн хөтөлбөр боловсруулав. Хөтөлбөрөө “Ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэхэд Дархан сумын иргэдийн оролцоо” радио хэлэлцүүлэг гэж нэрлэжээ. Хийсэн төслөө АНУ-ын “Азийн Сан”-д илгээв. Төслийн саналыг нь судалж үзээд шалгаруулжээ. Эхний амжилтандаа урамшсан хэлэлцүүлгийн баг шууд л ажилдаа орлоо.



### Авлигын эсрэг радио долгион

“-Хөөе, жолооч оо, наад радиогаа чангалаарай. Хэрэгтэй юм явж байна, сонсьё” хэмээн хижээл насны эр арын суудлаас хэлэв.

Радиогийн дуу өндөрсөхөд албан тушаалтан авлига авсан тухай олж мэдсэн иргэн хүн хаана хэнд хандаж мэдээлэх үүрэгтэй талаар ярьж байв. Хоёр хүн хоорондоо энгийн хүүрнэж байгаа энэ яриа нь хүмүүст их ойлгомжтой сонсогдоно.

Зогсоол дээр буухаасаа өмнө өөр нэг эмээ “-Гурван буудал явахдаа их хэрэгтэй юм сонслоо. Гэртээ очиж радиогоо сонсдог хэргээ хө” гэв. Хуучин Дарханы “Тосгон”-оос “Дархан” их дэлгүүр хүрэх замд микро автобусны радио хүлээн авагчийн нэвтрүүлэг сонссон зорчигчдын яриа энэ.

Хэвлэлийн хүрээлэнгийн хойд бүсийн төв, мэдээллийн “Орхон XXI” төв хамтран “Ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэхэд иргэдийн оролцоо” радио хэлэлцүүлгийг 2013 оны эхний улирлаас 2014 оны гуравдугаар

улирлыг дуустал Дархан-Уул аймгийн Дархан сумын иргэдийн дунд зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийн сэдвээр радио цуврал 10 бүлэгт нэвтрүүлэг бүтээж, “Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай”, “Авлигын эсрэг хууль”-ийн бүх бүлэг заалт бүрээр мэргэжилтнүүд оролцон иргэд олон түмэнд ойлгомжтой энгийн хэллэгээр хуулийг тайлбарлан ярив.

Нэвтрүүлэгт Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтнууд, Дархан-Уул аймгийн төрийн албан хаагчид, иргэдийн төлөөлөл оролцож санал бодлоо илэрхийлэв.

Радио нэвтрүүлгээ Дархан хотын “Орхон-106”, “Лха тэнгэр”, “Бизнесийн радио”-гаар нэвтрүүлжээ.

Дархан сумын гуравдугаар багийн иргэн Б.Төмөрбаатар “-Авлигын тухай радио нэвтрүүлгийг би гэртээ нэг удаа сонссон. Тэгээд тэр нэвтрүүлгийг өөрөө дахин сонсох, мөн энэ удаа сонсож амжаагүй гэрийнхэндээ сонсгохын тулд би хүүгээрээ гар утасных нь дуу хураагч дээр хэрэгтэй хэсгийг нь бичүүлж авч үлдсэн юм.

Тэгтэл тэр ч хэрэг болсонгүй, радио нэвтрүүлгийн тухай зарлал “Аа Жи Би” телевизээр явж, дахин сонсгох цагийг нь мэдээлсэн учраас дараа нь бид давтан сонссон. Би урьд нь сонсохдоо дутуу ойлгосон хуулийн заалтуудыг нь дахин сонсож байж бүрэн ойлгосон. Авлигын эсрэг хуулийг би багийн иргэдийн ярилцлага дээр бусдадаа тайлбарлаж өгсөн. Хүмүүс авлига гэж юу болох, урьдчилан сэргийлэх талаар зохих ойлголт авлаа гэж надад талархаж байна билээ. Хамгийн гол нь би өөрөө радиогоас олж авсан мэдлэгээ бусадтай хуваалцсанаар улам илүү бататгаж авсан. Радиогоар энэ нэвтрүүлэг явуулсан нь мэдээллийг ямар ч нөхцөлд шуурхай өгч байгаагаараа их ашигтай ажил боллоо” гэж үнэлжээ.



Нэвтрүүлгийг радиогоар явуулсаны зэрэгцээ дискэнд хувилж олшруулан авч явж тараан, гэр хорооллын иргэдийг нэг дор цуглуулж хөгжим тоглуулагчаар зохион байгуулалттайгаар сонсгов. Гудамж, хэсэг, хороогоор нь ингэж сонсгоход нэг удаа дунджаар 25 -110 хүн оролцжээ. Ийм уулзалт ярилцлагыг нийтдээ баг бүр дээр 12 удаа, нийтдээ 216 удаа хийжээ.

“Малчин” багийн иргэн С.Идэрчулууны гаргасан “-Малчдад авсаархан жижиг FM радио хүлээн авагч авчирч борлуулах ажлыг хийнэ үү. Тэгвэл радиогүй зарим өрхүүд авлигын тухай нэвтрүүлгээ алгасалгүй сонсох боломжтой болно” гэсэн хүсэлтийг ч хэлэлцүүлгийн баг биелүүлжээ.



*Зураг: Судалгааны багийн ахлагч хэвлэлийн хүрээлэнгийн хойд бүсийн зохицуулагч О.Хишигсүрэн*

Дархан сумын 18 багийн иргэдэд радио нэвтрүүлгээ зохион байгуулалттайгаар



сонсгож, “Ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэхэд иргэдийн оролцоо” сэдвээр чөлөөт хэлэлцүүлгийг өрнүүлж, мэдээллээс алслагдсан “Малчин” багийн иргэдтэй УИХ-ын гишүүн С.Ганбаатартай хамтран нээлттэй ярилцлагыг 2014 оны зун дөрвөн удаа зохион байгуулав.

Таван улирлын турш хийсэн хэлэлцүүлэгт авлига илүү ихээр нуугдаж байгаа гэж үзэж шүүмжлүүлсэн хэлтэс, агентлагуудын удирдлагуудыг иргэдтэй нүүр тулан уулзуулж, иргэдийн асуултанд хариулт өгүүлэх зорилготой “Төвлөрсөн нээлттэй хэлэлцүүлэг”-ийг Дархан-Уул аймгийн “Иргэний танхим”-д зохион байгуулав.

Дархан-Уул аймгийн төрийн байгууллагад Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийн биелэлтэнд Дархан сумын “Тосгон”, “Мангирт” багийн иргэдийг оролцуулан хөндлөнгийн хяналт тавьсан үйл ажиллагаагаар “Авлигагүй Дарханы төлөө” радио нэвтрүүлгийг бүтээж “Орхон-106”, “Шинэ долгион” радиогаар нэвтрүүлэв.

Энэ радио нэвтрүүлэг нь, Олон Улсын Авлигатай тэмцэх өдрийг угтан, Авлигатай Тэмцэх Газраас зарласан улсын уралдаанд 21 аймгийн радио бүтээлүүдээс тэргүүн байр эзэлж “Өргөмжлөл” шагнал хүртлээ.



### **Иргэдийн гинжин хэлхээ**

“-Намайг идэвхтэй гэж үзэж бусад иргэдэд нөлөөлөх үүрэг өгсөн. Надад

энэ ажил их сонирхолтой санагдаж, айлуудаар явж, гудамжинд уулзах зэргээр 14 иргэнд авлигын тухай хуулийг тайлбарлаж ойлгуулсан. Үр дүнд нь тав биш бүр найман иргэн цаашаа бусдадаа авлигын тухай мэдлэгээ түгээж байгаа.

Авлигын хэлэлцүүлгийн нөлөөгөөр хүмүүс өөрчлөгдөөд эхэлчихлээ”. Нөлөөллийн арга үр дүнгээ өгөөд эхэлчихлээ. Албан тушаалтны шударга бус үйлдлийг таслан зогсооход багийн иргэд оролцож эхэлсэн нь үүний баталгаа. Шинэ Дарханы 16-р багийн иргэн Ц.Амартүвшин нь, Дархан сумын 18 баг бүрээс оролцооны чадамжтай таван иргэнийг сонгож, мэдээллээс алс хол амьдардаг, идэвхи санаачилга мэдлэг чадваргүй иргэдэд туслах “Нөлөөллийн гинжин хэлхээ” үйл ажиллагааг явуулсаны үр дүнг ингэж үнэлж байна.

Сумын хэмжээнд идэвхтэй нэг иргэн нь бусад таван иргэнд нөлөөлж, хүн бүр дахин цаашаа таван иргэнд тусалж ажилласнаар нийт 450 идэвхтэй иргэдийн сүлжээ бий болгож чаджээ. Үүний үрээр Дархан сумын иргэдийн оролцоо 2013 оны гуравдугаар сарынхаас 2014 онд 30 хувиар өссөн. Идэвхжсэн иргэд нь “Нөлөөллийн гинжин хэлхээ” -г цаашдаа тасралтгүй үргэлжлүүлэх бололцоотой.

Ашиг сонирхол, авлигын хуулиар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд ямар ч үед цаашдаа үргэлжлүүлэн ашиглах радио нэвтрүүлэг, аудио материалтай болж авлаа.

Радио нэвтрүүлгийг сонссон Дархан сумын иргэд, хуулиудыг энгийн үгээр тайлбарласан учир ойлгоход амар хялбар гэж үнэлсэн. Энэ радио нэвтрүүлгийг цаашдаа аль ч аймаг хотын радиогаар нэвтрүүлж олон нийтэд сонсгох бүрэн боломжтой. Радио нэвтрүүлгийг FM радиогаар 16 сарын турш долоо хоногт гурван удаагийн давталттайгаар нэвтрүүлж, Дархан

сумын 18 багийн насанд хүрсэн 42 600 гаруй иргэн хүлээн авч сонслоо. Радио цуврал нэвтрүүлгийг айл өрхийн FM радио хүлээн авагч, хот доторх нийтийн тээврийн автобус, такси, автомашины радио хүлээн авагч, хөгжим тоглуулагч, гар утас зэрэг төхөөрөмжөөр олон нийт хүлээн авч сонгох ажлыг хэлэлцүүлгийн баг хариуцаж ажилласнаар, 2014 оны сонсогчдын тоог 2013 оныхоос даруй 12 400 сонсогчоор нэмэгдүүлж чаджээ. Нэвтрүүлгийг Дархан сумаас гадна Орхон, Хонгор, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын иргэд хүлээн авч сонсож байна.

Хэлэлцүүлгийн таван үе шатны хугацаанд нийтдээ 1480 иргэнээс төрийн албан тушаалтнуудын авлига, ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой 84 санал шүүмжлэл гарсныг Дархан сумын Иргэдийн Хурлын ажилд тусгуулахаар хүлээлгэж өгчээ. Санал шүүмжлэлийг нэг бүрчлэн хянан шалгаж 12 албан хаагчдад хариуцлага хүлээлгэжээ.

“Тосгон” багийн иргэдтэй хийсэн хэлэлцүүлэг дээр Хараа голын эргийн дагуу элс хайрга олборлож байгаа барилгын материалын аж ахуйнууд нь, байгаль орчныг сүйтгэж байна” гэж иргэн С.Мөнхтуяа, В.Жамъянсүрэн нар шүүмжилжээ. “-Аж ахуй, компаний эзэд нь зохих зөвшөөрөл олгодог байгууллагын удирдлага, байцаагч нарын гарыг хүндрүүлж, танил, найз нөхдийн шугамаар тэдэнтэй хуйвалдан олборлолт явуулах зөвшөөрөл олж

авсан” гэж мэдэгджээ. Энэ мэдээллийн мөрөөр аймгийн Мэргэжлийн Хяналтын Албанаас шалгаж элс хайрга олборлож байсан таван аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоов.

Хэлэлцүүлэгт оролцсон “Малчин” багийн иргэн Ч.Баттүвшин, Л.Мандах нар нь “-Газрыг албан тушаалтнууд авлига авч авалцаж өгөлцөж, нууцаар наймаалж байна” гэж шүүмжилсэн. Мэдээллийг УИХ-ын гишүүн Д.Хаянхярваа, С.Ганбаатар, аймгийн Засаг Дарга С.Насанбат нарт хүргүүлжээ. Үр дүнд нь газрын нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулж, Дархан хотын төвийн “А” зэрэглэлд, 15-р багийн нутаг дэвсгэрт байрлах “Дархан” зочид буудлын зүүн талын зургаан хуваарьт газрыг, 20 аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг оролцуулан үнэ хаялцуулан худалдлаа.

Дарханчууд “Бурхантын хөндийн цэцэрлэгээ хөсрийн өвснөөс” цэвэрлэж байна.

### **Холбоо барих :**

О.Хишигсүрэн. Хэвлэлийн хүрээлэнгийн хойд бүсийн төвийн зохицуулагч

Утас: 9937-2699.

Электрон шуудан:

orkhon106@gmail.com

Шуудангийн хаяг: Монгол Улс.

Дархан-Уул аймаг.

Төв шуудан. ш/х - 246.

# ДОРНОД АЙМАГ



## ДОРНОД АЙМГИЙН ЛИБЕРАЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОЮУНЫ САН

**САЙН ТУРШЛАГА:** Либерал эмэгтэйчүүдийн Оюуны сан төрийн бус байгууллага нь Дорнод аймгийн худалдан авах үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж буй эсэхэд хөндлөнгийн хяналт хийн, оршин буй дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулах, ил тод нээлттэй болгох зорилгоор хийсэн судалгаа, аргачлал, үр дүнг тодорхойлон, дүгнэлт хийж цаашид хэрэгжүүлэх санал, санаачилга дэвшүүлсэн нь сайн туршлага болохуйц үйл ажиллагаа болжээ. Тиймээс уг үйл ажиллагааг Сайн засаглалын төлөөх шилдэг туршлагаар шалгаруулан Авлигатай тэмцэх газраас “Авлигаас ангид, Сайн засаглалын туршлага-2013” өргөмжлөл хүртсэн байна.

## ДОРНОДЧУУД ТЕНДЕРИЙГ “ТЭНГЭРЭЭС БУУЛГАЖЭЭ”

Засгийн газар “Шинэчилж шийдье-222” уламжлалт уулзалтаа 2013 оны арванхоёрдугаар сард “Шилэн тендер” сэдвийн дор зохион байгуулж байв. Энэ уулзалтын үеэр Ерөнхий сайд Н.Алтанхуяг болон Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргал нар бизнес эрхлэгчидтэй нүүр тулан уулзаж тендер тойрсон зөрчил, будлиан, хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх гарцын талаар ярилцсан юм. Олон нийтийн зүгээс хамгийн их шүүмжлэл хүлээж, хардалт дагуулдаг худалдан авах үйл ажиллагааг хэрхэн ил тод, нээлттэй, шударга болгох вэ гэдэг асуултад хариулт хайсан нь энэ.

Засгийн газрын түвшинд яригдсан

дээрх асуултад Дорнодчууд өөрсдийн ухаалаг, зөв шийдлээрээ хариулт өгч чаджээ. Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан/ЛЭОС/-гийн Дорнод аймгийн салбар зөвлөлөөс санаачлан худалдан авах үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд мониторинг хийж, дутагдал, зөрчлийг илрүүлэн, үүндээ үндэслэн тендер шалгаруулалтыг ил тод, нээлттэй, хариуцлагатай болгох зорилгоор нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан байна. Ингэхийн тулд 2014 оны хоёрдугаар сарын 21-нд Дорнод аймгийн төв Хэрлэн сумын ИТХ-ын дэргэд Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөл/ХҮОНЗ/-ийг байгуулжээ.

Энэхүү зөвлөл нь орон нутгийн төрийн бус байгууллагуудын гурван төлөөлөл,

Хэрлэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас томилсон иргэний төлөөлөл гурав, сумын ИТХ-ын төлөөлөгч хоёр хүнээс бүрдсэн нийт долоон гишүүнтэй. Мөн Хэрлэн сумын 10 багт сайн дурын таван ажлын хэсэгт нийт 25 хүн ажилладаг.

Ийм бүтэц, бүрэлдэхүүнтэй байгуулагдсан олон нийтийн зөвлөл улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдэд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх, иргэд олон нийтээс худалдан авах үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгаа авах, төрийн байгууллагуудад хандан зөвлөмж гаргах зэрэг олон ажлыг хийж гүйцэтгэжээ.



***ЛЭОС-гийн Дорнод аймгийн салбар зөвлөлийн тэргүүн, Дорнод аймгийн ИТХ-ын дэргэдэх Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөлийн дарга Д.Бүжинтэй ярилцлаа.***

**-Тендерийн үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн байгууллагууд хяналт тавих, мэдээлэл авах боломж хомс байдаг. Танай аймгийн хувьд төрийн худалдан авах үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож чадсан юм**

**байна. Энэ бол тийм ч хялбар бүтэх ажил биш. Асуудлыг шийдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл юу байв?**

-ЛЭОС-гийн Дорнод аймгийн салбар зөвлөлөөс орон нутгийн ТББ-уудтай хамтран АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон Азийн сангийн дэмжлэгтэйгээр “Худалдан авах ажиллагааны мониторинг”-ийн төслийг хэрэгжүүлсэн юм. Энэ төслийн хүрээнд гарсан дүгнэлт, санал санаачилга дээр үндэслэн орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд тодорхой ажлууд хийж байгаа. Үүний нэг нь аймгийн ИТХ-ын дэргэд Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөл байгуулсан явдал.

Төрийн худалдан авах үйл ажиллагаа, тендер шалгаруулалтыг тойрсон ямар их шүүмжлэл, хардлага, зөрчил дутагдал байдаг билээ. Энэ бүхнийг өөрчлөхийн тулд хөндлөнгийн хяналт бий болгож, ил тод байдлыг хангах ёстой гэж бид үзсэн. Ингээд Дорнод аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөлөөс улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотой хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх бүтэц бий болгох талаар Хэрлэн сумын ИТХ-тай хамтран ажиллах санал оруулсан. Энэ саналыг хүлээн авч Хэрлэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөлийн ажиллах журам, бүтэц, бүрэлдэхүүнийг баталсан.

Үүний дагуу Хэрлэн сумын ИТХ-ын дэргэд Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөл байгуулагдсан. Хэрлэн сумын ИТХ-аас ХҮОНЗ-ийн 2014 оны үйл ажиллагааны зардал болох 12 сая төгрөгийг Хэрлэн сумын төсөвт суулгаж, эхний шатны хяналт үнэлгээний ажлын зардал 6,6 сая төгрөгийг Хэрлэн сумын Засаг даргын нөөцийн сангаас шийдвэрлэсэн.

### **-ХҮОНЗ байгуулагдсанаасаа хойш ямар үйл ажиллагаа явуулав?**

-Бид Хэрлэн суманд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулсан.

Хөндлөнгийн хяналт, үнэлгээний ажлын хэсгийн гишүүдэд төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр эрх зүйн мэдлэг олгож, мониторинг хийх аргачлалын талаар сургалт зохион байгуулаад байна. Энэ бол Хэрлэн сумын ИТХ болон Худалдан авах ажиллагааны албатай хамтран зохион байгуулсан ажил.

Хяналт, үнэлгээний олон нийтийн зөвлөлөөс ажлын хэсгийн гишүүдтэй хамтран 2014 оны гуравдугаар сарын 15-наас дөрөвдүгээр сарын 21-нийг хүртэлх хугацаанд Хэрлэн суманд хэрэгжсэн 7,2 тэрбум төгрөгийн санхүүжилттай 61 ажлыг хамруулан, гэрээний гүйцэтгэлд хяналт үнэлгээний ажлыг хийсэн. Үүнд, тендер шалгаруулалтаар гүйцэтгэсэн ажлуудын чанар, үр дүнгийн талаар сэтгэл ханамжийн судалгаа хийж иргэд болон ашиглагч байгууллагын төлөөлөл болох 1326 хүнийг хамруулсан.

Иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг дүгнэж үзэхэд Хэрлэн сумын хэмжээнд төсвийн болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудын талаар иргэд ерөнхий мэдээлэлтэй байдаг бөгөөд хийгдэж байгаа ажлууд нь хэрэгцээ шаардлагатай ажлууд мөн гэсэн байр суурь илэрхийлсэн байсан. Бараа, ажил үйлчилгээний чанарыг үнэлэхдээ иргэдийн 13 хувь нь маш сайн, 33 хувь нь сайн, 28 хувь нь дунд, 24 хувь нь муу гэж хариулсан байгаа нь иргэдийн сэтгэл ханамж тийм ч сайн биш байгааг илтгэх үзүүлэлт юм.

### **-Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа бодит байдалтай хэр нийцэж байх юм?**

-Иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгаан дээр үндэслэн ХҮОНЗ-ийн ажлын хэсгийн гишүүд дээрх бүх ажлыг газар дээр нь явж үзэн, чанарын үнэлгээ өгсөн. Ингээд үзэхэд А буюу үнэхээр чанартай хийгдсэн ажил огт байхгүй байсан. Нийт бараа, ажил үйлчилгээний 43 хувь нь сайн буюу боломжийн хийгдсэн ч анхаарах олон асуудлууд дагуулж байсан юм. Дунд буюу хангалтгүй, муу буюу чанаргүй гүйцэтгэлтэй гэж үзсэн ажлууд 57 хувьтай байгаа нь тендерээр хийгдэж байгаа ихэнх бараа, ажил, үйлчилгээ хангалтгүй, чанарын хувьд муу гүйцэтгэлтэй байна гэж ажлын хэсэг дүгнэсэн.



*Зураг: Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөлийн ажлын хэсгийн гишүүд худалдан авах ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлуудтай танилцаж байгаа нь*

### **-Худалдан авах үйл ажиллагаанд хийсэн хяналт үнэлгээний ажлын тайлангаа төрийн байгууллага болон олон нийтэд хэрхэн хүргэдэг вэ?**

-Хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах, зөвлөмж гаргах зэрэг хэлбэрээр олон нийтэд хүргэдэг. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Хэрлэн суманд хэрэгжсэн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд хяналт үнэлгээний ажлыг гуравдугаар сарын 15-наас дөрөвдүгээр сарын 20-ны хооронд хийж, хөндлөнгийн



хяналт үнэлгээний эхний шатны ажлын хэлэлцүүлгийг дөрөвдүгээр сарын 21-ны өдөр Хэрлэн сумын Иргэний танхимд зохион байгуулж хяналт үнэлгээний ажлын дүнг хэлэлцсэн.

Мөн дээрх хөндлөнгийн хяналт үнэлгээний эхний шатны ажлын тайлангийн хурлыг дөрөвдүгээр сарын 25-ны өдөр Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгуулсан. Энэ хуралд Хэрлэн сумын ИТХ-ын дарга, төлөөлөгчид, худалдан авах ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагууд, гүйцэтгэгч болон ашиглагч байгууллагуудын төлөөлөл, иргэд, Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөл болон ажлын хэсгийн гишүүд оролцож санал солилцсон.

**-Тендер шалгаруулалт хардлага, хэл ам дагуулахаас гадна тендерээр ажил гүйцэтгэсний дараа чанарын асуудал мөн л шүүмжлэлд өртдөг. Та бүхний хяналт, үнэлгээний үр дүнд илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах талаар тендерийн ажил гүйцэтгэгч компаниуд хэр санаачилгатай ажиллаж байна вэ?**

-Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөлөөс ажлын хэсгийн гишүүдтэй хамтран 2012-2013 онд Хэрлэн сумын есөн багт хэрэгжсэн 932 326 900 төгрөгийн санхүүжилттэй “Спорт тоглоомын талбай байгуулах” ажлын гүйцэтгэлд хяналт үнэлгээний ажлыг хийсэн. Илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулах талаар холбогдох төрийн байгууллагын удирдах ажилтнуудад танилцуулах уулзалт зохион байгуулсан. Тухайн байгууллагууд зөрчил дутагдлаа арилгах талаар санаачилгатай ажилладаг.

**-Танай ХҮОНЗ-өөс гаргасан зөвлөмжид дээрх зөрчил дутагдлыг арилгах талаар саналууд туссан уу?**

-Тийм. ХҮОНЗ-ийн ажиллах журамд “Хяналт үнэлгээний олон нийтийн зөвлөлийн тайланг сумын ИТХ-д

мэдүүлж, холбогдох шийдвэр, залруулга, арга хэмжээг сумын ИТХ-аар гаргуулж ажиллах болно” гэж заасан байдаг. Энэ дагуу хяналт, үнэлгээний ажлын тайлангаа бид сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулснаар, холбогдох шийдвэрийг гаргасан.

Худалдан авах ажиллагааны хяналт үнэлгээний ажлын хүрээнд иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгаа, санал асуулга, ашиглагч байгууллага болон иргэдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага, ХҮОНЗ болон ажлын хэсгийн гишүүд хамрагдсан хэлэлцүүлэг, төрийн болон хувийн хэвшил, иргэдийн дунд зохион байгуулсан ХҮОНЗ-ийн эхний шатны ажлын тайлангийн хурал зэрэг ажлуудын дүгнэлтэд тулгуурлан зөвлөмж гаргасан.



*Зураг: Худалдан авах ажиллагааны хүрээнд хийсэн хяналт үнэлгээний ажлын дүн танилцуулах хэлэлцүүлэг.*

**-Та бүхэн цаашид ямар ажлууд хийхээр төлөвлөж байна вэ?**

-Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн бараа, ажил, үйлчилгээний үр дүнг сайжруулах талаар Хэрлэн сумын ИТХ-аас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.

Мөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд Хэрлэн суманд хэрэгжиж буй худалдан авах ажиллагааны явцад хяналт үнэлгээ хийхээр төлөвлөөд байгаа. 2015 оны төсвийн төсөлд санал авах, хэлэлцэх, батлах үйл явцад иргэдийн оролцоо

хангаж буй эсэхэд хяналт үнэлгээ хийнэ.

Сайн болон чанартай хийгдэж байгаа ажил үйлчилгээг олон нийтэд таниулж, сурталчилах, хангалтгүй болон чанаргүй хийгдсэн ажлуудыг чанаржуулж, сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахаас гадна энэ үйл явцыг хуулийн дагуу, ил тод нээлттэй, хариуцлагатай болгоход нөлөөллийн арга хэмжээ авч ажиллах нь бидний зорилго. Дорнод аймгийн бусад сумдад төрийн болон төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн бараа ажил үйлчилгээний хэрэгжилтэд иргэдийн зүгээс хяналт тавих бүтцийг бий болгоход нөлөөллийн ажиллагаа явуулна. Энэ талаар бид зөвлөмждөө тусгасан байгаа.



Иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын санал, санаачилгаар байгуулагдсан Хяналт, үнэлгээний олон нийтийн зөвлөл Дорнод аймгийн хэмжээнд 2013 онд зарлагдсан худалдан авах ажиллагааны тендерүүдийн хэрэгжилт, гүйцэтгэлд анх удаа хяналт тавин, зохих зөрчил дутагдлуудыг илрүүлж, тэдгээрийг засч залруулах арга зам, шийдлийг төр захиргааны байгууллага болоод гүйцэтгэгч байгууллагуудад зөвлөмж болгожээ.

Энэ бол иргэддээ нээлттэй, ил тод, сайн засаглалыг төлөвшүүлэхэд чиглэсэн сайн туршлага. Одоо Дорнодын иргэдэд

тендер гэдэг “тэнгэрийн юм” байхаа больжээ.

ХҮССЭН ЦАГТАА тэд ХҮОНЗ-өөр дамжуулан төрийн худалдан авах үйл ажиллагаа болон тендер шалгаруулалтын талаар мэдээлэл авах боломж нээлттэй. Тендерийн дагуу хийгдсэн ажлуудын гүйцэтгэлийн талаар мэдээлэл авах, санал шүүмжлэл гаргахад хүлээн авч уламжлан шийдвэрлэх бүтэц бий болсон. Юутай ч Хэрлэн сумын ИТХ-ын дэргэд байгуулагдсан ХҮОНЗ хөндлөнгийн хяналт тавьснаар орон нутагт төрийн болон төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн чанар, үр дүнг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулжээ. Нөгөө талаар энэ бол төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавихад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ил тод, нээлттэй байдлыг хангахад чухал түлхэц болсон санаачилга байв.

### **Холбоо барих:**

Д.Бүжин ЛЭОС-гийн Дорнод аймаг дахь салбарын тэргүүн.  
Хэрлэн сум. 7-р баг.  
Нарлагийн 29 тоот.  
Утас: 99286761

# ӨВӨРХАНГАЙ АЙМАГ



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**САЙН ТУРШЛАГА:** Өвөрхангай аймаг хөдөө аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбаруудыг хөгжүүлж, орон нутгийн хөгжил дэвшилд хувийн хэвшлийн оролцоо дийлэнх хувийг эзэлж, бүтээн байгуулалт, бизнесийн цар хүрээ өдрөөс өдөрт өргөжин тэлж байна.

Тус аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж байна. Энэхүү арга хэмжээнд иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй оролцсон бөгөөд төрийн ачааллыг багасгахад иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлд үр дүнтэй сайн туршлага болж чаджээ.

## ТӨРИЙН АЧААГ ХӨНГӨЛСӨН ИРГЭНИЙ НИЙГМИЙНХНИЙ ОРОЛЦОО

Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчин манай улсад 21 жилийн өмнө бүрэлдсэн юм. 1993 онд батлагдсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд "Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно" гэсэн заалт бий.

Төрийн хүнд ачааг хөнгөлөх, ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд ийнхүү төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх нь чухал ач холбогдолтой.

Үүнийг ажил хэрэг болгож, амьдрал дээр үр дүнг нь үзсэн төрийн байгууллага бол Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар. Тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс санаачлан төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх ажлыг 2013 онд эхлүүлжээ.

**Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Ч.Батсуурьтай ярилцлаа.**

**-Өвөрхангай аймгийн хувьд төрийн бус байгууллага хэр олон бэ. Тэдгээр байгууллагын үйл ажиллагаа ямар түвшинд байна вэ?**

-Манай аймгийн хэмжээнд бүртгэлтэй 80 гаруй төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод бий. Тэдгээрээс 20 нь үйл ажиллагаагаа тогтмол явуулдаг, санхүү, эрх зүйн зохицуулалт, хүний нөөцөөр хангагдсан. Манай аймагт төрийн бус байгууллага, иргэний нийгмийн зөвлөл 2005 оноос эхлэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж, төрийн байгууллага, иргэний нийгэм, иргэдийн төлөөлөл бүхий гурван талт түншлэлийн үйл ажиллагаагаар дамжуулан хэлэлцүүлэг, иргэний нийгмийн зөвлөл зэрэг санаачилгыг амжилттай туршин хэрэгжүүлсэн.

Иргэний нийгмийн байгууллагын сүлжээ байгуулагдсанаар орон нутгийн төрийн бус байгууллагууд хамтрах, харилцан туршлага судлан, нээлттэй ажиллахад ихээхэн ач тусаа өгч байгаа. Үүний нэг илрэл нь төрийн ажил үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байгаа явдал юм.

**-Төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх энэ ажлыг хэрхэн зохион байгуулав?**

-Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн "Чиглэл батлах тухай" 2008 оны 22 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2012-2016 оны "Бүтээлч Өвөрхангай" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх төрийн ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулж байгаа. Дээрх тогтоол шийдвэрүүдийн хүрээнд энэ ажлыг хийх эрх зүйн орчин бүрдсэн гэсэн үг. Тиймээс бид аймаг,

орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд төрийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх ажилд төрийн бус байгууллагуудын төслийг сонгон шалгаруулж, санхүүжилтийг олгон, гүйцэтгэлд хяналт тавин ажилладаг.

Орон нутгийн төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх төрийн ажил үйлчилгээний жагсаалтыг жил бүр гаргадаг болсон. Жилээс жилд төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлэн, иргэд, иргэний нийгмийн байгууллагаас төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих нөхцлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

**-Танай аймгийн хэмжээнд өнгөрсөн оноос энэ ажлыг эхэлсэн гэсэн. 2013 онд хэдэн байгууллагатай гэрээ байгуулж ажилласан бэ?**

-2013 онд төрийн байгууллагуудын төсөл сонгон шалгаруулах ажлын саналыг нэгтгэн, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар нээлттэй зарласан.

Ингээд нийт 5 байгууллагын 24 төслийн саналыг хүлээн авч, төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгээр хэлэлцүүлэн төслийг шалгаруулсан. Нийт 10 төрийн бус байгууллагаар 17.040.000 төгрөгийн ажил гэрээгээр гүйцэтгүүлээд байна.

**-Төрийн ямар чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэв?**

-“Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан” /ЛЭОС/ ТББ-ын “Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах нь” төслөөр орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад иргэдийн саналыг авах, эрэмбэлүүлэх, үнэлгээ өгч арга зүйн зөвлөгөө боловсруулах ажлыг хийлгэсэн.

Энэ бол маш шинэлэг бөгөөд үр дүнтэй

ажил болсон. Өмнө нь иргэд орон нутагтаа хийгдэж байгаа төсвийн хөрөнгө оруулалтад санал өгдөггүй байсан. Орон нутгийн хөгжлийн сан байгуулагдсанаар иргэд ийм эрхтэй болсон. Үүнийг ЛЭОС-гийнхан маань амжилттай хэрэгжүүлсэн.

Мөн “Эрүүл омогшил” ТББ-ын “Согтууруулах, мансуурах, донтох өвчтэй 30 иргэнд хийх сургалт” төслийн хүрээнд Арвайхээр хотын 30 иргэн, гэр бүл, архинаас гарах сургалтад хамрагдан, архинд донтох өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид хамтран ажиллахаар болсон.

Энэ бол өнөөгийн нийгэмд хамгийн тулгамдсан асуудал болоод байгаа архидан согтуурахын эсрэг оновчтой, зөв аргаар тэмцэх жишиг болж чадсан гэж бид үзэж байгаа.

“Инээмсэглэж буй гэр бүл” ТББ-ын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн сэтгэлгээ хандлагыг өөрчлөх сургалт” зохион байгуулах төслийг бид дэмжсэн. Аймгийн Ахмадын хорооны “Хотжих соёлд суралцуулах иргэдийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтуудыг зохион байгуулах” төслөөр хотын соёлыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэд, ЕБС-ийн сурагчдад сургалт, мэдээлэл хийх зэрэг ажлыг хийсэн. Энэ мэтээр 10 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж үр дүнг нь тооцсон.

**-Худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг төрийн бус байгууллага амжилттай хэрэгжүүлсэн гэж дуулсан. Энэ талаар тодруулаач?**

-2012-2014 онуудад “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан” ТББ-аар улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр гүйцэтгүүлж буй авто зам, барилга угсралт, их засвар, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх ажлын талаар иргэдийн дунд хэлэлцүүлэг явуулж, санал хураан эрэмбэлсэн.

Үүнийгээ аймаг, сумын хөрөнгө оруулалтын жагсаалт гаргахад тусгаж төрийн байгууллага, иргэдийн уялдааг сайжруулан, арга зүйн зөвлөмжөөр ханган ажилласан.

Ингэснээр иргэд худалдан авах ажиллагаанд оролцох, үнэлгээний хороонд идэвхтэй хандах, тендерийн үйл ажиллагааг ойлгох, иргэд эерэгээр нөлөөлж, тэдгээрийг авто зам,



бүтээн байгуулалтын тендерт биечлэн оролцох, хяналт тавих боломж бүрдсэн. Энэ ажлын хүрээнд гүйцэтгэгчид хийх ажлын зөвлөмж хүргүүлэн, зөрчил дутагдлыг арилгуулсан.

Иргэд төрийн худалдан авах ажиллагаанд оролцон, тодорхой хяналт тавих болсноор гүйцэтгэлийн чанар, уялдаа холбоо сайжирсан давуу талууд ажиглагдаж байгаа.

**-Төрийн бус байгууллагуудтай байгуулсан гэрээгээ хэрхэн дүгнэдэг вэ. Ажил гүйцэтгэх явцад нь хяналт тавьдаг уу?**

-Төрийн бус байгууллагуудаар ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэхдээ гэрээний төсөлд санал авах, үйл ажиллагааг нь төрийн болон хувийн хэвшил, и р г э д т э й х о л б о х о д д э м ж л э г үзүүлэх, үр дүнгийн тайлан т а в и у л а х , м э д э э л э л

Хөгжингүй орнуудад төрийн чиг үүргийн 60-70 хувийг нь иргэний нийгмийн байгууллагууд гүйцэтгэдэг туршлага бий. Манай засаг захиргааны байгууллагууд ч гэсэн энэ чиг хандлага руу шилжих эхний алхмуудыг хийж байна.

солилцох хэлбэрээр ажиллаж, дүгнэсэн. Ингэснээр төр, төрийн бус байгууллагын хамтын үйл ажиллагаа сайжирч байна. Мөн мэргэжлийн холбоодоор сургалт, семинар зохион байгуулах, түншлэлийн арга хэмжээ, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байгаа.

Хариуцлагатай, сайн засаглалын төлөөх төр, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийг бэхжүүлэхийг чухалчилж байгаа энэ үед орон нутгийн төр захиргааны байгууллагуудын сайн туршлагыг энд онцлохыг хичээсэн юм. Сонгож авсан Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын хувьд төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж байгааг дээрх ярилцлагаас мэдэрсэн байх.

Энэ бол төр, иргэний нийгмийн

байгууллагуудын түншлэлийн нэг тод жишээ, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж буй сайн жишиг юм.

Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын тогтвортой үйл ажиллагаа, ажлын хариуцлага, ур чадвар, хүний нөөц, санхүүгийн чадавхи зэрэг тулгамдсан асуудлууд хамтын үйл ажиллагаанд зохих хэмжээгээр нөлөөлж байгаа ч Өвөрхангай аймгийн хэмжээнд төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсэн ажлуудын үр дүн сайн байгаа ажээ.

Тусаймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн бус байгууллагууд төрийн чиг үүргийг гэрээгээр хэрэгжүүлэхийн тулд

тодорхой шалгуур, ажлын туршлагыг харгалзан үзэж, нийгмийн салбар бүрт өөрийн онцлог, давуу тал, бүтээлч санаачилгыг өргөжүүлэхэд анхаарч ажилладаг.

Орон нутагт төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоор гэрээгээр гүйцэтгүүлснээр төрийн ажил үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, түншлэлийг хэрэгжүүлэх, харилцан итгэлцлийг бий болгож чаджээ.

Энэ талаар Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Ч.Батсуурь хэлэхдээ “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийг орон нутгийн хөгжлийн асуудалд бүтээлчээр хандахад нөлөөлөн иргэд, иргэний нийгмийн байгууллагын

харилцан уялдаа, төрийн үйлчилгээ, үр дүн, чанарт оролцох хөндлөнгийн хяналтын механизмыг сайжруулж байна.

2012, 2013 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр баригдсан бүтээн байгуулалтын ажилд иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөллөөр гүйцэтгэлд нь хөндлөнгийн хяналт тавьсан нь үр дүнгээ өгч, барилга угсралт, автозамын шинэчлэлтийн чанар сайжирч байсан нь төрийн бүхий л үйлчилгээнд оролцох, иргэдэд зөв хандлага төлөвшүүлэхэд санаачлагатай ажлуудын нэг болсон” хэмээн өгүүлсэн юм.

Өвөрхангай аймгийн засаг захиргааны байгууллагын зүгээс цаашид төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхэд ажлын арга барил, туршлага, санаачилгыг нэмэгдүүлэхээс гадна төрийн хяналт мониторинг, хөндлөнгийн судалгаа шинжилгээ, дүгнэлт хийх ажлыг хийлгэх зорилт тавин ажиллаж байгаа ажээ. Ингэхийн тулд орон нутгийн төрийн бус байгууллагуудыг бэхжүүлэх, чадавхижуулах асуудал нэн тэргүүнд тавигдаж байгааг тэд онцолж байлаа.

Сайн засаглал гэдэг бол төр хүчирхэг, нүсэр байхын нэр биш, харин төрийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод,

шударга, хариуцлагатай, хүртээмжтэй байж, иргэдийн оролцоо, иргэний нийгмийн түншлэлийг бий болгохыг хэлнэ.

Төрийн ачааг хөнгөлсөн Өвөрхангайнхны туршлага ийм сайн жишгийг тогтоохын төлөөх бодитой алхам болжээ. Хөгжингүй орнуудад төрийн чиг үүргийн 60-70 хувийг нь иргэний нийгмийн байгууллагууд гүйцэтгэдэг туршлага бий. Манай засаг захиргааны байгууллагууд ч гэсэн энэ чиг хандлага руу шилжих эхний алхмуудыг хийж байна.

Ингэхийн тулд иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхижуулахад төрөөс анхаарах шаардлагатай. Төр бол бүхнийг хийдэг, бүхнийг чаддаг шидтэн биш. Харин сайн менежер байх ёстой гэдэг. “Том төрөөс ухаалаг төр рүү” хэмээх Ерөнхийлөгчийн уриалгын утга санаа ч үүнд оршиж буй билээ.

### **Холбоо барих:**

Ч.Батсуурь Өвөрхангай аймгийн  
Засаг даргын Тамгын газар, Төрийн  
захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах  
мэргэжилтэн  
Утас: 70323990

# ӨМНӨГОВЬ АЙМАГ



## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**САЙН ТУРШЛАГА:** Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бүх мэдээллийг электрон самбараар олон нийтэд сурталчилан таниулдаг болсоноор нээлтэй, ил тод байдлыг хангаж чаджээ. Мөн өөрийн байгууллагын ачаалал хөнгөрч, ажлын бүтээмж дээшилсэн байна.

## ХУРААР ДУТАВЧ МЭДЭЭЛЛЭЭР ЦАНГАХГҮЙ ӨМНӨГОВЬЧУУД

Өмнөговь бол манай улсын хамгийн том нутаг дэвсгэртэй аймаг. Нийт 165 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 58555 хүн амтай гэхээр суурьшил маш сийрэг. Гэхдээ энэ нь төр захиргааны байгууллагын ачаалал бага гэсэн үг биш.

Өмнөговь аймаг Монголын өнөө, ирээдүйн хөгжлийн нэг гал голомт болж буй. Уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, томоохон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа Өмнөговь аймагт үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжин, дэд бүтэц сайжран суурьшлын бүс тэлсээр байна.

Энэ бүхэн орон нутгийн засаг захиргааны ачааллыг нэмсээр байгаа ажээ. Газар зохион байгуулалт, барилга, хот

төлөвлөлтийн ажлууд Өмнөговь аймагт сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдэж байгаа.

Эрдэнэсийн их үүцээ нээсэн өмнийн говийн өөрчлөлт ийнхүү хүн зоно ахуй амьдрал, төр захиргааны байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж байна. Цаашид Өмнөговь аймгийн төв улам өргөжин тэлнэ. Эдийн засаг нь эрчимжинэ. Төсөв санхүү нь арвижна. Ийм л өөдрөг төсөөлөл, зураглал харагдаж байна. Шинэ суурьшлын бүсүүд тэлж, аймгийн төв, суурин газрууд өргөжих тусам тэр бүхнийг төлөвлөн, зураг төслийг нь гаргах ажлыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар гардан хийдэг. Хөгжлийн зургийг тэд гаргана гэсэн үг. Өөрөөр хэлбэл, тус газар бол орон нутагт барилга хот байгуулалт, газрын

харилцааны салбарын төрийн бодлогыг хэрэгжүүлэгч агентлаг юм. Энэ ажил амаргүй. Нэг талаас асар их хэл ам, хардалт, шүүмжлэл дагуулдаг. Тэр ч байтугай иргэдийн эсэргүүцэлтэй ч тулгарна.

### **Ачаалал хөнгөлсөн электрон самбар**

Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар аймаг орон нутгийн хөгжлийн гол бодлогыг хэрэгжүүлж ажилладаг тул ажлын ачаалал өндөр. Газрын харилцаа болон барилгын асуудлыг шийдвэрлэдэг нэг мэргэжилтэн л гэхэд өдөрт дунджаар 20 хүнтэй харилцана. Түүнээс гадна төлөвлөгдөөгүй гэнэтийн ажлаар хөдөө орон нутагт томилолтоор явах нь олон. Энэ бүх ажлын ачаалал болон дээрх хүчин зүйлүүдээс шалтгаан иргэдийн зүгээс хүссэн мэдээллээ хангалттай авч чадахгүй байх тохиолдол цөөнгүй.

Тиймээс олны дунд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрынхныг хүнд суртал ихтэй гэсэн ам дамжсан яриа гардаг байв. Нөхцөл байдал ийм байжээ.

Байжээ гэдгийн учир нь дээрх хүндрэл өнөөдөр арилсан гэдгийг хэлэх гэснийх. Энэ таагүй нөхцөл байдлыг ө ө р ч и л с ө н

арга зам, шийдэл нь бусад засаг захиргааны байгууллагуудад үлгэр жишээ болохуйц юм. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ажилтан, мэргэжилтнүүд ажлын ачаалал их, ирсэн хүн бүртэй тэр бүр тулж харилцан, хүссэн мэдээллийг нь өгч, тайлбарлах боломж, цаг зав хомс тул иргэдэд хэрэгтэй мэдээллийг нь 100 хувийн чанартайгаар хэрхэн өгөх вэ гэдэг боломжийг судалжээ.

Ингээд иргэд хэрэгцээтэй, шаардлагатай мэдээллээ бусдын амнаас сонсох биш

өөрсдөө сонгож олж авах шийдлийг санал болгох нь зүйтэй гэж үзсэн байна. Үүнд орчин үеийн мэдээллийн технологийг ашиглахаар шийджээ. Аймгийн хэмжээний газар эзэмшил, өмчлөл болон бусад бүх мэдээллийг электрон самбарт байршуулах тооцоо судалгааг хийж, ажил хэрэг болгосон байна. Электрон дэлгэц оруулж ирдэг аж ахуйн нэгж, компаниудыг судлаад саналаа албан ёсоор тавьж худалдан авалт хийжээ.

Ийнхүү богино хугацаанд touch буюу мэдрэмтгий дэлгэцийг байгууллага дээрээ байршуулан тухайн дэлгэцэд иргэдэд хэрэгтэй бүх мэдээллийг бүрэн оруулжээ.

### **Хөлөө чилтэл хүлээхгүй, хуруугаа цуцтал хайлт хийнэ**

Газрын харилцаа, газар зохион байгуулалт, газар өмчлөл, эзэмшил, барилга, хот байгуулалттай холбоотой бүх мэдээллийг электрон самбарт байршуулснаар төрийн байгууллагын ажлын ачаалал эрс багасчээ. Иргэдийн санал гомдол, шүүмжлэл ч буурсан байна. Электрон самбарыг ашиглан хүссэн мэдээллээ олж авах арга зарчим нь тун энгийн.

Уг самбарын бүх Мэдээллийг Барилга хот байгуулалт, Газрын харилцаа гэсэн үндсэн хоёр бүлэгт багцалсан бөгөөд энэ хоёр ангиллаар дамжин цааш нэвтэрч хэрэгцээт мэдээллээ чөлөөтэй олж авах боломжтой.

Өмнө нь иргэд газрын харилцааны мэргэжилтнүүдийн үүдийг сахин хөлөө чилтэл зогсч байж лавлагаа, тодруулга авдаг байсан бол одоо электрон дэлгэцийг хуруугаараа илбээд л хэрэгцээт мэдээллийнхээ сан руу

нэвтэрдэг болсон байна. Хуруу нь цуцахгүй л бол хэчнээн ч хугацаагаар хайлт хийж, ямар ч мэдээллийг олж авч болно. Иргэдэд чирэгдэлгүй үйлчилгээ гэвэл энэ. Нөгөө талаар энэ бол мэдээллийн ил тод байдлыг хангасан томоохон ажил юм.

Төр захиргааны байгууллагын үйлчилгээ төвөг чирэгдэлтэй байхаа больсны тод жишээ Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт ийнхүү биелэлээ олов.

Үүний үр дүнд иргэд төрийн үйлчилгээнд хамрагдах гэж цаг заваа гарздахгүйгээр хүссэн мэдээллээ олж авдаг болсон бол Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтнүүд дээр ирдэг иргэдийн тоо буурч, тэдний нэг өдөрт гүйцэтгэх ажлын үр дүн бүтээмж нэмэгдэж, илүү чанартай, илүү их ажил хийж гүйцэтгэдэг болсон байна.

Мэдээллийн электрон самбарт тус агентлаг хуулиар хориглоогүй, өөрөөр хэлбэл Төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад бүхий л мэдээллийг тавьдаг ажээ. Хувь хүний өмч болох газартай холбоотой мэдээллүүдийг холбогдох төрийн байгууллагаас нь албан ёсны зөвшөөрөл авсны дараа тавихгүй бол эргээд хувь хүний нууцыг задрүүлсан гэдэг асуудал үүсэх магадлалтайг өнгөрсөн хугацаанд туршлагаасаа мэдэж авчээ. Тиймээс иргэний хувийн өмч газартай холбоотой асуудлыг тагнуулын байгууллагын албан ёсны зөвшөөрөлтэйгөөр электрон дэлгэц дээрээ суурилуулсан байна.

Говьд ус гэдэг чандмань эрдэнэ. Хур

бороо ганц нэгхэн дусах төдийд л таана нь хэнзэлдэг тийм л нутаг. Байгаль дэлхий ингэтлээ хур чийгээр ангаж байдаг шиг иргэд мэдээллээр цангах учиргүй. Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрынхан мэдээллийн ил тод байдлыг бий болгож, иргэдийнхээ мэдээлэл авах эрхийг хангаж чадсанаар мэдээллийн урсгалыг нээлттэй, хүртээмжтэй болгожээ. Цаасан мэдээллийн зудыг халж, цахим мэдээллийн санг үүсгэсэн электрон самбар яах аргагүй шилдэг туршлага.

### **Холбоо барих:**

Өмнөговь аймаг. ЗДТГ. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар  
Хаяг: Өмнөговь аймаг.  
Даланзадгад сум,  
Нутгийн удирдлагын ордон  
108-113 тоот  
Утас: 70532800, 70532917





## УВС АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА

**САЙН ТУРШЛАГА:** Увс аймгийн Худалдан авах ажиллагааны алба нь Худалдан авах ажиллагааны шалгаруулалтыг ил тод болгох, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр дүнтэй ашиглаж, өрсөлдөөний тэгш байх нөхцлийг хангах зорилт тавин ажиллаж байна. [www.uvstender.mn](http://www.uvstender.mn) цахим хуудас нээж, аймгийн иргэдэд худалдан авах ажиллагааны мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд ил тод түгээх боломжийг бүрдүүлж чаджээ.

## ЦАХИМ ТЕНДЕРЭЭР ЦАХИУР ХАГАЛСАН УВСЫНХАН

The screenshot shows the website interface with a navigation bar, a main content area with news articles, and a sidebar with a list of tenders. The news articles include:

- "Сайн засаглал" үндэсний форум Увс аймгаас Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зурханд хэрэгжүүлсэн туршлагаг хуваалцлаа.** - 2014-07-2
- АЗДТ-ийн Худалдан авах ажиллагааны албаас зохион байгуулсан тендер шалгаруулалтын үр дүнг ил тод байдлын мэдээлэл 8-р сарын 31-ны байдлаар...** - 2014 оны 9 дугаар сарын 9

The sidebar lists several tenders with their dates and categories, such as:

- Увс аймгийн Улаангом сумын 4-р цэцэрлэгийн барилгын засварын ажил гүйцэтгэх
- Улаангом сумын Б.Базарын баатарын галбины ажил гүйцэтгэх
- Хотын хөгжил цэцэргэлжүүлэгтэй газрын үйл ажиллагаанд зориулалтын хүчин чадал бүхий "КОВИШ" нийлүүлэх
- Газар эзэмшүүлэх зэргийн нээлттэй төслийг сонгож шалгаруулалтад урьж байна /ЗАРЖАА СҮМ/
- Увс аймгийн 9 сум /Ховд, Баянман, Завсга, Нэгдэрсэнгай, Зуусхангай, Малчин, Харгас, Баруунгууруун, Цэцээнсайхан/ -ын төмрийн тооцогтойн ажил гүйцэтгэх
- Увс аймгийн Зургинговь сумын тас газрын тусламж ажил гүйцэтгэх
- Сайн үр дүнтэй оид мал нийлүүлэх

### "Шилэн халаас"

2013 онд Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа төсвийн ил тод байдлыг хангахад чиглэсэн "Шилэн данс", "Шилэн тендер" зэрэг санаачлагууд гарч, төсвийн ил тод байдлын үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулан хэлэлцэж байсан үе билээ.

Энэ санаачилга орон даяар гарахаас арай өмнөхөн буюу 2013 оны хоёрдугаар сард Увс аймгийн Засаг дарга Д.Цэндсүрэн захирамж гаргаж, "Шилэн халаас" гэсэн арай өөр өвөрмөц содон нэртэй хөтөлбөр баталжээ. "Шилэн Халаас" хөтөлбөрийн гол зорилгод төрийн байгууллага, сумд, төсөвт газрууд худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах тухай тусгагдсан байна.

Орон нутгийн төсвийн ил тод байдлын 2013 оны судалгаанаас үзэхэд орон нутгийнхны Худалдан авах ажиллагааны албаны мэдээлэл төдийлэн хангалттай ил тод нээлттэй болж хэвшиж чадаагүй хэвээр байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө, тендерийн зар урилга, үр дүнгийн тайлангаа цахим хуудсанд цаг хугацаанд нь байршуулж хэвшсэн цөөн хэдэн аймгийн нэг Увс юм.

### **Өмнө нь...**

2013 оноос өмнө олон нийтэд төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийг түгээх ажил хүртээмж муу, энэ талаарх иргэдийн ойлголт мэдлэг төдийлөн сайн биш байв.

Ирэх онд аймаг орон нутагт нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ямар хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийгдэх, төсөвт байгууллагууд болон сумдад ямар хэмжээний төсөв, хөрөнгө оруулалт хуваарилагдсан талаарх тодорхой мэдээллийг олон нийт, бизнес эрхлэгчдэд хүргэх мэдээллийн тогтсон суваг байсангүй.

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүн, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг мэдээлэл нь хязгаарлагдмал хүрээнд зөвхөн холбогдох төрийн байгууллагын ажилтнуудад л хамааралтай байлаа.

Төрийн байгууллагаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүн зэрэг мэдээллийг олон нийтэд хүргэхэд зарим тохиолдолд хүндрэлтэй байжээ.

Тендерийн урилгыг орон нутгийн телевизээр зарладаг боловч бүх тендерийн урилгыг нэг бүрчлэн телевизээр зарлуулахад зардал өндөр. Тиймээс нээлттэй тендерийн урилгыг долоо хоног л зарладаг /Хуульд зааснаар 30 хоног зарлах ёстой/. Мөн

төвийн болон орон нутгийн сонинуудад тендерийн урилгыг нийтэлдэг боловч энэ нь хүртээмж муу байжээ.

Сангийн яамны [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn) сайтад тендерийн урилгууд нийтлэгддэг ч, орон нутгийнхан энэ сайтын талаар мэддэггүй шахам байв.



### **Одоо...**

“Шилэн Халаас” хөтөлбөрийн хэрэгжилтэнд АЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс хяналт тавьж ажилладаг. Уг хөтөлбөр батлагдсаны дараахан “Төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг сурталчилах аян” –ыг Мерси Кор Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан байна.

Төрийн байгууллагуудын дунд “Нээлттэй худалдан авалт” болзолт уралдаан зарлаж дүгнэв. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх хэвшил бий болгох эхлэл тавигдлаа.



*Зураг: Сумдын иргэний танхимийн ажилтан, албан байгууллага агентлагуудын өргөдөл гомдол хариуцсан ажилтнуудад цахим өргөдлийн системийг хэрхэн ашиглах талаар сургалт явуулж амжилттай өндөрлөлөө.*

## **www.uvstender.mn цахим хуудас нээв.**

Аяны хүрээнд хамгийн томоохон хийгдсэн ажлын нэг нь Увс аймгийн худалдан авах ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан бий болгох, худалдан авалтын бүх мэдээллийг олон нийтэд хүргэх мэдээллийн тогтсон суваг бий болгох зорилгоор. www.uvstender.mn цахим хуудсыг бий болгох явдал байв. Цахим хуудсыг ICOGS төслийн хүрээнд “Төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг сурталчилах аян”-ы ажлын хэсгийн гишүүдийн санаачлагаар Клоуднетворк ХХК хийж гүйцэтгэв.

Тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр хийх худалдан авах ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлэхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасантай уялдуулан эхэлсэн энэ ажил цагаа олжээ.

Худалдан авах ажиллагааны үйл явцад хөндлөнгийн хяналт үнэлгээ, мониторинг хийх орон нутгийн төрийн бус байгууллагууд чадавхиж, идэвхтэй ажиллаж эхлэв. Хөндлөнгийн байгууллагуудын хийсэн хяналт, үнэлгээ, мониторингийн тайланг цахим хуудсандаа тогтмол тавьж тэдний гаргасан заавар зөвлөмжийг ажилдаа хэрэгжүүлж байна.

Орон нутагт энэ цахим хуудсыг нээснээр хэрэглэгчдэд шаардлагатай мэдээлэл бүрэн утгаараа нээлттэй тавигддаг боллоо. Ингэснээр иргэд цаг хугацаа хожиж, төрийн үйлчилгээ түргэн шуурхай болж хүнд суртал багасна. Захиалагч ба гүйцэтгэгчдийн тендерт бэлтгэх цаасан зардал багасна. Мэдээлэл технологийн дэвшлийг ашиглах замаар худалдан авах ажиллагааны ил тодыг байдлыг цаг хугацаа, орон зайд хязгаарлагдахгүйгээр хүлээн авах бололцоотой болов.

“Төсвийн тухай” шинэ хууль батлагдаж, аймаг суманд хийгдэх хөрөнгө

оруулалт, бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг аймаг, бие даан зохион байгуулах болсон энэ үед аймгийн худалдан авах ажиллагааны мэдээллийн нэгдсэн системийг бий болгох зайлшгүй шаардлага гарсан юм. Төрийн худалдан авах ажиллагаа нь төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт, хяналт үнэлгээ гэсэн дөрвөн үе шатаар дамжин хэрэгждэг бөгөөд эдгээр үе шатуудын мэдээллийг нэг дор агуулсан мэдээллийн санг энэхүү цахим хуудсаар хангах зорилт тавин ажиллаж үр дүнгээ өгч байна.

Аймгийн хувьд худалдан авах ажиллагаа нь зөвхөн Худалдан авах ажиллагааны албаны ажил биш. 22 төсөвт байгууллага, 19 сумдын бүгдийнх нь үүрэг юм. Тиймээс эдгээр байгууллагуудад тус бүрд нь хэрэглэгчийн эрх үүсгэж тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүнг нийтлэх боломжоор хангалаа.

Цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл түгээх нь хавьгүй зардал багатай хүртээмж өндөр байгаа нь ажиглагдлаа. Одоогоор энэ сайтад сард 4500-5500 хүн хандаж мэдээлэл авч байна.

Аймгийн Худалдан авах алба нь захиалагч, гүйцэтгэгчдэд зориулсан цахим худалдан авалтыг хэрхэн зохион байгуулах талаар Мерси Кор Олон улсын байгууллагын санхүүжилтээр хоёр удаа сургалт зохион байгуулав.

## **Цахим тендерээр цахиур хагалав**

Үр дүнд нь орон нутгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 12 ААН-ийг цахим худалдан авах ажиллагааны MEPS системд бүртгүүлж, 2014 онд худалдан авалтын ажлын 23 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулжээ.

Увс аймгийн Худалдан авах алба жилд дунджаар 9-11 тэрбум төгрөгийн өртөг бүхий 50-70 төрлийн бараа ажил

үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг.

2014 оны наймдугаар сарын 31-ны байдлаар нийтдээ 12,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 61 төрлийн бараа ажил үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж 12,6 тэрбум төгрөгийн гэрээ хийгдсэнээр 136,7 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

61 тендер зохион байгуулахад давхардсан тоогоор нийдээ 105 компани тендер шалгаруулалтанд оролцож 67 компанитай ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх гэрээ хийсэн байна.

Энэ нь дунджаар нэг тендерт 1,7 компани оролцсон гэсэн үг. Зохион байгуулсан нийт тендерийн 13,1% нь зөвлөх үйлчилгээ, 50,8% нь нээлттэй тендер шалгаруулалт, 1,6% нь түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй, 32,7% нь харьцуулалтын аргаар 1,6% нь шууд гэрээ хийх аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулжээ.

Худалдан авах албаныхан ажлаа илүү сахилга баттай явуулахын тулд [www.uvstender.mn](http://www.uvstender.mn) цахим хуудсанд байгууллагын электрон шуудангийн үйлчилгээ нэвтрүүлээ.

Ингэснээр худалдан авах ажиллагааны ажилтнууд, үнэлгээний хорооны гишүүд, сумдын засаг даргын орлогчид болон төрийн байгууллагууд нэгдсэн стандарт электрон шуудангийн хаягтай болж иргэд болон аж ахуйн нэгжтэй зөвхөн худалдан авах ажиллагааны асуудлаар харилцах суваг нээгдлээ.

Урьд нь ашигладаг цахим шуудангийн хаяг нь хувийн болон албаны шуудантай холилдог, олон хүний хаягнаас ялгахад хэцүү, цээжлэхэд бэрхшээлтэй зэрэг хүндрэл учирдаг байсан.

Энэхүү электрон шуудан үйлчилгээ нь...@uvstender.mn хаягтай байх бөгөөд вирус болон спамын хамгаалалттайгаараа давуу талтай юм.

**Дүгнэлт:** Цахим худалдан авалтын тухай сургалтыг захиалагч болон гүйцэтгэгчдэд зориулан Мерси Кор Олон улсын байгууллагын санхүүжилтээр хоёр удаа зохион байгуулжээ. Сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдэд цахим хуудасны системийг ажиллуулах талаар сургалт хийсэн боловч, одоогоор бүгд жигд сайн хэрэглэж хэвшээгүй байна.

Тиймээс сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнууд болон, төсвийн байгууллагын худалдан авах ажиллагааг хариуцсан мэргэжилтнүүдийг байнга мэдээллээ оруулдаг болгож хэрэглэж хэвшүүлэх. Цахим хуудасны зарим цэснүүд нь мэдээлэлгүй хоосон байгаа тул мэдээллийн хэсгийг байнга шинэчлэх шаардлагатай нь ажиглагдлаа.

Цахим хөтчийн чадварыг сайжруулах, хяналт үнэлгээ тендерийн гүйцэтгэлийн мэдээллийг идэвхтэй болгох, хичээл сургалтын агуулгыг өргөжүүлэх ажлаа эрчимжүүлэхийг анхааруулья.

#### **Лавлагаа холбоос:**

[www.uvstender.mn](http://www.uvstender.mn)  
[www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn)

#### **Холбоо барих:**

Л.Цогтсайхан Худалдан авах ажиллагааны албаны дарга  
Утас 99456715,

Электрон шуудан:  
[tsogoo64@yahoo.com](mailto:tsogoo64@yahoo.com) /

В.Даваа.Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн  
Утас 99696869

Электрон шуудан:  
[anum\\_0730@yahoo.com/](mailto:anum_0730@yahoo.com/)

Х.Төртогтох – Мерси Кор Монгол ОУБ,  
Увс аймгийн түншлэлийн зохицуулагч  
Утас 99459150

Электрон шуудан:  
[turtogtoh@mn.mercycorps.org](mailto:turtogtoh@mn.mercycorps.org) /





## “ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ ТӨВ” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**САЙН ТУРШЛАГА:** 2006 онд байгуулагдсан, нийгэмд үйлчилдэг иргэний нийгмийн байгууллага. Хүүхэд залуучууд руу хандсан төрийн үйлчилгээнд хяналт үнэлгээ, судалгаа явуулах ажлыг эрхлэдэг. Энэ удаа тус байгууллагын Увс аймагт нэвтрүүлсэн “Цахим өргөдөл гомдлын систем [www.70452222.mn](http://www.70452222.mn)”-ийг онцолж байна.

## ИРГЭНИЙ ГОМДОЛ “ИЛ” ХАРАГДАНА

### “Миний өргөдөл хаана гацчихав”

Иргэнээс хүлээж авсан өргөдөл гомдлын хариуг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, эргэж хариуг нь өгдөггүй таг болчихдог хүнд сурталтнууд төрийн албанд байсаар л байна.

Иргэн хүн өөрийнх нь өргөдөл хүсэлт хэн гэдэг албан тушаалтан дээр ямар шалтгаанаар гацчихаад байгааг мэдэх боломжгүйдээ хамгийн их бухимддаг.

Нутгийн захиргааныхны эл хүнд суртлыг “халахаар” иргэдийн өргөдөл хүсэлтийг цахим системээр бүртгэж, хуулийн хугацаанд өргөдөл гомдлыг шийдвэрлэж байх, үйл явцыг түргэн шуурхай болгох, өргөдөл гомдлын шийдвэрлэх явц нь ямар шатандаа явж байгааг иргэд өөрсдөө хяналт тавьж байх нөхцлийг бүрдүүлж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах нөхцөл бүрдүүлэх явдал нь “Хүүхэд залуучуудын өрсөлдөх

чадварыг дэмжих төв” ТББ-ийнхны Увс аймагтаа хэрэгжүүлсэн “Цахим өргөдөл” төслийн зорилго байлаа.

### “Гацааг гаргахаар зүтгэсэн нь”

**Төслийн удирдагч Р.Итгэлийн өдрийн тэмдэглэлээс:**

**2013 оны гуравдугаар сард** “Хүүхэд залуучуудын өрсөлдөх чадварыг дэмжих төв” ТББ, аймгийн ЗДТГ-ын 7045-2222 дугаартай өргөдөл гомдол хүлээн авдаг утсыг цахим сайтад холбон ажиллуулахаар хамтарсан төслөө батлав.

**2013 оны дөрөвдүгээр сард** аймгийн ЗДТГ-тай дугуй ширээний уулзалт хийж, [www.70452222.mn](http://www.70452222.mn) домэйн нэр авахаар тохиролцож, төлбөрийг төслөөс урьдчилан хийлээ.

Уг нь ЗДТГ-ын санхүүжилтээр хийгдэх



байсан ч, гэрээ хийгдээгүй, санхүүжилт орж ирээгүй тул ажил удааширч байсан учраас ТББ-ын зүгээс энэ арга хэмжээг авсан. Программд орох байгууллагуудын жагсаалтыг хэлэлцэн гаргав.

**2013 оны тавдугаар сард** программыг байршуулж турших ажлын хүрээнд программ хангамжид 40 гаруй байгууллагын 450 гаруй хүний мэдээллийг бэлэн болгов.

... Ажлын эхэнд, төслийг санаачлагч ТББ-ынхан, ИТХ, Иргэний танхим, аймгийн ЗДТГ хамтран ярилцаж өргөдөл гомдлын цахим системийн ерөнхий зохион байгуулалт, хэрэглээний талаар программын ерөнхий ажлын даалгаврыг боловсруулж, программ хангамжийн компанитай гэрээ байгуулан системийг боловсруулан туршилт судалгаа явуулж, системд бүх төрийн байгууллага, албан тушаалтны мэдээллийг оруулж бүртгэлжүүлэв.

Цахим хандалтыг идэвхжүүлэхийн тулд хэвлэл мэдээллээр сурталчилгаа хийж, төрийн албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулав.

Фэйсбүүк хуудсаар дамжуулан сурталчилах зэргээр олон нийтэд хүргэх үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулжээ.

Үүний үр дүнд цахим өргөдлийн систем ашиглалтанд орсон эхний гурван сарын хугацаанд 5000 гаруй иргэн цахим хуудсанд хандаж мэдээлэл авсан байна.

Одоо тус цахим хуудсыг Иргэний танхим тогтворжуулан ажиллаж байна. Системийн үйл ажиллагааг илүү сайжруулах ажлыг аймгийн ЗДТГ хариуцан ажиллахаар шийдвэрлэжээ.

Энэ ажлыг аймгийн ЗДТГ, ИТХ, Иргэний танхимтай хамтран хэрэгжүүлсэн нь төслийн цаашдын тогтвортой байдал нь бүрэн хангагдах нөхцөл бүрдүүлжээ.

**Төслийн удирдагч Р.Итгэлийн өдрийн тэмдэглэлээс:**

**2013 оны зургаадугаар сард** Программыг байршуулж турших ажлын хүрээнд туршилтанд оролцох албан тушаалтнуудыг сонгож тэдний өмнөөс дүрд тоглон туршилт явуулав. Өргөдөл гомдлын системийг ашиглах гарын авлага бэлтгэж, туршилтанд оролцогчдод тараасан.

**2013 оны долдугаар сард** программыг байршуулж турших ажлын хүрээнд хэрэглэгчдийг facebook-ээс шууд нэвтэрдэг болгов. Мөн туршилтын хугацаанд оруулсан өгөгдлүүдийг устгаж, найман сарын нэгнээс эхлэн албан ёсоор бүртгэж эхлэхээр болов.

**2013 оны наймдугаар сард** сумдын иргэний танхимын ажилтнууд, байгууллагын өргөдөл гомдол хариуцсан ажилтнуудад программыг хэрхэн ашиглах талаар сургалт явууллаа. 36 хүн хамрагдав.


**Өргөдөл цахимаар хүлээж авна.**

...Увс аймгийн албан ёсны болон бусад цахам хуудсуудад цахим өргөдөл гомдлын системтэй шууд холбогдох холболтуудыг хийв.

Цахим өргөдөл гэсэн дэд сайт үүсгэжээ. Аймгийн засаг даргын захирамжийн дагуу хэлтэс агентлагын үйл ажиллагааг иргэдээр үнэлүүлэх, тэдний санал бодлыг сонсох ажилд цахим өргөдөл гомдлын систем хамтран оролцож байна.

Мөн Тариалан, Өмнөговь сумдад цахим өргөдөл гомдлын системээ сурталчилав. Цахимаар хандаж байгаа хэрэглэгчдийн тоог нэмэх үүднээс өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдлыг нь зургаар авч Увс аймгийн цахим хуудсуудад тавьсан. Мөн иргэдийн анхаарал татахуйц зарим санал, гомдлыг цахимаар тарааж энэ асуудлыг яаж шийдвэрлэх бол гэсэн

## хүлээлт үүсгэхийг зорилоо.



### "Нээлттэй" эсвэл "хаалттай"

### **Хийсэн ажлынхаа талаар төслийн удирдагч Р.Итгэл тун товчхон ийн хариуллаа:**

-Бүртгэлийн ажилтан иргэдээс ирүүлсэн санал гомдлыг бүртгэн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж шийдвэрлүүлдэг ч, хэнд, хэдийд очсоныг иргэн өөрөө асууж лавлахаас нааш мэдэх боломжгүй байв.

Цахим өргөдөл төсөл хэрэгжсэнээр иргэд өөрийн явуулсан санал гомдлыг холбогдох албан тушаалтанд хэдийд шилжүүлж, хэд хоногт хэрхэн шийдвэрлэгдсэнийг цахим хуудаснаас харах боломжтой болно.

Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчийн хариуцлага ил харагдаж байна гэсэн үг юм. Иргэний илгээсэн санал гомдлын ард "Нээлттэй" гэсэн таних тэмдэг байвал тухайн асуудал шийдвэрлэгдээгүй, "Хаалттай" таних тэмдэгтэй бол шийдвэрлэгдсэн байгааг илтгэнэ. Мөн тухайн санал гомдол ямар хэлбэрээр ирсэн нь харагдаж байх бөгөөд иргэд цахим хуудсанд бүртгүүлсэн кодоор нэвтэрнэ.

Иргэдийн хувьд бусад хүмүүсийн өргөдөл гомдлыг хэн хэрхэн шийдвэрлэж байгааг сонирхох боломжтой болсон. Өргөдөл гомдлын хүлээн авалтыг цахимжуулж чадсанаар

гар ажиллагаа, цааснаас цахим системд шилжсэн. Иргэдийн ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийн архив бүрдсэн. Мэдээллийн ил тод байдлыг хангахад шинэлэг арга хэлбэр нэвтрүүлж байгаа юм.

### **Иргэний гомдол "ил" харагдана**

### **Увс аймгийн ЗДТГ, засаг захиргааны байгууллагуудад ирүүлсэн өргөдөл гомдлын 2014 оны 3-р улирлын тайлангаас эшлэв:**

Аймгийн хэмжээнд 2014 оны 3-р улирлын байдлаар 11478 санал, өргөдөл, гомдол ирснийг бүртгэн авч 11236 буюу 97,89 %-ийг шийдвэрлэн хариу өгч ажиллалаа. Шийдвэрлэх шатандаа буюу хугацаа болоогүй 242 санал, өргөдөл, гомдол байна.


Газар хүссэн, газрын эзэмшил, ашиглалт, өмчлөлийн талаар, модны зөвшөөрөл хүссэн болон тэтгэвэр тэтгэмж, халамжийн санхүүжилт, тэтгэмжтэй холбоотой, ажилд орохыг хүссэн, мөнгөн болон эд материалын тусламж хүссэн өргөдөл ихээр ирсэн байна.

Аймгийн Засаг даргад болон Тамгын газарт хандаж 1674 иргэн өргөдөл, хүсэлт гаргасны 1639 санал, өргөдөл, гомдолд хариу өгч шийдвэрлэлт 97,9 % -тай байна.

35 өргөдөл, гомдол шийдвэрлэгдэх хугацаа болоогүй судлагдаж байна. Аймгийн Засаг даргад хандаж тусламж, гэр, ажилд орохыг хүссэн, халаалт, дулаантай холбоотой болон гудамж төсөлтэй холбоотой чөлөөлсөн газарт нөхөн төлбөр авах, газрын маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхийг хүссэн өргөдөл, санал, хүсэлтүүд ихээр ирсэн байна.

7045-2222 нээлттэй утсанд халаалт, дулааны шугамын засвар, халуун, хүйтэн ус үе үе тасарч байгаа талаар,

жишиг хороололын цахилгаан, усны асуудлыг шийдвэрлэж өгөх, худалдан авах ажилтай холбоотой мэдээлэл, Түргэн сумын эрүүл мэндийн төвд асрагч, Сагил сумын цэцэрлэгт туслах багшийн орон тооны талаарх гомдол гэх мэт асуудлаар холбогдож хариулт авчээ.



...Иргэний өгсөн өргөдөл газрын гаваар орсон юм шиг таг болчихдог байдал багасч, таны өгсөн өргөдлийн хариу энэ, ингэж шийдвэрлэж байна хэмээн эргэж хариу өгдөг боллоо.

### **Дүгнэлт:**

Төслийн багийнхны зорилго биелжээ. Хийснээ эргэн харахад дахиад л засч залруулмаар ажил ундраад эхэллээ.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн сар бүрийн хугацаа хэтрэлтийн тайлан мэдээг зөвхөн тоогоор биш, цаашид байгууллагаар нь харагддаг болгох. Ингэснээр хяналт тавих бүрэн боломжтой болно.

[www.70452222.mn](http://www.70452222.mn) цахим хуудаснаас буюу ЗДТГазраас бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлэсэн санал, өргөдөл, гомдлын тоог харуулдаг болох.

Тэгвэл аймгийн Засаг дарга, ЗДТГ тухайн сард шийдвэрлэсэн өргөдөл гомдлоо

ялгаж харах боломжтой болно.

Өргөдөл, санал, хүсэлтийг ангилдаг болох /Жишээ нь : Гэр хүссэн, тусламж хүссэн, ажилд орохыг хүссэн зэргээр ангилдаг, тоон үзүүлэлтээр гардаг болох/.

Иргэнээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд "... Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ." гэсэн заалтын дагуу хугацааг сунгах боломжоор хангах.

Цахим хуудсанд файл хавсаргахад гурваас доошгүй материал оруулдаг болох. Учир нь иргэний өргөдөл нэгээс илүү хуудастай ирэх тохиолдол элбэг байгаа зэргийг анхаарч, цаашид сайжруулах шаардлагатай байгаа тухайгаа төслийн багийнхан тайлангийн хуралдаа тавьлаа.

### **Лавлагаа холбоос:**

<http://www.70452222.mn/>

<http://www.uvs.gov.mn/>

### **Холбоо барих:**

Р. Итгэл Увс аймгийн Хүүхэд залуучуудын чөлөөт өрсөлдөөнийг дэмжих төв ТББ-ын тэргүүн  
Утас: 99459851

Электрон шуудан: [itgel2@yahoo.com](mailto:itgel2@yahoo.com)

Хаяг: Увс аймаг.Улаангом сум

2-р байр 64 тоот



## ХОВД АЙМГИЙН БУЯНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

### САЙН ТУРШЛАГА:

Буянт сумын төв нь Ховд хотоос 25 км зайд оршдог, зүүн талаараа Мянгад сум, урд талаараа Чандмань, Манхан сум, баруун талаараа Дуут сум, хойд талаараа Ховд сумтай хиллэдэг. Буянт сум нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд таван багаас бүрддэг. Халх, казах, тува, узбек үндэстэн, 10 гаруй ястнаас бүрдсэн 2647 хүнтэй 718 өрхтэйгээс 610 нь малчин өрх юм. Хүн амын дийлэнх нь мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг.

Сумын Засаг даргын Тамгын газар хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх, хөгжил дэвшлийн зохистой шийдвэр гаргах, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төв хөдөөгийн таван багийн иргэд болон төсөвт албан байгууллага, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн тус байгууллагуудад төрийн үйлчилгээ үзүүлж, зохион байгуулгаар хангах үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. Энэ чиг үүргийнхээ хүрээнд төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор төсвийн мэдээллийн самбарыг ажиллуулж эхэлсэн нь сайн туршлагаар нэрлэгджээ.

## ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАСАН БУЯНТ СУМЫН ТУРШЛАГА

Манай улсын төсөв тэлж, санхүүгийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага өндөрсөхийн хэрээр төсвийн ил тод, хариуцлагатай байдал, үр ашгийн асуудлууд чухлаар тавигдах болсон. Энэ чиглэлд төрийн байгууллагууд нэлээд анхаарч, төсвийн мэдээллийг ил тод болгох, төсөв боловсруулах үйл явцад олон нийтийг оролцуулах алхмуудыг хийж байв. 2013 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай

хуульд энэ үйл ажиллагааг идэвхжүүлэх нөхцөлүүд туссан юм. Мөн 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн болон төсвөөс санхүүждэг байгууллагын ил тод байдлыг хангах, иргэн, хуулийн этгээд эдгээр байгууллагаас мэдээлэл авах үйл явцыг зохицуулсан. Уг хуулиар үйл ажиллагаа, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах мэдээллээ нээлттэй байлгах үүргийг төрийн байгууллагуудад ногдуулж, иргэн,

хуулийн этгээд төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан юм.

Сайн засаглалыг бэхжүүлэх нэг чухал нөхцөл нь төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх явдал гэж үздэг. Төсвийн мэдээллийг ил тод болгож, төсвийн зарлагыг тайлагнадаг болсноор нийгэмд итгэлцэл бүрдэж, зах зээлийн эрсдэл ба мэдээллийн тэнцвэртэй бус байдал буурч, зах зээл илүү үр дүнтэй ажиллах боломж бүрддэг.


Төсвийн ил тод байдлыг төсвийн тайлагналт тодорхой, найдвартай, давтамжтай, цаг үеэ олсон, оновчтой байх, сум орон нутгийн бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь олон нийтэд нээлттэй байх гэж тодорхойлсон байдаг. Тиймээс төсвийн ил тод байдал нь төсвийн үр дүнтэй удирдлагын амин чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Харин хэдхэн жилийн өмнө ингэж ярихад жирийн иргэд байтугай төрийн байгууллагын албан тушаалтнууд гайхах байсан болов уу. Төрийн байгууллагын үйл ажиллагаа тэр тусмаа төсвийг захиран зарцуулахтай холбоотой үйл ажиллагааны талаарх мэдээлэл иргэд олон нийтэд хаалттай байлаа. Төсвийн зарцуулалтын талаарх мэдээллийг төрийн нууц л гэж боддог. Тиймээс сум орон нутагт нь хэдэн төгрөгийн хөрөнгө оруулалт хуваарилагдаж юунд зарцуулагдаж байгаа, орон нутгийн байгууллагууд ямар хэмжээний урсгал зардал гаргадаг зэргийг иргэд мэддэггүй байсан юм.

Ховд аймгийн Буянт суманд ийм л байв. Баруун хязгаарын алслагдмал сууринд төсвийн ил тод, нээлттэй байдлын тухай ярихад хүршгүй холын юм шиг санагддаг үе байжээ. Иргэдийн олонх нь засаг захиргааны байгууллагыг иргэний үнэмлэх, газрын гэрчилгээ олгодог л газар шиг санадаг. Түүнээс биш татвар төлөгчдийн мөнгийг захиран зарцуулж, сум, орон нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд

хийж, нийгмийн үйлчилгээг үзүүлж байдгийг нь, тэр бүх үйл ажиллагаанд иргэд хяналт тавих эрхтэй, төрийн албан тушаалтнууд тэр нөхцөлийг хангаж өгөх үүрэгтэйг мэддэггүй байв. Төр, иргэн хоёр бие биеэсээ хэт холдсон, дундаа үл үзэгдэх ханаар тусгаарлагдсан энэ байдал Монголын хөдөөд нийтлэг үзэгдэл байлаа.

Сүүлийн арваад жилийн дотор байдал өөр болсныг Буянт сумын жишээн дээр хэлж болно. Төрийн байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй болгох хууль эрх зүйн орчин бүрдсэнээр төр, иргэн хоёрыг холбосон, өөрөөр хэлбэл үйлчлүүлэгч, үйлчлэгч хоёрын дунд боссон үл үзэгдэх хана аажмаар нуран унажээ.



Хуульд төсвийн байгууллага мэдээллийг олон нийтэд хүргэхдээ мэдээллийн самбар, цахим болон хэвлэмэл хуудас, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран төсвийн байгууллага мэдээллийн самбарыг заавал ажиллуулж, самбарт тавигдах мэдээллийг тодорхой хугацаанд тогтмол шинэчилж байна гэж заасан байдаг. Ховд аймгийн Буянт сумын Засаг даргын Тамгын газрынхан энэ дагуу



төсвийн ил тод нээлттэй байдлыг ард иргэдэд сурталчлах зорилгоор санхүү мэдээллийн самбаруудыг 2013 оны нэгдүгээр сараас эрхлэн гаргаж тогтмол ажиллуулж ирсэн байна. Мэдээллийн самбарыг ажиллуулах эрх бүхий албан тушаалтныг Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар томилжээ. Одоогоор сумын төрийн сангийн төлөөлөгч уг самбарыг хариуцан ажиллуулж байгаа юм байна.

Мэдээллийн самбарт тухайн жилийн төсвийг жил бүрийн нэгдүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулна. Мөн төсвийн байгууллага өөрийн төсвөө 10 хоногийн дотор, сар, улирлын тайланг сар, улирлын гүйцэтгэл гарснаас хойш долоо хоногийн дотор мэдээллийн самбарт байршуулдаг бөгөөд сумын нийт төсвийн гүйцэтгэлийг сүүлийн гурван жилээр гаргахаас гадна орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэлийг давхар танилцуулдаг болжээ. Самбарын мэдээллийн гол агуулга нь тус суманд хуваарилагдсан нийт төсвийн санхүүжилт, орон нутгийн орлогоос орох санхүүжилт, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, түүний зарцуулалт, төсөвт албан байгууллагуудын санхүүгийн зарцуулалтын зүйл анги зэргийг нарийн тусгаж харуулдаг байна. Төсвийн ил тод байдлыг хэрхэн танилцуулах, ямар мэдээлэл авахыг хүсэж байгаа талаар ард иргэдээс санал авч, ирүүлсэн санал хүсэлтэд үндэслэн авахыг хүссэн мэдээллийг самбарт ажлын тав хоногт багтаан байршуулдаг нь иргэдийн талархлыг хүлээжээ.

Мөн тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг сар бүрээр гаргаж байршуулдаг ба улирал бүр ард иргэдэд нээлттэйгээр танилцуулдаг байна. “Байгууллагын төсвийн гүйцэтгэлийг сар бүрээр байгууллагын албан хаагчдад танилцуулж ажилладаг нь төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах үндэс суурь болдог” хэмээн Буянт сумын Засаг даргын Тамгын газрын

дарга Ш.Даваатогтох ярьж байна. Цаашид төсвийн ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллахын тулд сум орон нутгийн төр захиргааны байгууллага болон удирдлагуудаас тодорхой асуудлыг боловсруулж, тайлагнаж ажиллахаас гадна иргэд, аж ахуйн нэгжүүдийг идэвхжүүлэх нь хамгийн чухал гэдгийг Ш.Даваатогтох дарга онцолсон юм.

Төсвийн ил тод, нээлттэй байдлын самбар ажиллуулах болсноос хойшхи хоёр жилд иргэд уг самбараас хэрэгтэй мэдээллээ авч сурчээ. Тиймээс мэдээлэл шинэчлэгдэх бүрт ирж үзэж, зарим тохиолдолд нэмэлт тодруулга авдаг иргэд цөөнгүй бий гэнэ. Ийнхүү сумын нэгдсэн төсөв болон төрийн байгууллагуудынхаа төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийг ил тод, нээлттэй байдлаар мэдээлж олон нийтэд хүргэх болсноор иргэдийн дунд төсвийн зарцуулалттай холбоотой ямар нэгэн хардлага, шүүмжлэл гарахаа больжээ. Мэдээлэл авахынхаа хэрээр иргэд ч өөрсдөө төсвийн талаар зохих мэдлэгтэй болж, Орон нутгийн хөгжлийн сангаар сумандаа хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудад идэвхтэй санал өгдөг болсон байна. Ингэж санал өгөхдөө мэдээлэл сайтай иргэдийн хувьд нэлээд үндэслэлтэй, чухал бөгөөд үр дүнтэй гэсэн ажлуудыг сонгодог.



Буяант сумын 720 гаруй өрхийн 610 нь малчин өрх. Малчдын хувьд жилийн дөрвөн улиралд малынхаа бэлчээрийг даган нүүдэллэдэг ч сумын төв хааяахан

орохдоо дэлгүүр хоршоо орохоос урьтаад Засаг даргын Тамгын газраар орно. Малчдад мэдээлэл гэдэг ус агаар шиг хэрэгтэй байдаг болохоор тэр. Засаг даргын Тамгын газрын ажилтнууд орж ирсэн хүн бүхэнтэй уулзаж танилцуулга хийгээд байх зав тэр бүр гарахгүй нь мэдээж. Тиймээс мэдээллийн самбар хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ.



Жирийн хоёр малчин өвгөн уулзаад сум орон нутгийнхаа талаар яриа дэлгэхэд хэн хэн нь сумын төсөв санхүү ийм ийм байгаа, ирэх жилийн төсөвт энийг нэмэгдүүлээсэй, тэр ажлын хөрөнгө оруулалт үргэлжлээсэй гэх мэтээр барагтайхан нягтлан бодогчоос дутахгүй тоо тооцоо ярьдаг болжээ. Мэдээлэлтэй иргэд хүчирхэг гэдэг энэ.

Төрийн байгууллагын мэдээлэл нь ил тод, үйл ажиллагаа нь нээлттэй, хийж буй ажлууд нь иргэдийнхээ амьдралд сайн үр нөлөөг үзүүлдэг, хүртээмжтэй, иргэд нь мэдээлэл авах эрхээ эдэлж, тэр хэрээрээ орон нутгийнхаа төр захиргааны байгууллагын ажилд идэвхтэй оролцдог ийм таатай хандлага Буянт суманд хэдийнэ тогтжээ. Сайн

засаглалын үндсэн зарчмуудыг ийнхүү амьдрал дээр хэрэгжүүлж, бэхжүүлж байгаа зах хязгаарын сумын ажил үйлс, иргэдийн ахуй амьжиргаа өөдрөг сайхан байгаа ажээ.

Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хийсэн Буянт сумынхны энэхүү санаачилга бол яах аргагүй түгээн дэлгэрүүлэх шаардлагатай сайн туршлага юм. Аливаа төр захиргааны байгууллага сайн засаглалын долоон зарчмыг хангахын тулд юуны өмнө ил тод, хүртээмжтэй, үр нөлөөтэй үйл ажиллагааг явуулах ёстой. Энэ шаардлагад нийцсэн ажлын нэг нь төсвийн ил тод байдлыг хангасан мэдээллийн самбар.

Төсөв захиран зарцуулагчдын хувьд үүнийг хийхэд маш амархан. Гагцхүү үйл ажиллагааныхаа мэдээллийг олон нийтэд шударгаар, ил тод, нээлттэй байдлаар хүргэх хүсэл эрмэлзэлтэй л байхад болно. Үүнийг Буянт сумын туршлага харуулж байна.

**Лавлагаа холбоос:**

<http://buyant.kho.gov.mn/>  
[www.khovd.gov.mn/home/index.php?option=com\\_content](http://www.khovd.gov.mn/home/index.php?option=com_content)

**Холбоо барих:**

Ш.Даваатогтох Ховд аймгийн Буянт сумын  
Засаг даргын Тамгын газрын дарга  
Утас: 99135230

# СҮХБААТАР АЙМАГ

## ИРГЭНИЙ ТАНХИМ



### "СҮХБААТАР АЙМГИЙН ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ ТАНХИМ, "ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙН ЭЗЭД" ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**САЙН ТУРШЛАГА:** Гэрэлт ирээдүйн эзэд" ТББ Сүхбаатар аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимд цахим захидал илгээх программыг суурилуулж, мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх талаар санаачилга гарган шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэн төслөө үр бүтээлтэй хэрэгжүүлжээ.

Багийнхны баримталж буй зарчим бол төслийн хэрэгжих хугацаанд хамгийн багадаа таван хэлэлцүүлэг хийх ба эдгээр хэлэлцүүлгүүдээ бодит үр дүнд хүргэхийг зорьжээ.

Иргэний танхимтай хамтарч зохион байгуулсан хэлэлцүүлгүүд амжилттай хэрэгжиж үр дүнд хүрчээ.

Багийнхан ажилдаа даруй орж, "Бинг Солюшнс" компаниас очиж цахим захидал илгээх программ худалдаж авав. Тэр даруйдаа программаа хэрхэн суулгах, ажиллуулах заавар зөвлөгөө ч авч амжлаа.



Сүхбаатар аймгийн Иргэний танхим, "Гэрэлт ирээдүйн эзэд" Төрийн бус байгууллагатай хамтарсан төслийн багийнханы энэ удаагийн ажил нь

иргэдэд, зар мэдээг нэгэн зэрэг илгээх, тэдний санал хүсэлтийг цахимаар болон утсаар хүлээн авах "цахим захидал илгээх программ"-ыг аймгийн Иргэний танхимд нэвтрүүлэх.

Баруун-Урт сумын иргэдтэй уулзаж, "захидал" хүлээн авахыг зөвшөөрсөн 3430 иргэдийн утасны дугаарыг цуглуулжээ. "Захиагаа" илгээх иргэдийн мэдээлэл цуглуулах ажилд сайн дурын гурван ажилтан сонгож, хөлслөн ажиллуулав. Захидал програмыг дагалдаад модем болон тусгай үйлчилгээний захидлыг зэрэг илгээх дугаартай ч болсон байна. Баруун-Урт сумын иргэдийн хаягийн мэдээлэл, утасны дугаар бүхий мэдээллийн сантай ч болчихлоо.

Аймгийн ИТХ-аас төслийн үйл ажиллагааг дэмжиж 800,000 төгрөгний зөөврийн компьютер болон төслийн багийнханы ажлын байрны асуудлыг шийдэж өглөө.



“Сүхбаатар аймаг Иргэний танхим” Утас: 70510615 гэсэн анхны зараа түгээлээ. Туршилт амжилттай.

Ажлаа эрчимжүүлж, “Сүхбаатар аймаг иргэний танхим” Facebook групп үүсгэж гишүүд нэмэх үйл ажиллагаа явуулав. 1000 гаруй идэвхтэй гишүүдтэй болжээ.

Ажлаа дахин төлөвлөж, иргэний танхимд хэд хэдэн хэлэлцүүлэг зохион байгуулах, ямар ямар асуудлаар хэлэлцүүлэг хийх зэрэг урьдчилсан төлөвлөгөө гаргав. Багийнхны баримтлаж буй зарчим бол төсөл хэрэгжих хугацаанд хамгийн багадаа таван хэлэлцүүлэг хийх ба эдгээр хэлэлцүүлэгүүдээ бодит үр дүнд хүргэх явдал.

#### Захидал 1:



**2013 оны хоёрдугаар сарын 25 нд** Тамхины шинэ хууль батлагдаж байгаатай холбогдуулан Иргэний танхимд иргэдэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн талаар танилцуулга сурталчилгааг хийхээр бүртгэл бүхий 3430 иргэнд зар түгээв.

#### Захидал 2:

**2013 оны гуравдугаар сарын 01 15:00 цагт**

Иргэний танхимд Аймгийн ИТХ-ын ажлын алба, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн хэлтэс, төрийн бус байгуулагууд, “SB” телевиз, “Сүхбаатар” кино театр, иргэд хамтран тамхины эсрэг хууль хэрэгжсэнтэй холбогдуулан нээлттэй хэлэлцүүлэг хийлээ. Энэхүү хэлэлцүүлэгийг хийхэд тодорхой бүлэг хүмүүсийн утасны дугаарыг сонгож аваад захидал илгээж мэдээллийг хүргэлээ.

Иргэний танхимын цахим хуудаснаас ишлэв: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны “Тамхины хяналтыг сайжруулах тухай” 66 тоот тогтоолын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг сумын Баруун-Урт сумын Засаг даргын 74 тоот захирамжаар байгуулан удирдамжийг хавсралтаар батлан тус сумын нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дэлгүүр, баар, ресторан, нийтийн хоолны 40-өөд газруудад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг



арилгуулах хугацаатай үүрэг, өгч хамтран ажиллаа. Иргэний танхим 2014.05.01 <https://www.facebook.com/groups/155271297962779/>



**Захидал 3:**



**2013 оны гуравдугаар сарын 07-нд** Сүхбаатар аймгийн /Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтэс/, түүний дэргэдэх хүүхдийн парламент, Сүхбаатар аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхим, Баруун-Урт сумын ИТХ хамтран Олон улсын хүүхдийн нэвтрүүлгийн

хорьдугаар өдрийг тохиолдуулан хүүхдийн зөв хүмүүжил, хүүхэд хамгааллын журмыг нийтэд таниулан сурталчлан хэлэлцэж мөн хүүхдийн дуу хоолойг удирдлагын түвшинд хүргэх үүднээс хүүхдийн парламент анхдугаар хурлаа Сүхбаатар аймгийн Иргэний танхимд хийлээ.

Энэ үеэр хүүхдийн Парламентийн дарга А.Анар цаашид хэрхэн ажиллах төлөвлөгөө гарган танилцуулж, Баруун-Урт сумын ИТХ-ын даргаар батлууллаа. Хүүхэд бүр эрүүл зөв хүмүүжиж, хүүхэд бүрийн дуу хоолой зөв ирээдүйн хөгжлийн түлхүүр байх ёстой гэдгийг энэхүү хэлэлцүүлэгээр ярилцсан. Зар мэдээг бүх иргэд рүү бус тодорхой хэсгийг сонгон захидал илгээсэн.

**Захидал 4:**

**2013 оны гуравдугаар сарын 15-нд** Сүхбаатар аймгийн ИТХ-ын хуралдаанаас гарсан тогтоол шийдвэрүүдийг иргэн бүрт мэдээлэх, тогтоол шийдвэрүүдтэй танилцуулах үүднээс иргэдэд дараах захидлыг илгээсэн.

/2013 onii 03.15nd SUA-n ITH-n 6 daksi udaagiin songuuliin eeljit bus 5-aar khuraldaanaar 1.Aimgiin 2013onii tusuwt uurchlult oruulsan togtool 2.Aimgiin bolowsroliin khugjliin khutulbur 3.Aimgiin zarim 1 gazar nutgiig ulsiin tусгай khamgaalaltand awah togtooliig 4.Ger horoolold dakhin tuluwlult khiikh juram болон,irged baiguullagiin umchlulii ed khurungund unulgee khiikh zereg togtooliig batallaa. Utas: 70510615/

**Захидал 5:**





## **2013 оны гуравдугаар сарын 22-23-нд**

Сүхбаатар аймгийн иргэний танхимд “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо” төсөл, Мерси Кор Олон улсын байгууллага, Аймгийн болон Баруун-Урт сумын ажлын хэсгээс Манлайлагч эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг аймгийн Иргэний танхимд зохион байгуулав. Чуулганд таван сумын манлайлагч гуч гаруй эмэгтэйчүүд санал бодлоо солилцон, уриалга гарган баталлаа.

Энэ мэдээллийг захидлаар иргэдэд илгээж дэлгэрэнгүй мэдээллийг Иргэний танхим дээр ирж авахыг уриаллаа. Иргэний танхимын зай багтаамж, хэлэлцүүлгийн үр дүн, хэлэлцүүлж буй асуудлуудаас хамаараад зарим тохиолдолд тодорхой хэсэг рүү захидлыг илгээж, харин иргэний танхимд болсон үйл ажиллагаа, ИТХ-аас гарсан тогтоол шийдвэрүүдийн талаарх мэдээллийг захидлаар бүх утасны дугааруу хүргэдэг. Дэлгэрэнгүй мэдээллийг иргэний танхим дээр ирж авах боломжтойг сануулсан захидлыг ч давхар илгээдэг.

Иргэний танхимын үйл ажиллагааны талаар мэдээ мэдээллийг Facebook группэд цаг алдалгүй нийтэлж байв.

Ажил ундарч, хурал үргэлжлэн, захидал хөвөрсөөр...

Компьютерээ форматлахдаа захидал илгээх программаа устгачихсан тул дахин суулгав. Тиймээс Иргэний танхимын ажилтнуудад программ устсан тохиолдолд яаж сэргээхийг зааж сургав. Одоо Иргэний танхимын мэдээллийн ажилтан О.Лхагва-Очир программаа бүрэн ажиллуулж сурчээ. Харин түүнийг ээлжийн амралттай үед нь ажил зогсчих тал бий.



**Захидал 6:**

**2013 оны дөрөвдүгээр сарын 13-нд** “Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд 4 сарын 13 нд 15 цагт МҮОНТУ-р Төрийн албан хаагчдад засгийн газрын бодлого хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулна. Иргэний танхим утас 70510615” гэсэн захидлыг 250 иргэдэд илгээсэн.

**Захидал 7:**

**2013 оны дөрөвдүгээр сарын 22-нд** “Аймгийн ИТХ-аас батлагдсан журмын дагуу гэмт хэргийн мэдээллийг 150000-500000 төгрөгөөр худалдаж авна. Дэлгэрэнгүй мэдээллийг Иргэний танхимаас Утас 70510615” гэсэн захидлыг 250 иргэдэд илгээсэн.

**Захидал 8:**

**2013 оны дөрөвдүгээр сарын 24-нд** “Аймгийн ЗДТГ, ИТХ, Мерси Кор ОУБ-ын төсөл хамтран хууль дүрэм бодит амьдралд аяны туг, богцыг Баруун-Урт, Уулбаян, Мөнххаан, Сүхбаатар сумдуудад аялуулав. Дэлгэрэнгүй мэдээллийг Иргэний танхимаас Утас 70510615” гэсэн захидлуудыг илгээлээ. Захидал хөвөрсөөр...



Ингэж, “Гэрэлт ирээдүйн эзэд” ТББ, аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимынхан хамтран олон улсын

төслийн дэмжлэгтэйгээр Сүхбаатар аймгийнхаа Иргэний танхимыг иргэдэд мэдээлэл түгээх захидлын программыг нэвтрүүлж чадлаа. Одоо Иргэний танхимын суурин утасны дугаарыг олон хүн мэддэг болсон. Байнга түгээх захидлаар мэдээлэл авсан иргэд Иргэний танхимын талаар болон орон нутгийн талаарх мэдээлэлтэй болж, орон нутагт болж буй хурал цуглаанд идэвхтэй оролцдог болов.

Мерси Кор ОУБ-ын төслийн зохицуулагчид санхүүгийн бичиг баримт хэрхэн бүрдүүлэх талаар иргэний нийгмийн байгууллагуудад сургалт зохион байгуулж, санхүү бүрдүүлэлтийн талаар мэдлэг олгосон нь чухал ажил болжээ. Төсөл хэрэгжүүлж эхлэхэд санхүүгийн баримт хэрхэн бүрдүүлэх талаар мэдлэггүй байсан төрийн бус байгууллагынханы чадавхи сайжирсан байна.

**Захидал 9:**

**2013 оны есдүгээр сарын 04-нд** Сүхбаатар аймгийн 1 дүгээр багийн иргэдийн дугаарыг сонгон авч захидал илгээв. Захидлаар “Нэгдүгээр багийн хурал 2013 оны 09 сарын 05нд 09,00 цагаас аймгийн ЗДТГ-т болно” дэлгэрэнгүй мэдээллийг Иргэний танхимаас Утас: 70510615

**Лавлагаа холбоос:**

<http://www.facebook.com/groups/155271297962779/>

**Холбоо барих :**

О.Лхагва-Очир “Сүхбаатар аймаг Иргэний танхим”-ийн мэдээллийн ажилтан

Утас: 70510615, 91199449

САЙН ЗАСАГЛАМЫН ТӨЛӨӨХ  
САЙН ТҮРШЛАГА

# ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД

---



## АРДЧИЛЛЫН БОЛОВСРОЛ ТӨВ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**САЙН ТУРШЛАГА:** Ардчиллын боловсролын төв төрийн бус байгууллага нь төрийн үйлчилгээний байгууллагын ил тод байдал, хүртээмжийг Иргэдийн онооны картын аргачлалаар үйлчилгээ хүртэгч иргэдээр үнэлүүлж, туршилт хийсэн нь сайн туршлага болсон. Уг туршлагыг Авлигатай тэмцэх газраас Сайн засаглалын төлөөх сайн туршлага, санаачилгын нэг гэж үзэн “Авлигаас ангид, сайн засаглалын туршлага-2013” өргөмжлөл хүртээсэн байна.

2014 оны тавдугаар сарын 6-7-нд Индонези улсын Бали аралд болсон Нээлттэй Засгийн Түншлэл (Open Government Partnership)-ийн Ази, Номхон далайн бүсийн орнуудын хуралд Ардчиллын боловсрол төв /ДЕМО/-ийн захирал Г.Ундрал илтгэгчээр уригдаж “Check My Service” буюу төрийн үйл ажиллагааны ил тод байдал, үйлчилгээний хүртээмжийг Иргэдийн онооны картын аргачлалаар үнэлсэн санаачилгаа таницуулсан байна. Энэ үеэр “Check My Service” санаачилга нь Ази, Номхон далайн орнуудын засаглалын ил тод, хариуцлагатай байдал, иргэдийн оролцооны уралдаанд шилдэг санаачилгаар шалгарчээ.

---

## ИЛ ТОД БАЙДАЛД ИРГЭД ДҮН ТАВИНА

### Үр дүнгээс үүдсэн яриа

**А**рдчиллын боловсрол төвийн сайн засаглалын төлөөх туршлагыг үр дүнгээс нь эхэлж яримаар санагдлаа. Тэд үүнийгээ “Өөрчлөлтийн түүх” хэмээн нэрлэдэг юм. Өөрчлөлтийн түүхийг төгсгөлөөс нь эхлэн өгүүлэхэд нэн урамтай. Тус төвийн хэрэгжүүлсэн төслийн үр дүнд төсөл хэрэгжсэн ерөнхий боловсролын сургуулиудад үйл ажиллагааны болон төсвийн мэдээллийн нээлттэй самбар ажилладаг болсон байна. Эдгээр самбартаа тухайн сургуулийн жилийн

төсөв, сарын гүйцэтгэлийн тайлан, шагнал урамшууллын зардал, үдийн цай, хүүхдийн хоолны зарцуулалт, хандив болон бусад хөрөнгө оруулалтын мэдээллийг тавьдаг болжээ. Зарим сургууль нээлттэй мэдээллийн самбар дээрээ багш нарынхаа утас, цахим хаягийг тавьсан байна. Мөн сургуулийнхаа дотоод дүрэм, журмыг уг самбартаа байрлуулжээ.

Төсөл хэрэгжсэн хоёрдугаар сургууль нээлттэй мэдээллийн самбартай болсноос гадна “Нээлттэй сургууль 353528” утас ажиллуулж эхэлсэн гэнэ.

Энэ утсаар эцэг эхчүүд сургуулийн талаарх санал гомдол, шүүмжлэлээ илэрхийлэх боломжтой болсон нь давуу тал юм. Мөн тус сургуулийн эмчийг сурагчид нь ажлын цагаар өрөөндөө байдаггүй, зан харьцаа муутай гэж дүгнэсэн байна. Ардчиллын боловсрол төвөөс хэрэгжүүлсэн төслийн үр дүнд тус сургуулийн эмч 2013 оны есдүгээр сараас эхлэн ажиллах цагийн хуваарь болон гар утасныхаа дугаарыг өрөөнийхөө үүдэнд бичиж өлгөжээ.

Чингэлтэй дүүргийн тавдугаар сургуулийн “Өөрчлөлтийн түүх” бас санаа авууштай, сайн туршлага болжээ. Тус сургуульд анги дүүргэлт хэтэрсэн, хичээлийн анги танхим хүрэлцдэггүй хүндрэлтэй асуудал байгаа нь үнэлгээний дүнгээр гарсан байна. Төслийн хүрээнд тавдугаар сургуулийнхан өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан сургалтын менежерүүдийн суудаг өрөөг нийлүүлэн засварлаж тохижуулан хичээлийн нэг танхим нэмэгдүүлснээр хоёр анги ээлжээр хичээллэх боломжтой болжээ.

Түүнчлэн хоёрдугаар сургуулийн адилаар нээлттэй мэдээллийн самбар ажиллуулсан байна. Тавдугаар сургуулийн шинэлэг ажил нь өөрсдийн цахим хуудастай болсон явдал. Тус сургууль өөрийн цахим хуудасгүй байсан бол төслийн үнэлгээний үр дүнд [www.school5.mn](http://www.school5.mn) цахим хуудас нээж, <http://school5.mongol.name> блог ажиллуулж эхэлжээ. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудаас өөрийн цахим хуудастай сургууль тун цөөн. Тиймээс тавдугаар сургуулийн цахим хуудас бусдад үлгэр дууриал болохуйц сайн туршлага болж чаджээ. Тус сургуулийнхан цаашид цахим хуудасныхаа агуулга мэдээллийг улам боловсронгуй болгохоор ажиллаж байгаа ажээ.

Дараагийн сайн туршлагын эзэд бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 55 дугаар сургууль. Тус сургууль Мэдээллийн ил тод байдал ба

мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу санхүүгийн мэдээллийн самбар ажиллуулан сургуулийнхаа жилийн төсөв, улирлын гүйцэтгэлийн тайланг ил тод, нээлттэй тавьдаг байсан нь сайн туршлага болж чаджээ. Ардчиллын боловсрол төвийн төслийн үнэлгээний дүнд ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд төсвийн гүйцэтгэлийн талаар 14 хоног тутамд багш, ажилтнуудын хурал хийж, улирал тутамд санхүүгийн тайлангаа танилцуулдаг болсон байна.

Ардчиллын боловсрол төв /ДЕМО/ бүтээлч харилцаа үүсгэн Нийслэлийн боловсролын газартай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан ажиллажээ.

Түүнчлэн 55 дугаар сургууль дээр хийсэн үнэлгээгээр тус сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургалтын үйл ажиллагаа явуулдаг онцлогтой боловсролын байгууллага боловч нэгдүгээр ангид ганцхан туслах багштай, цалинжуулах төсөвгүйгээс болоод сэтгэл зүйч, сувилагчгүй байжээ.

Энэ байдлаа БШУЯ-нд танилцуулснаар 2013 оны есдүгээр сараас нэг туслах багш, 2014 оны хоёрдугаар сараас хоёр туслах багш, мөн оны гуравдугаар сараас сэтгэл зүйч, сувилагчийн орон тоо нэмэгдсэн байна. Тус сургуулийн барилга зориулалтын бус. Тиймээс анги танхимууд нь засвар үйлчилгээ хийх шаардлагатай болжээ. Төслийн хүрээнд Солонгосын КОНЕС компани 40 сая төгрөгийн санхүүжилтээр сургуулийн урлаг заалны их засварын ажлыг хийж өгчээ.

### **Үйлчилгээ ба үнэлгээ**

Ерөнхий боловсролын сургуулиудад хичээлийн хуваарь бүхий самбарууд л байдгаас биш төсөв санхүүгийн тайлангаа дэлгэсэн самбар байдаггүй. Тэгвэл дээр өгүүлсэн төслийн үр дүн яах аргагүй шинэлэг бөгөөд сайн туршлага болсон гэдэгтэй та санал нийлэх бизээ. Ямар төсөл хэрэгжүүлснээр ийм үр



дүнд хүрвэ гэдгийг одоо тайлбарлая. Ардчиллын боловсрол төв “Check My School” буюу ерөнхий боловсролын сургуулийн ил тод байдал, хүртээмжийг үнэлэх төслийг 2013 оны гуравдугаар сараас зургадугаар сарын хооронд Сүхбаатар дүүргийн хоёрдугаар сургууль, Чингэлтэй дүүргийн тавдугаар сургууль, Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулиудад тус тус хэрэгжүүлжээ. Төслийн хүрээнд нийт 1061 эцэг эх, сурагчид үнэлгээнд хамрагдсан бөгөөд нийт 20 төрийн бус байгууллагын төлөөлөл үнэлгээний багийн гишүүдээр ажилласан юм байна.

Сургуулиудын ил тод байдал, хүртээмжийг хэрхэн үнэлсэн арга нь тун шинэлэг. Төсөл хэрэгжсэн сургуулиудад эцэг эх, сурагчдаар Иргэдийн онооны карт бөглүүлэн картаар илэрсэн зөрчил дутагдал болон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэжээ. Төрийн үйлчилгээг иргэд, олон нийтээр үнэлүүлсэн гэсэн үг. Уг үнэлгээнд тулгуурлан үнэлгээний багийн гишүүд төрийн байгууллагатай хамтарч ажиллаж санамж бичиг байгуулдаг байна. Ингэснээр төр, иргэд, иргэний нийгмийн байгууллагын хооронд бүтээлч харилцаа, хамтын ажиллагаа бий болж чадсаныг дээр өгүүлсэн. Ерөнхий боловсролын сургуулиуд дээр Иргэдийн онооны карт ашиглан хийсэн ил тод байдал, хүртээмжийн үнэлгээ ийм л аргачлал, зарчмаар хэрэгжжээ.

Ийнхүү Иргэдийн онооны картын аргачлалыг Монголд анх нэвтрүүлж төрийн үйлчилгээг үйлчилгээ хүртэгч иргэдээр үнэлүүлэх ажлыг практик дээр туршин хэрэгжүүлснийг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүйн яам болон Авлигатай тэмцэх газраас үнэлж Ардчиллын боловсрол төвийн энэ үйл ажиллагааг 2013 оны шилдэг туршлагаар шалгаруулж “Шударга ёсны төлөө” өргөмжлөлөөр шагнасан байна. Ардчиллын боловсрол төв 2014 оны есдүгээр сараас эхлэн “Check My School” буюу ерөнхий боловсролын сургуулийн ил тод байдал, хүртээмжийг үнэлэх төслийн хүрээнд Баянгол дүүргийн 47, Баянзүрх дүүргийн 85, Сонгинохайрхан дүүргийн 65, Сүхбаатар дүүргийн нэг, 29, 116, Хан-Уул дүүргийн 52, 63, Чингэлтэй дүүргийн 17 гэсэн нийт есөн сургуульд Иргэдийн онооны картын аргачлалаар үнэлгээ хийж байгаа ажээ. Цаашид “Check My School” буюу “ЕБС-ийн ил тод байдал, хүртээмжийг үнэлэх нь” төслийн хүрээнд 2014 онд БШУЯ-тай хамтран ЕБС-ийн ил тод байдал, хүртээмжийг Иргэдийн онооны картын аргачлалаар үнэлэх журмын төслийг боловсруулж батлуулахаар ажиллаж байгаа гэнэ.

Тус төрийн бус байгууллага “Төрийн үйлчилгээний ил тод байдал, хүртээмжийг үнэлэх” буюу “Check My Service” хөтөлбөрийн хүрээнд 2012-2014 онд их сургуулиудын үйлчилгээг оюутнуудаар үнэлүүлэх “Check My University”, ерөнхий боловсролын сургуулийн ил тод байдал, хүртээмжийг үнэлэх “Check My School”, өрхийн эрүүл мэндийн төвийн ил тод байдал, хүртээмжийг үнэлэх “Check My Clinic”, дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн ил тод байдал, хүртээмжийг үнэлэх “Check My Hospital”, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ил тод байдал, хүртээмжийг үнэлэх “Check My Hospital-1” төслүүдийг тус тус хэрэгжүүлж сайн засаглалын төлөөх сайн туршлагыг хуримтлуулсан байна.

“ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖИЙГ ҮНЭЛЭХ” ТӨСӨЛ

DEMO USAID

### CHECK MY SCHOOL project

ЕБС-ийн үйл ажиллагааны ИРГЭДИЙН ОНОНЫ КАРТ-ын дүн

МЭДИЙН СУРГУУЛЬ	ХАЙН ЭСР СУРГУУЛЬ	СЭХВИЙН СУРГУУЛЬ
Мэргэжлийн их сургууль: 10 багана	Идэвхтэй: 112 багана	Төрийн их сургууль: 10 багана
Төрийн их сургууль: 85 багана	Сургууль: 2 багана	Төрийн сургууль: 10 багана
Амьдрал: 10 багана	Сургууль: 22 багана	Төрийн их сургууль: 4 багана
Сүхбаатар дүүргийн сургууль: 11 багана		
Чингэлтэй дүүргийн сургууль: 14 багана		
Баянзүрх дүүргийн сургууль: 14 багана		
Баянгол дүүргийн сургууль: 14 багана		

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Тусгай зориулалт:	ИБС-ийн Соёлын багийн багшдын ажиллагаа
Нэгдсэн зорилго:	ИБС орчин, хөгжж, хамрагдсан
Хэрэгжсэн зорилго:	10 сургуульд орчин, хөгжж, хамрагдсан
Бүтээгдсэн ажил:	20 ТБХ, 7 тэмцээн, 500 хураангуй
Мэдээлэл, танилцуулга:	20 ТБХ, 7 тэмцээн, 500 хураангуй
Урьдчилсан үнэлгээ:	Сайн, амжилттай үнэлгээний үр дүнд хүрчээ. Сайн ажиллагаа, хуримтлагын үр дүнд хүрчээ. ИБС-ийн ажиллагааг дэмжж, хамрагдсан байна.

АРДЧИЛЛЫН БОЛОВСРОЛ ТӨВ ДЭМӨ

Хаяг: СБД, Баянзүрх, 46-3/2, Утас: 318566

И-мэйл: demo@ardchil.com  
 ИБС: www.ardchil.com

## **Иргэдийн онооны карт олон улсын шилдэг санаачилга болов**

Ардчиллын боловсрол төв /ДЕМО/ нь 2009 оноос хойш нийгмийн хариуцлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Монголд анх удаа Иргэдийн онооны картын аргачлалыг нэвтрүүлж, энэхүү аргачлалаар төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгааг өмнө дурдсан.

Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн нэг гол алхам нь төрийн аливаа хэрэгт иргэдийн оролцоог хангах талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, түүний үр дүн гэж үздэг. Оролцооны олон янзын арга, хэлбэрүүд байдгийн чухам нэг нь төрийн үйлчилгээг иргэдээр үнэлүүлэх хэлбэр бөгөөд орчин цагт олон оронд Иргэдийн онооны картын аргачлалыг ашиглах болжээ. Энэ нь ялангуяа төрийн үйлчилгээний салбарууд, түүний байгууллагуудын иргэддээ үзүүлж байгаа үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд зайлшгүй хэрэгцээтэй бөгөөд үр нөлөөтэй арга гэдгийг дэлхийн орнуудын туршлагаас харж болно.

Иргэдийн онооны картын үйл ажиллагаа нь олон нийтэд тулгуурласан Иргэдийн тайлангийн карт, нийгмийн аудитын аргачлалаас бүрдсэн үнэлгээний холимог арга юм. Иргэдийн тайлангийн адил Иргэдийн онооны карт нь иргэдийн тайлагнах чадвар болон үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага хоёрын нийцлийн арга хэрэгсэл гэж болно. Хэдий тийм боловч үйлчилгээ үзүүлэгч болон үйлчилгээ хүртэгч хоорондын нүүр тулсан уулзалтыг оруулснаар Иргэдийн онооны карт нь шууд хариу үйлдэл хийх боломжийг бий болгодог байна. Энэ үйл явц нь хоёр оролцогч талд эрх мэдэл олгох хүчтэй зэвсэг болдог.

Энэхүү аргачлал нь тухайн төрийн байгууллагаас иргэд үйлчилгээ авахад чухам ямар асуудал бэрхшээл байгааг иргэд өөрсдөө гаргаж, дараа нь

тэрхүү үйлчилгээг зохицуулдаг ямар хууль зүйн баримт, норм стандарт байдгийг судласны үндсэн дээр иргэд Иргэдийн онооны картын аргаар тухайн үйлчилгээнд үнэлгээ буюу оноо өгнө. Үүний дараа тухайн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь мөн адил өөрсдийн үйлчилгээг үнэлнэ. Эцэст нь нүүр тулсан уулзалт буюу хамтарсан уулзалтаар үйлчилгээ хүртэгч иргэд болон үйлчилгээ үзүүлэгч байгууллага харилцан Иргэдийн онооны картын үр дүнг танилцуулж, харилцан ярилцаж тухайн үйлчилгээг цаашид сайжруулах төлөвлөгөөг хамтран боловсруулдаг байна. Ингээд тодорхой хугацааны дараа үйлчилгээ хүртэгчид дахин тухайн үйлчилгээг үнэлж, өмнөх жилийн Иргэдийн онооны картын үр дүнтэй харьцуулж үйлчилгээнд ахиц гарсан эсэхэд үнэлгээ өгдгөөрөө онцлогтой. Ингэснээр төрийн байгууллагуудын үйлчилгээний ил тод байдал сайжирч, үйлчилгээний чанар хүртээмж нэмэгддэг байна. Товчхондоо бол Иргэдийн онооны карт нь нийгмийн болон төрийн хариуцлагатай байдал, мөн үйлчилгээ үзүүлэгчдээс эргэн тайлагнах явцыг хангадаг аргачлал юм.

“Check My Service” санаачилга 2013 онд Ази, Номхон далайн орнуудын засаглалын ил тод, хариуцлагатай байдал, иргэдийн оролцооны уралдаанд шилдэг санаачилгаар шалгарсан нь энэхүү сайн туршлагыг олон улсад хүлээн зөвшөөрсний илрэл байв.

Лавлагаа холбоос:  
[www.demo.org.mn](http://www.demo.org.mn)

### **Холбоо барих:**


Хаяг: СБД, 6-р хороо, Бага тойруу,  
44-р байр, 3 давхар, 7 тоот  
/“Залуучууд зочид” буудлын баруун  
урд,

“Сити Интест”-ийн байр/

Утас: 310560, 99164419

Электрон шуудан:

[demo@magicnet.mn](mailto:demo@magicnet.mn)



## “ИЛ ТОД БАЙДАЛ САН” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**САЙН ТУРШЛАГА:** Монгол Улсын засгийн газрын төв байгууллагууд ил тод байдлыг хэрхэн хангаж байгааг нээлттэй эх сурвалжийн үндсэн дээр нягталж дууссан ба эхний ээлжинд Засгийн газрын яам, агентлагуудын ямар мэдээлэл нээлттэй, ямар мэдээлэл хаалттай байгааг тогтоож цахим сайтад нийтэлжээ. Энэ нь төрийн ил тод байдлыг эерэг, сөрөг сурталчилгаа болон хийсвэр ойлголтуудаас аль болох ангид, зөвхөн бодитой баримт мэдээллийн үндсэн дээр дэлгэн харуулах зорилготой юм. Мөн төрийн хаалттай мэдээллийг судалгааны болон эрэн сурвалжлах сэтгүүл зүйн аргаар нээлттэй болгож олон нийтэд хүргэх ажлыг эхлүүлсэн байна.

## “ИЛ ЗАСАГ”-ИЙН ЭРЭМБЭ

Төрийн байгууллагуудын мэдээллийн чадавх, боломж ихээхэн сайжирч асар их мэдээллийг албан ёсны цахим сайт, хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэг, товхимол, хэвлэлийн хурал, уулзалт зэрэг хэлбэрээр өдөр тутам дамжуулан түгээж байгаа хэдий ч сурталчилгаа, PR-ын бүтээгдэхүүн хэт давамгайлж иргэд, олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бодитой баримт, мэдээлэл үгүйлэгдсэн хэвээр байгаа билээ.


Шинэчлэлийн Засгийн газар 2012 оны намраас өөрийн үйл ажиллагааг сурталчлах зорилготой [www.zasag.mn](http://www.zasag.mn) цахим хуудсыг байгуулан ажиллуулсан нь үүний нэг жишээ.

**Ил засаг цахим хуудас**  
 “Ил тод байдал сан” ТББ-хан төрийн үйл ажиллагааг иргэний нийгмийн өнцгөөс ил тод болгох зорилго бүхий [www.ilzasag.mn](http://www.ilzasag.mn) цахим хуудсыг нээжээ. Цахим хуудсын загварыг “Том амжилт” болон “Ийгл софт” ХХК-иудтай хамтран хэд хэдэн янзаар туршиж үзсэний эцэст нэг талаас мэдээллийн багтаамж ихтэй, нөгөө талаас бүтцийн хувьд харьцангуй энгийн ойлгомжтой загварыг сонгож хийлгэжээ. Үүний үр дүнд төрийн холбогдолтой ямар ч бичлэг буюу баримт, мэдээллийг байгууллага, албан тушаалтны ангилалд дангаар, эсвэл зэрэг бүртгэж оруулах, дараа нь буцаагаад тэгж ангилж харуулах, хайлт хийн гаргаж ирэх зэрэг боломжийг бүрдүүлсэн аж.



**“Ил тод байдал сан” ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжавтэй ярилцлаа.**

**-Цахим хуудасны загвар их энгийн юм?**



-Бидний хүссэн загварын дагуу, ялангуяа ангиллыг жирийн иргэдэд ойлгомжтой, цэгцтэй байдлаар хийж гүйцэтгэх вэб дизайны компани ховор байсан. Тэд өндөр өртөгтэй хэрнээ гоё сайхныг нэгдүгээрт, мэдээллийн агуулга, эмх цэгцийг хоёрдугаарт тавьсан нүсэр цахим хуудас хийх хандлагатай байсан юм. Ийм цахим хуудас тухайн үедээ сайхан харагдавч, цааш нь үргэлжлүүлэн авч явахад маш түвэгтэй болох байлаа.

Анх яам, агентлагийн хуудсууд тус бүртээ лавлах булантай байх зэргээр төлөвлөсөн боловч програмчлалын хувьд алдаа магад байнга гарсны улмаас арга буюу хялбарчилсан. Тиймээс энгийн загвараас эхэлж зүгшрүүлсний дараа аажмаар нэмж өргөжүүлэх зарчмыг баримтлах шийдэлд хүрсэн. Төслийн өмнөх үе шатанд [www.ilzasag.mn](http://www.ilzasag.mn) цахим хуудсыг зөвхөн яам,

агентлагийн ангиллаар байгуулсан бол энэ үе шатанд төрийн албан тушаалтны ангиллыг нэмснээр цаашид төрийн үйл ажиллагааг институци ба хувь хүмүүсийн талаас нэгэн зэрэг нээлттэй болгож ажиллах орон зайг бий болгож байгаа юм. Олон нийтийн хувьд зайлшгүй мэдэх шаардлагатай гэж үзсэн тийм баримт, мэдээллийг бодитойгоор нээлттэй болгох зарчмыг баримталж байна.

**-Яамдынхан танай сайтын талаар ямар сэтгэгдэлтэй байдаг вэ?**

Ерөнхий сайдын зөвлөхүүдийн хэн нь хэн бэ?



Ерөнхий сайд Н.Алтанууг орон тооны болон орон тооны бус 15 зөвлөлтэй нь ил боллоо. Зургагт эдгээр зөвлөхүүдийн аль нь орон тооны, аль нь олон орон тооны бус гэдгийг ялгах харуулжээ.

Орон тооны зөвлөхүүдийн тунгад албан ёсны мэдээлэл байдаг. Харин орон тооны бус зөвлөхүүд нь төдийлэн олон нийтэд ил болоогүй байна.

Ордыг тойрон хороолж, ургалж тэмцэж байсан Алмадын холбооны тэргүүн Г.Баасан гүйцэтгэх засаглалын тэргүүний багт оржээ.

Мэдээллийн news.mn сайтыг төсөл байхаас нь гардан өдий зэрэгт хүргэн, мөн хэд хэдэн ТБ-нуудтай өөрийн болгоод байгаа А.Амууха мөн Ерөнхий сайдын орон тооны бус зөвлөх юм байна.

Иргэний нийгмийн ивэлдөөнөөс гарч ирж олоод танигдан, хүний эрхийн хуульч М.Чинзоригийг Ерөнхий сайд дэргэдээ асан байдаг аж. Нам нам сольж, хэсэг суудлаа олоогүй будицж явсан түүнд Ерөнхий сайд итгэн нийлүү орон тооны бус зөвлөхөө болгосон байна.

Нэгдэл үүсгэх замаар илүү гөлөөлж өгвэй гэжээ. Баттайгаар Ерөнхий сайдтай олоогүй түүнийг бид чөлөөлж...

-[www.ilzasag.mn](http://www.ilzasag.mn) цахим хуудсыг ажиллуулаад хэсэг хугацаа өнгөрсний дараа Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам, Цөмийн энергийн газар зэрэг яам, агентлагийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны хүмүүст электрон шуудан явуулж, мөн утсаар ярьж санал сэтгэгдлийг нь сонссон. Тэд :

-Та бүхэн манай яаман дээр ирээд хүссэн мэдээллээ аваад цахим хуудсандаа тавьж болдоггүй юм уу. Мэдээллийг дээд шатны удирдлагадаа танилцуулж байж цацдаг учраас цаг их алддаг. Бид хангалттай мэдээлэл оруулдаг, манай сайд ч зөндөө ярилцлага өгдөг, тэгсээр байхад хаалттай байна гээд байгаагийн учрыг ойлгохгүй байна гэх мэт санал, шүүмжлэлийг гаргасан.

Цахим хуудсыг дахин төлөвлөх, шинээр хийлгэх, байнга мэдээлэл оруулах



явцад төрийн мэдээллийн мөн чанар, ач холбогдлын талаарх бидний ойлголт, төсөөлөл улам гүнзгийрч олон талтай болж байна. Бид цаашир [www.ilzasag.mn](http://www.ilzasag.mn) нь индекс (рейтинг), мониторинг, эрэн сурвалжлагын явц, үр дүн зэрэг

бусад ажлыг шууд нээлттэй болгож, хүмүүс санал бодлоо илэрхийлэх, шүүмжлэх зэргээр тал бүрээсээ оролцох, энэ утгаараа хамтын ажиллагаа, оролцооны талбар байлгахад түлхүү анхаарна.

**ИЛ ТОД БАЙДЛЫН КАРТ** 2014 оны 6-р сар

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ**

УИХ-ын гишүүнээр 4 дэх удаагаа сонгогдсон

УИХ ажиллагааны чиг үүрэгт: Засгийн газрын Ерөнхий чиг үүргийн яам

**САЙД**

Овог, нэр	Санжаасүрэнгийн ОЮУН
Угс төрийн намын харьяалах, намын ажил, албан тушаал	Иргэний эрэг, ногоон намын дарга
Сайдын эрхэмж буй төр, засгийн бусад ажил, албан тушаал (Комисс, үндэсний зөвлөл, хөтөлбөр, ажлын хэсэг, ТУЗ, бусад)	1. УИХ-ын гишүүн 2. Улсын онцгой комиссын гишүүн 3. Бионоэгүй байдалт хамгаах үндэсний хорооны дарга 4. Монголын амьтан, ургамлыг хамгаалах үндэсний хорооны дарга 5. Ойн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах үндэсний хорооны дарга 6. Үзр амьсгалын үндэсний хорооны дарга 7. Үзр амьсгалын үндэсний хорооны дарга

**ГАЗАР, ХЭЛТЭСНИЙ УДИРЛАГА, АЖЛАГААНЫ НЭРС, УТАСНЫ ЖАГСААТ**

Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтөй газар	Услын мониторинг, зохицуулах ажил хэлтэс
1. Газрын даргын түүрийг түр орон гүйцэтгэгч Г.Чулуун. Утас: 310357	69. Холтсийн дарга Г.Мөнх-Эрэм. Утас: 262131
2. Хөдөөгийн тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Доржпалов. Утас: 261309	70. Усны баригта байгууллаг, зураг төслийн дүгнэлт зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Баатарзогот. Утас: 266305
3. Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн М.Ганбат. Утас: 261309	71. Усны тос бүртгэгч, хяналт шинжилгээний сүлжээ, усны мэргэжлийн байгууллага хариуцсан мэргэжилтэн Д.Чулуунцүлү. Утас: 266305
4. Үйлдвэр, уул уурхайн ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Б.Саран. Утас: 261309	72. Усны бохирдол, комдол, усны хөвөөт төлөв байдлын аналзт хариуцсан мэргэжилтэн Б.Пүрэвжав. Утас: 266305
5. Ногоон хэдий засгийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэний түр орон гүйцэтгэгч Д.Энгийн. Утас: 325848	73. Усны мэдээллийн сан, дотоод үйл ажиллагааны зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Сарантуяа. Утас: 267545
6. Дэд бүтцийн тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн М.Мөнхула. Утас: 311278	74. Үйдэрлээний ус ашиглалтын удирдлагын зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Отгонбаяр. Утас: 266305
7. Ногоон хот байгуулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн М.Ганбат. Утас: 325848	75. Сан газрын удирдлагын хэлтэс
8. Байгаль орчин, ногоон хөгжлийн төслийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Чулуунбат. Утас: 325848	76. Сан газрын сургалт сурталчлага, хамтын оролцооны удирдлага зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн И.Баттөгс. Утас: 267545
9. Соёл боловсролын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Ө.Бүжидлэгэр. Утас: 325848	77. Сан газрын менежмент, удирдлага зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Х.Совжидлова. Утас: 267545
10. Холтсийн дарга Д.Ширээ. Утас: 267828. 3312450	78. Сан газрын голчлалын экологийн цаас тогтоох.

**ТӨРИЙН ӨМЧИН БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООГЙ ХУУЛИЙН ЭГТЭЭДИЙН ТҮЗ Д ОРГОГ АЛБАН ГУШААЛТАН, АЛБАН ХААГЧ**

АЖИЛТНЫ НЭР, АЛБАН ГУШААЛ	КОМПАНИЙН НЭР	ТҮЗ-ИЙН ЮУ БОЛОХ?
С.Оюун – Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд	“Цэврү агаар” сангийн	ТҮЗ-ийн дарга
Ж.Батболд – Төрийн нарийн бичгийн дарга	“Шинэ овоо” ХК	ТҮЗ-ийн дарга
Д.Энхбат – Намын Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга	“Төв АЗЗА” ХК	ТҮЗ-ийн гишүүн
Д.Энхбат – Намын Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга	“Эрдэсэнт АЗЗА” ХК	ТҮЗ-ийн гишүүн
Б.Гантулга – Яамны Бодлогын Хэрэгтэгийг Зохицуулах газрын дарга	“Ховд АЗЗА” ХК	ТҮЗ-ийн гишүүн
Б.Гантулга – Яамны Бодлогын Хэрэгтэгийг Зохицуулах газрын дарга	“Увс АЗЗА” ХК	ТҮЗ-ийн гишүүн
Б.Гантулга – Яамны Бодлогын Хэрэгтэгийг Зохицуулах газрын дарга	“Төв-Алтай АЗЗА” ХК	ТҮЗ-ийн гишүүн
Б.Гантулга – Яамны Бодлогын Хэрэгтэгийг Зохицуулах газрын дарга	“Завхан АЗЗА” ХК	ТҮЗ-ийн гишүүн

**ЯАМНЫ ОНЦЛОГТОЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЭ**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН САН**

Байгаль орчны хамгаалах тухай хуулинд заасны дагуу Үндэсний хэмжээний байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан (амьсгал зөвлөхөөр байгуулагдсан. Түүнийг БОАЖ-ын дарга Ж.Батгал Орчны мэдээллийн төвөөс хариуцаж өнөөдрийн байдал дарах сэдэвчилсэн сангууд ажиллаж байна. Үүнд: 1. Газрын мэдээллийн сан, 2. Элдэрсэн газрын тоололын мэдээллийн сан, 3. Усны мэдээллийн сан, 4. Ойн нөөцийн мэдээллийн сан, 5. Ой зохион байгуулалтын мэдээллийн сан, 6. Амьтны мэдээллийн сан, 7. Агаарын бохирдлын мэдээллийн сан, 8. Байгалийн гэмтцийн мэдээллийн сан, 9. Хөдөөн хот болон аюултай бодисын мэдээллийн сан, 10. Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, 11. БО-ны эрх зүйн мэдээллийн сан, 12. Байгаль орчинд нөлөөлж байгаа үнэлгээний мэдээллийн сан, 13. БО-ны бодлого, төсөл, хөтөлбөрийн мэдээллийн сан, 14. Байгаль орчны статистик мэдээллийн сан, 15. БО-ны байгууллага, хүний нөөцийн мэдээллийн сан, 16. Г-то-мэдээллийн сан, 17. Угсдалын мэдээллийн сан, 18. Өсөлтийн мэдээллийн сан, 19. Байгаль орчинд ээлтэй төмөрлөлийн мэдээллийн сан, 20. Метал мэдээллийн сан. Байгаль орчны мэдээллийн сангийн хаяг: [www.оic.mn](http://www.оic.mn)

**-Табүхэн "ил тод байдлын карт" нэвтрүүлсэн. Энэ талаар тодруулбал:**

-Төрийн байгууллагууд өөрсдийн санаачилгаар буюу Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль -ийн эхний хэсэгт заасан зарчмуудын дагуу мэдээллээ хэрхэн ил тод болгож байгааг судалсны үндсэн дээр "Төрийн байгууллагын ил тод байдлын карт"-ын эхний хувилбарыг яам, агентлаг тус бүрээр бэлтгэж гаргалаа. Төрийн байгууллагын зүгээс хамгийн түрүүнд ямар ямар мэдээллийг ил тод болгох ёстойг жагсаагаад тэр мэдээлэл нээлттэй байгаа эсэхийг олж тогтоох замаар үнэлэх арга юм. Энэ зорилгоор бид яам, агентлагуудын "Ил тод байдлын карт" хэмээх бүтээгдэхүүнийг бий болгон туршиж эхэллээ.

**-Энэ картын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн онцлог...**

-Энэ карт нь тухайн яам, агентлагийн хувьд хамгийн чухал мэдээлэл нээлттэй байгаа бол шууд танилцуулж, харин хаалттай буюу тодорхойгүй бол зохих тайлбарыг хийсэн хүснэгт юм. Картын эхний

Байгаль орчны мэдээллийн төвийн хаяг: [www.оic.mn](http://www.оic.mn) (Байршил: Улаанбаатар 15160, Чингэлтэй дүүрэг, Жууачны гудамж-3. Цаг уур орчин шинэчлээний газар)

**ЯАМНЫ ХАЯРГА АГЕНТЛАГ, ГАЗАР ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖЛЭГЭЭНИЙ ГАЗАР**

Чиг үүрэг, төв танилцуулга	Удирдлага (дарга, дэд дарга)	Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Монгол Улсын нутаг дэвсгэрт цаг уур, орчны шинэчлэгэ хийж мэдээлээр хэрэгжүүлэх үйлчилгээ ажлыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй. Улаанбаатар Ус цаг уур, орчны хүрээлэн, Байгаль орчны мэдээллийн төв, Байгаль орчны хөндийн төв лаборатори, Нислэгийн цаг уурын төв, аймаг, нийслэлд Ус цаг уур орчны шинэчлээний албагч харьяалаг.	Дарга Сөвжидний Энхтүвшин Ус цаг уурын байгууллагад мэргэжилтэн, Байгаль орчны яаманд мэргэжилтэн – Улсын байдалч, лабораторийн инженер, "Дуран" тусгай ерөнхий инженер "Тонгорийн заада" ХХК-ийн Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Цаг уурын инженер мэргэжлэтэй. 1959 онд төрсөн.	Байгууллагын мэдээлэл – <a href="http://www.оic.mn/namem/">www.оic.mn/namem/</a> Цаг агаарын мэдээлэл – <a href="http://www.ил-тод.байгаль.оic.mn">www.ил-тод.байгаль.оic.mn</a> Байгаль орчны мэдээллийн сан – <a href="http://www.оic.mn">www.оic.mn</a>

**Зураг: 2014 оны 6-р сарын байдлаар "Ил тод байдлын карт"-ыг хангалттай сайн бөглөж "Ил тод байдлын индекс"-ээр сайн үнэлгээ авсан Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны картыг сайн туршлагын жишээ гэж үзлээ.**



хувилбарт, яам, агентлагын удирдлага, албан тушаалтан, хүний нөөцтэй холбоотой үндсэн мэдээллийг багтаасан ба цаашид аажмаар өргөжүүлж тухайн яамны талаар илүү өргөн хүрээтэй, илүү иж бүрэн мэдээллийг нэг хавтгайгаас олж авна. “Ил тод байдлын карт” нь төрийн байгууллагын хамгийн чухал мэдээллүүдийг хураангуйлж хүснэгтэн хэлбэрээр харуулсан хавтгай (хуудас) юм. Харин бид төрийн байгууллагын тодорхой мэдээллийг хэрхэн ил тод, нээлттэй болгосныг үнэлэх аргачлалыг ашигласан. Үүний тулд эхлээд олон нийтэд хамгийн чухал ач холбогдолтой, тэдний мэдэх эрхэд нийцсэн тийм мэдээллийн жагсаалт гаргасны үндсэн дээр “Ил тод байдлын карт”-ын загварыг боловсруулсан. Уг картыг нээлттэй эх сурвалжийг ашиглан өөрсдөө бөглөж, дараа нь тухайн байгууллагад хуулийн дагуу хүсэлт тавьж гүйцээж бөглүүлэх аргаар хамтарч ажиллав. Яам, агентлагт тус бүрт тавих асуулт буюу мэдээллийн агуулга ижил учраас тэдгээрийг өөр хооронд нь харьцуулж дүгнэх боломж бүрдсэн.

Төрийн байгууллага тус бүрийн картыг зэрэгцүүлэн нийтэлснээр тэдгээрийн ил тод байдлыг тов тодорхой баримт мэдээлэлд тулгуурлан харьцуулах буюу янз бүрийн үнэлгээ гаргахад дөхөж очлоо. Эхний ээлжинд яамдын ил тод байдлын картыг [www.ilzasag.mn](http://www.ilzasag.mn) цахим хуудсанд нийтэлсэн. Иргэд, олон нийтийн зүгээс төрийн байгууллагын ил тод байдлын тухай судалгааны дүгнэлт бус, ил тод болгосон мэдээлэлтэй шууд танилцах нь ийм картын давуу тал гэж үзэж байна.

-Бид одоо “Ил тод байдлын карт”-ны зөвхөн суурь хувилбарыг ашиглаж байгаа ба төслийн дараачийн үе шатанд улам боловсронгуй болгож дэлгэрүүлэн ил тод байдлын шалгуур болгох хэмжээнд хүргэх зорилт тавьж байна. Бас “Ил тод байдлын карт”-аар төрийн байгууллага, албан тушаалтнуудтай

холбогдолтой бөгөөд урьд хаалттай, тодорхойгүй, эсвэл хагас дутуу байсан, мөн илтгэл тайлан, өгөгдлийн сан зэрэгт далд хадгалагдаж байсан, бас бидний албан хүсэлтийн дагуу яам, агентлагуудаас ирүүлсэн нэлээд олон шинэ баримт мэдээлэл багтсанаар [www.ilzasag.mn](http://www.ilzasag.mn) цахим хуудсанд нээлттэй болж олон нийтийн анхаарал, хэвлэл мэдээллийн эргэлтэнд орсон.

### **–“Ил тод байдлын индекс” –ээ ямар аргачлалаар явуулсан бэ?**

-Урьд нь манайд төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлыг голчлон хүмүүсийн сэтгэгдэл, цөөн тохиолдолд статистик мэдээлэлд тулгуурлан үнэлж байсан. Мөн төрийн байгууллагууд өөрсдөө үнэлэхдээ голдуу энэ чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, тоо хэмжээг үндэслэж байсан юм. Төрийн ямар ч байгууллагад ил тод, нээлттэй байдлын талаар нийтлэг яриа, танилцуулга, ажлын төлөвлөгөө, тайлан, сурталчилгаа хангалттай боловч 2009 оны “Төрийн байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлт”, 2011 оны Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 2012 оны “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам” болон бусад хууль тогтоомжийн дагуу нарийвчилж тулгахад нийтдээ хангалтгүй байна. Үүнийг сүүлийн үеийн судалгаанууд давхар нотолсон.

Дээр дурдсан хууль журмын заалтуудын ихэнх нь ерөнхий, тодорхой хэмжүүр байхгүйн улмаас судалгааны байгууллагууд өөр өөрийн харах өнцөг чадавх, боломжоос шалтгаалан үзэмжээрээ үнэлж дүгнэхэд хүргэж байна. Авлигийн индекс, шударга байдлын түвшин, нийгмийн хэсэг бүлгийн төсөөлөл, төсөл, хөтөлбөрүүдийн биелэлтийн талаарх судалгаа, үнэлгээний ажлуудын тайланг үзэхэд ил тод байдлын шалгуурын нэр томъёо, агуулгын талаарх нэгдсэн

ойлголт, стандарт хараахан тогтоогүй нь ажиглагдлаа.



### **-Шинэ арга зүй нэвтрүүлсэн гэсэн үг үү?**

-Ийм нөхцөлд манай байгууллага өөрийн үзэмжээр дахин нэг индекс гаргаж давтах нь учир дутагдалтай гэж үзсэн.

Манай төслийн бүтээгдэхүүн болох Төрийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлын индекс (рейтинг)-ийн шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсруулах ажил хоцрогдонгуй явж байгаа нь бидний өмнө тулгарсан нэг бэрхшээл юм.

Иймээс Түншлэлийн гишүүдийг оролцуулсан хэлэлцүүлэг, мөн бусад байгууллага, судлаачидтай хийж байгаа ажил хэргийн уулзалтын үеэр гарсан санал шүүмжлэл, зөвлөмжүүдийг хүлээн авч зарчмын өөрчлөлтийг оруулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд, төрийн яам, агентлагийн ил тод, нээлттэй байдлыг

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль -ийн бүх шалгуур үзүүлэлт, дээрээс нь өөрсдийн зүгээс нэмсэн шалгууруудыг багтаасан нүсэр байдлаар биш, харин хэсэгчилж, тодорхой сэдэв, асуудал, үйл явдал, баримт жишээг тухайн цаг хугацаа, орон зайд хэрхэн ил тод болгосноор үнэлж байх тийм арга зүйг эрж хайж байна.

Тухайлбал, яамдууд сайдын зөвлөл, эсвэл төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүнийг хэрхэн зарласан, ямар нэгэн худалдан авах ажиллагааг явуулахдаа хуульд зааснаар үнэлгээний хорооны ил тод байдлыг хангахын тулд төрийн бус байгууллагын төлөөллийг оруулж ажиллуулсан баримтууд, яам, агентлагийн төсвийн тодорхой зүйлийн (төрийн албан хаагчийн буруутай үйлдлээс учирсан хохирлын нөхөн төлбөр, томоохон худалдан авалт гэх мэт) зарцуулалтыг тайлагнасан байдал, эсвэл тухайн яам, агентлаг, байгууллагын мэдэлд байдаг буюу ашигладаг өмч хөрөнгө (байшин барилга, газар, амралтын газар, орон сууц зэрэг) -ийн тухай мэдээлэл нээлттэй эсэх.

Энэ мэт тодорхой үнэлгээг хэсэг хугацааны дараа давтан явуулж ямар өөрчлөлт, чиг хандлага гарсныг тогтоох, улмаар хэд хэдэн ийм үнэлгээг нэгтгэж иж бүрдэл болгох зэргээр индекс (рейтинг)-ийн арга зүйг үе шаттайгаар нэвтрүүлж ажиллана.Цаашид ил тод байдлын индекс (рейтинг)-ийг тодорхой давтамжтайгаар гаргана.

### **“Хаалттай” мэдээлэл хийгээд эрэн сурвалжлага**

**-Ил тод байдал сангийн судлаачдын ихэнх нь сэтгүүлчид. Та бүхнийг хаалттай сэдвээр эрэн сурвалжлага хийж эхэлсэн гэж сонссон.**



-Төрийн байгууллага, албан тушаалтнуудын тухай мэдээллийг иргэд, сэтгүүлчдийн, үзэл бодлынхоо дагуу үнэлж дүгнэсэн, захиалгат, эсвэл хөндлөнгийн нөлөө орсон нийтлэл, нэвтрүүлэг, сурталчилгаанаас олж авдаг. Ийм нөхцөлд тэр бүх мэдээлэл бодит байдалтай хэр нийцэж байгааг тогтоох үүднээс төслийн энэ үе шатанд телевизийн мэдээллийн хөтөлбөр ба нийгэм, улс төрийн агуулгатай нэвтрүүлгүүд болон өдөр тутмын сонинуудын төстэй нийтлэлд мониторинг хийх эхлэлийг тавилаа. Төслийн дараачийн бүрэлдэхүүн хэсэг болох хаалттай мэдээллийг эрэн сурвалжлах замаар нээлттэй болгох сэдвүүдийг урьдчилсан байдлаар: "Төрийн зарим өндөр албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэгт дурдсан, тэдний хувь эзэмшдэг компаниуд хэзээ байгуулагдсан, ямар үйл ажиллагаа явуулдаг, бусад хувь эзэмшигчид нь хэн болохыг тодруулах замаар улс төрчдийн хэлхээ холбоо, болзошгүй сонирхлын зөрчлийг дэлгэн харуулах, зарим яам, агентлаг ажиллагсаддаа зориулан орон сууцны барилга захиалан бариулж байгаа, төсвийн байгууллагууд өөрийн мэдлийн газрыг барилгын компанид өгч, орон сууц бариулж байгааг судалж ил тод болгох, Засгийн газрын 29 тусгай сангаас анхаарал татсан 5-6 тусгай сангийн зарцуулалтын задаргааг арга хэмжээ тус бүрээр (2013 оны 1,2,3-р улирал болон жилийн эцсийн дүнгээр) нээлттэй болгохоор " сонгож жагсаалт

гарган нягталж байна.

**-Манайд эрэн сурвалжлагыг хэвлэл мэдээллийн сенсаац нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх гэсэн утгаар түлхүү ойлгож ирсний улмаас сэтгүүлчид анхаарал татахуйц баримт мэдээлэл тааралдвал, эсвэл сураг ажиг сонсмогцоо хальт тодруулаад хувийн зүгээс дүгнэлт өгч шуугиулахыг оролддог болж тэрхүү чухал асуудал бүрэн тодрохгүй үлдэх, сэтгүүлч өөрөө бусдад ашиглагдах, захиалга гүйцэтгэгч болж хувирах, заримдаа гүтгэлгийн хэрэгт орооцолдох явдал гардаг.**

-Харин бид Азийн сангийн төслийн зүгээс олгосон боломжийг ашиглан нээлттэй эх сурвалж, мэдээллийн сан, архивт хандан урьдчилсан судалгаа хийх замаар олж авсан өгөгдөл, баримт мэдээллээ боловсруулан асуудлын ерөнхий дүр зургийг гаргасны дараа сэтгүүлчээр дутууг гүйцээх буюу хамаарал, учир шалтгаан зэргийг илрүүлэхэд чиглэсэн маш тодорхой эрэн сурвалжлагыг хийлгэж байгаа болно.

Бид төлөвлөсний дагуу, мөн МУИС, Хэвлэлийн хүрээлэн, "Глоб Интернэйшнл" байгууллагын судлаачдын зөвлөгөөг авч баримт мэдээллийг боловсруулах шинэлэг арга зүйд тулгуурласан өгөгдлийн сэтгүүл зүй буюу data journalism-ийг Монголд хөгжүүлэх зорилт тавьж байгаа бөгөөд манай эрэн сурвалжлагад хамрагдаж буй сэтгүүлчид анхдагчид байх юм.

**Лавлагаа холбоос:**  
[www.ilzasag.mn](http://www.ilzasag.mn)

**Холбоо барих:**

Д.Цэрэнжав "Ил тод байдал сан"  
ТББ-ын Гүйцэтгэх захирал  
Утас: 99163657  
Электрон шуудан:  
[tseren2005@yahoo.com](mailto:tseren2005@yahoo.com)



## МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН НИЙГМИЙН ШУДАРГА ЁСНЫ ТӨЛӨӨ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХҮЧИРХЭГЖҮҮЛНЭ

### “МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**САЙН ТУРШЛАГА:** “Монгол Улсад Засаглал, ил тод байдлыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Үйлчилгээгээ өөрсдөө хяная” нэртэй бичил төслийг Азийн сангийн тэтгэлэгтэйгээр дөрвөн дүүргийн дөрвөн цэцэрлэг дээр эхлүүлжээ.

Уг төсөл нээлттэй, ил тод байдлыг тухайн цэцэрлэг дээр хэвшүүлж, эцэг эхчүүдийн хяналт болох иргэдийн онооны картын тусламжтайгаар төрийн үйлчилгээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, цэцэрлэгийн талаарх иргэдийн сэтгэлгээ хандлагыг өөрчлөх төдийгүй Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль -ийг төрийн үйлчилгээний анхдагч байгууллага цэцэрлэг дээр хэвшүүлж, хэрэгжилтийг нь хангахад туслалцаа, дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Энэхүү төслийг “Монголын эмэгтэйчүүдийн сан” ба “Эмэгтэй удирдагч сан” ТББ-ууд хамтран хэрэгжүүлжээ.

## “ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ ӨӨРСДӨӨ ХЯНАЯ”

Засгийн гаргасан шийдвэрээр цэцэрлэгийн багачууд өдөрт 1650 төгрөгийн хоол хүнс хэрэглэдэг. Өлсгөхгүй л байвал тэр илчлэг чанарын асуудал яриад ч хэрэггүй. Цэцэрлэгийн төсөв тоглоом авах, цагаан хэрэглэл, сандал ширээ авахад хаанаа ч хүрдэггүйг багш эрхлэгч нар байнга л учирладаг.

Нэг нь төсөв мөнгө хүрэхгүй байна гэх, нөгөө нь хүүхдийнхээ цэцэрлэгийн орчин нөхцөл ямар байгааг мэдэхгүй явсаар, дунд нь хүүхэд хохирч байна. Мэдээлэл авах эрх нь хуулиар нээлттэй болсон энэ цагт эцэг эхчүүд бид хэнэггүй явсаар л байх уу.

2011 онд батлагдан мөрдөгдөж байгаа Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх -ийн тухай хууль, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад мөрдөх журам нь зөвхөн төрийн албан хаагчдад зориулагдсан юм шиг л ойлгож байсан нь эндүүрэл ажээ.

Энэ хууль бүх шатны үйлчилгээний байгууллагад хамаатай гэдгийг “Монголын Эмэгтэйчүүдийн сан” болон “Эмэгтэй удирдагч Сан” ТББ-тай хамтран Азийн сангийн дэмжлэгтэйгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах “Үйлчилгээгээ өөрсдөө хяная” төслийнхөн харууллаа.





**Энэ талаар тодруулахаар уг төслийг хэрэгжүүлсэн Монголын эмэгтэйчүүдийн сангийн гүйцэтгэх захирал Б.Эрдэнэчимэгтэй уулзлаа.**

-Хүүхдүүд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаагийн гол шалтгаан нь цэцэрлэгийн хүрэлцээ хангалтгүй, шилжин суурьшигчдын тоо нэмэгдэж байгаа явдал юм.

Цэцэрлэгийн талаарх мэдээлэл ил тод байдаггүй учир эцэг, эхчүүд танил талаа ашиглан авлига өгч цэцэрлэгт оруулдаг гэсэн нийтлэг ойлголт олон нийтийн дунд байдаг.

Эцэг эхчүүдэд хэдэн хүүхдийг бүртгэх, таны хүүхэд бүртгэлийн хэддэх дугаарт жагсч байна, хүүхдийн шилжилт хөдөлгөөнөөс хамаараад хэдийд орон тоо гарах, ямар ур чадвар, туршлагатай багш нар ажиллаж байгаа зэрэг хэрэгцээтэй мэдээлэл нь ил тод байдаг бол хонон өнжин дугаарлаж, хэн нэгэн таньдаг хүнийг хайхгүй байх боломж байна гэснээр бидний ярилцлага эхэллээ.

**-Үнэхээр цэцэрлэгүүдийн ачаалал их байгаа шүү дээ.**

-Цэцэрлэгүүд дотоод нөөц бололцоо, нийтийн эрх ашгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрийн хүчин чадлаас дандаа хэтэрсэн ачаалалтай ажиллаж байна.

Ийм үед нэмж цэцэрлэг барьж чадахгүй байна гэж гомдоллохоос илүү одоо байгаа хүчин чадал, орон тоог нэмж ээлжийн багштай болгох хэрэгтэй юм. Нийслэлд цэцэрлэгийн зориулалтаар баригдсан 30 гаруй барилга өөр зориулалтаар хувийн өмчид шилжин ашиглагдаж байгааг мэдээлснийг шинэ барилга барих төсөвгүй байгаа шийдвэр гаргагчид маань лав анзаарсан байх. Ер нь бол цэцэрлэгийн сайн засаглалын нэг хэсэг нь төлөвлөлт юм шүү.

**-Төсөлд хамрагдсан цэцэрлэгүүдийг хэрхэн сонгосон бэ? Гэр хороолол, хотын төвийн цэцэрлэгүүдийн хооронд ялгаа байв уу ?**

-Бид үүнийг мэдээж бодолцсон. Эдгээр цэцэрлэгүүд адил биш, ялгаатай төдийгүй өөр өөрийн онцлогтой байсан. Тухайлбал, хотын захын гэр хорооллын гэгдэх Хан-Уул дүүргийн Яармагийн 189 дүгээр цэцэрлэг өмнөх жил нь байгуулагдаж бүх зүйлийг шинээр эхлэж буй онцлогтой байв. Баянгол дүүргийн 76 дугаар цэцэрлэг гэр хорооллын болон байрны хүүхдүүд хамтдаа явдаг гурав, дөрөвдүгээр хороололд социализмын үед баригдсан олон цэцэрлэгийн нэг.

Баянзүрх дүүргийн 22 дугаар цэцэрлэг орон сууцны хороололд байрлалтай, бусад гурван цэцэрлэгээ бодоход олон улсын төсөлд өмнө нь хамрагдаж, "Шилэн түрийвч"-ний талаар туршлага хуримтлуулсан, өөрийн цахим хуудастай орчин үетэй хөл нийлж яваа өвөрмөц цэцэрлэг. Сүхбаатар дүүргийн хоёрдугаар цэцэрлэг хотын төвд байрлалтай 70,80-аад оны барилгатай цөөн ангитайгаараа бусдаасаа ялгагдах онцлогтой байсан.



**-Цэцэрлэгийн үйл ажиллагааны ил тод байдал гэхээр нэг их сонин сонсогдож байна шүү. Бид чинь Засгийн газрын мэдээлэл, аймаг дүүргийн мэдээлэл л ил тод байна уу, үгүй юу л гэж маргадаг болохоос цэцэрлэгийг бүүр анзаарч ч байгаагүй байсан юм байна.**

-2012 оноос эхлэн хэрэгжсэн Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд төрийн бүх байгууллага мэдээллээ ил тод байлгах үүрэг хүлээсэн байдаг. Ийм учир эцэг эхчүүдийн зүгээс хуулиа хэрэгжүүлэхийг шаардаж тухайн цэцэрлэгийн бүхий л үйл ажиллагааны талаар мэдээлэл авах эрхтэй.

Гэхдээ хуулийн талаар мэдээлэл эцэг эхчүүдэд дутмаг байгаа учир мэдээллүүдийг ил тод болгохыг шаарддаггүй. Энэ нь нэг талаар цэцэрлэгийн зүгээс үйлчлүүлэгчдээ зориулсан хэрэгцээтэй мэдээлэл бага, нөгөө талаар эцэг эхчүүдэд хангалттай, хэрэгцээтэй мэдээлэл дутмаг байдагтай холбоотой.

**-Тийм шүү. Өглөө хүүхдээ бушуухан оруулж өгөөд, орой нь хурдхан аваад явахыг л бодно, юун тэр мэдээлэлтэй манатай л юм болдог. Багш юм хэлэхгүй бол анзаарах ч үгүй. Ихэнхдээ л байдал ийм байдаг.**

-Нэг ангид 20 хүүхэдтэй ажиллах ёстой багш маань 60 гаруй хүүхэдтэй өдөржингөө ажиллаад, хүн бүрт нэг бүрчлэн мэдээлэл өгнө гэдэг нь бас хэцүү. Ийм учир эцэг эхчүүд цэцэрлэгт хүүхэд нь ямар үйлчилгээ авч байна гэдэг мэдээллийг бүрэн авч чаддаггүй.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулинд эцэг эхчүүд “цэцэрлэгийн сургалтын орчин, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, сургалтын чанартай холбогдсон санал хүсэлт, гомдол гаргах, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хяналт тавьж, санал гаргах, хүүхдийг сургах үйл ажиллагаатай холбогдуулан өөрөөс

гаргасан зардал, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих” эрхтэй боловч ийм эрхтэй гэдгийгээ мэддэг эцэг эх цөөн.

**-Эцэг эхийн оролцоо хязгаарлагдмал байна гэж та хэлэх гээд байна аа даа?**

-Цэцэрлэгийн орчныг сайжруулахад тусалж, хандив өгөх, хамтрах зэргээр идэвхтэй оролцдог санаачилгатай ээж аавууд нэлээд бий.

Цэцэрлэгийн захиргаа нь ч эцэг эхчүүдийн дунд уралдаан зохиох зэрэг эцэг эх, цэцэрлэгийн хоорондын холбоо харилцаагаа бэхжүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж байна. Мөн эцэг эхчүүд маань хичээлийн жилийн турш хүүхдүүдийнхээ сурсан бүхнийг үзэж харах боломжтой байдагт сэтгэл хангалуун байдаг. Эцэг эхийн оролцоо үүгээр л хязгаарлагдаж байна.

**-Эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь хамгийн чухал юм аа даа. Тэднийг яаж идэвхжүүлэх вэ?**



-Тэгэлгүй яахав. Эцэг эхчүүд нь ажлаа хийхийн тулд цэцэрлэгт хүүхдээ өгчихээд л “чимээгүй” явах ёстой биш, харин өөрсдийн оролцоо, идэвх санаачилгаар цэцэрлэг дээр олон зүйлийг өөрчилж болно гэдэг итгэл үнэмшилтэй болж эхлэж байна. Намар цэцэрлэг эхлэх үеэр шөнөжин дараалалд зогсож хүүхдээ цэцэрлэгт арай гэж оруулсан бол хэл ам

гаргахгүйхэн байя гэдэг сэтгэлгээг өөрчлөх зорилт бидний өмнө тулгарсныг хэлэх ёстой болов уу. Цэцэрлэг дээр байх ёстой олон стандарт, норм зөрчигдөж байдаг эцэг эхчүүд санаа зовох болсон. 20 хүүхдийн нормтой нэг ангид хотын төвд ч, хотын захад ч 60 гаруй хүүхэд, шахалдан байгаа нь энгийн үзэгдэл болсныг хэрхэн яаж шийдэх шийдлийг хамтдаа эрж хайж эхэллээ.

### **-Цэцэрлэгийн бүх мэдээлэл ил тод байх ёстой гэхээр хүмүүс яаж хүлээж авч байна?**

-Эцэг эхчүүдийн хувьд нэлээд болгоомжилсон байдлаар хүлээн авсан. Бид цэцэрлэгтэйгээ зөрчилдөхийг хүсэхгүй байна гэсэн хандлагатай байсан. Хоёр төрийн бус байгууллагын хувьд мэдээлийг ил тод болгосноор хүүхэд нь өнөөдөр эрүүл, аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхийг мэдэх шаардлагатай байгааг ойлгуулсан.

Бид ажилласан дөрвөн цэцэрлэгийнхээ эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг сургалтад хамруулж, тэднээр цэцэрлэгийн орчны талаарх судалгааг хийлгэж үзлээ. Нэг ангид байх хүүхдийн орон тоо, нэг хүүхдэд ноогдох талбай, нэг суултуурт бие засах хүүхдийн тоо гэсэн гуравхан үзүүлэлтийн дагуу үнэлж үзэхэд л цэцэрлэгийн орчин ямар байгаа, хүүхдийн эрх яаж зөрчигдөж байгааг мэдэрсэн.

#### *Эцэг эхийн хийсэн үнэлгээний мэдээлэл*

Шалгуур үзүүлэлт	Норм норматив	Бодит байдал	Үр дагавар, эрсдлүүд
Нэг ангид байх ёстой хүүхдийн тоо	20 хүүхэд	60 хүүхэд 1 ангид хүмүүжиж байна	Багш 2 дахин их ачаалалтай ажиллаж байгаа учир хүүхэд нэг бүрт хүрч ажиллах, анхаарал тавих боломжгүй үүнээс үүдэлтэй хүүхдийн аюулгүй байдлын эрсдэл нэмэгдэнэ
1 хүүхдэд ноогдох талбай	Дунджаар 5 м <sup>2</sup>	Нэг хүүхдэд ноогдох талбай 2-2,4 дахин бага  /Нэг хүүхдэд ноогдох талбай ...м <sup>2</sup>	Агааржуулалтын төхөөрөмж байхгүй, цонх онгойлгож агааржуулдаг учир өвлийн цагт хүүхэд ханиад хүрэх магадлал өндөр. Бүгчим, чийгтэй, амьсгалын замаар дамжих халдварт өвчин гарах эрсдэлтэй, хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлал өндөр. Хүүхдийн хэвийн хөдөлгөөн хязгаарлагдсан учир биеийн хөгжлийг саатуулах эрсдэлтэй.
Суултуур	8 хүүхдийн дунд 1/стандартын дагуу нэг ангид байх хүүхдийн тоотой харьцуулан тооцов/	20 хүүхдэд 1 суултуур ноогдож байна  /нэг ангид 3 суултуур л байдаг/	Эрүүл ахуйн шаардлага хангасан орчин алдагдаж, бохиртож, багшийн ачааллыг нэмэгдүүлдэг, халдварт өвчин тусах эрсдэл өндөр, бие биенээ удаан хүлээх зуур өмдөндөө бие засах, өндөр эрсдэлтэй.

Чанартай үйлчилгээ авахын төлөө эцэг эхчүүд оролцох хэрэгтэй гэдгийг ч Эцэг эхийн зөвлөлийн

гишүүдийн хийсэн үнэлгээ харууллаа. Ийм учир цэцэрлэгийн эцэг эхчүүд түүний дотор Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны нэг чиглэл бол хүүхдийнхээ авч байгаа үйлчилгээний талаар мэдээлэл байнга авах, үйлчилгээ ямар байгаад хяналт тавьж, дутагдлыг сайжруулахыг шаардах, шийдвэр гаргахад оролцох оролцоог нэмэгдүүлэхийг зорьсон.

### **-Цэцэрлэгийн үйл ажиллагааг нээлттэй болгохын тулд ямар бодитой ямар ажлууд хийсэн бэ?**

-Эцэг эхчүүдэд хэрэгцээтэй мэдээллийг зөвхөн самбараар төдийгүй цахим хуудас, нийгмийн мэдээллийн сүлжээг ашиглан тараах нь ач холбогдолтой гэдэг нь харагдлаа.

Бид сонгон ажилласан дөрвөн цэцэрлэгтэй цахим хуудас нээж, эцэг эхчүүдэд цэцэрлэгийн үйл ажиллагаа, багш, ажиллагсдын тухай болон худалдан авалт, төсөв санхүүгийн талаар ил тод мэдээлсэн.


Дээрх мэдээлэл нь цэцэрлэгт хүүхэд ямар зүйл сурч, ямар хоол идэж байна гэсэн мэдээллээс эхлээд хүүхэд өдөрт хэдэн төгрөгний хоол иддэг, цэцэрлэгийн төсөв, хүүхдийн хоол, хүнсийг ямар байгууллагаас худалдан авдаг зэрэг олон асуудалд хариу авах боломжийг бүрдүүлсэн юм.

Багш ажилтнууд болон эцэг эхчүүдийн оролцоог цэцэрлэгийн үйл ажиллагаанд хангах дараагийн бүрэлдэхүүн хэсэгт нүүр тулсан уулзалт, сургалтуудыг зохион байгуулж, цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдтэй хамтран хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, асуудал дэвшүүлж хамтран шийдвэрлэх, иргэдийн онооны картаар үнэлгээ хийсэн нь үр дүнтэй болсон.

Цэцэрлэгийн хоолны амт чанарыг сайжруулах, хоол хүнсний хангалтад эцэг эхчүүдийн анхаарлыг хандуулах ажлыг зохион байгууллаа.

Сайн засаглалын бас нэг бүрэлдэхүүн хэсэг болох хууль, эрх зүйн хүрээнд тус цэцэрлэгүүд үйл ажиллагаагаа явуулах ажлыг хэвшил болгохын тулд үйл ажиллагаанд суурилсан сургалт явуулж, холбогдохууль эрх зүйн актаар гарын авлага бэлтгэн өгч хуулийн хэрэгжилтээр дүрийн тоглолт хийх, нүүр тулсан уулзалтаар мэдээлэл хүргэх, энгийн ойлгомжтой байдлаар төсвийн хуулийг мэдээллийн самбараар дамжуулан сурталчлах гэх мэт ажлуудыг хийсэн нь эцэг эхчүүд болон багш ажилтнууд хуулийг хэрэгжүүлэхэд оролцоотой байх ёстойгоо ойлгоход чухал алхам болсон юм.

### **-Та бүхний сонгосон арга хэр оновчтой байв ?**



-Бидний сонгосон арга зөв байсан. Арга зөв байсныг эцэг эхчүүдийн цахим хуудаст үлдээсэн сэтгэгдэл болон сургалтууд дээр ярьсан зүйлээр баталгаажиж байна.

Төрийн үйлчилгээний анхан шатны нэгж болох цэцэрлэгийн үйлчлүүлэгчдийнхээ

онцлог, тэдний сонирхол хэрэгцээнд нийцсэн мэдээллийг бүгдийг нэг мөр сайжруулах нь цаг хугацааны асуудал. Эцэг эхчүүд цэцэрлэгт хүүхэд нь ямар үйлчилгээ авч байна гэдэг мэдээллийг өгч байх ямар оновчтой хэлбэр байж болох вэ гэдгийг анхаарсан юм. Цэцэрлэгүүд бүгд цахим хуудас нээж, болж байгаа гол үйл явдлыг мэдээлэх болсон төдийгүй, үйл ажиллагааны ил тод байдал гэсэн цэстэй болсон.

Мэдээллийн самбараар дамжуулан эцэг эхчүүдэд мэдээллийг энгийнээр, ойлгомжтой танилцуулах уралдаан цэцэрлэгүүдийн дунд зарласан. Уралдааныг эцэг эхчүүд шүүсэн.

Мэдээллийн ил тод байдлын талаар эцэг эхчүүдийнхээ ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх “Оролцоонд суурилсан нээлттэй цэцэрлэг” цуврал сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар эцэг эхчүүд хүүхдийнхээ ангийн самбар, цэцэрлэгийн хэмжээнд тавигдсан самбаруудад дүн шинжилгээ хийж, сайжруулах талаар санал бодлоо илэрхийлсэн.

Эцэг, эхчүүд урьд нь мэдээллийн самбарыг зөвхөн хараад л өнгөрдөг байсан бол ямар мэдээлэл тавигдсан гэдэгт дүн шинжилгээ хийж, сайжруулах саналуудыг гаргасан.



Дөрвөн цэцэрлэг дээрээ “Нээлттэй цэцэрлэг” сарын аян өрнүүлсэн. Аяны хүрээнд цахим хуудасны баяр, эцэг эхчүүдийн сургалт, “шилэн түрийвч”

санхүүгийн үйл ажиллагааг танилцуулах нээлттэй өдөрлөг, “Эрүүл хүнс” өдөрлөгийг зохион байгуулсан.

Эрүүл хүнс өдөрлөгийн үеэр цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсэнд хэрэглэж байгаа бүтээгдэхүүнийг хаанаас авдаг хүүхдийн хоолны илчлэг, нормын талаар ойлголтоо нэмэгдүүлсэн.

Төслийн тогтвортой үргэлжлэх байдлыг хангах зорилгоор Нийслэлийн Боловсролын газартай хамтарч цэцэрлэгийн дүрмийг шинэчлэн боловсруулсан. Цэцэрлэгийн дүрэмд мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах асуудалтай холбоотой нэлээд хэдэн заалтыг тусгасан.

### **-Эхлүүлсэн ажлаас сэтгэл дундуур үлдсэн юм юу байна ?**

-Үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн идэвхтэй хэсэг л оролцож байлаа. Цэцэрлэгт багш, арга зүйч, туслах багш, туслах ажилчид гэсэн орон тоотой. Харин цахим хуудас ажилуулахад цэцэрлэгийн ажиллагсдад давхар ачаалал үүсэх, цаг зав зарцуулсны төлөө ямар нэгэн нэмэгдэл хөлс авахгүй, ажил хавсран гүйцэтгэх талаар нэмэгдэл хөлсийг цэцэрлэгийн төсөвт тусгах боломжгүй байсан учир, цахим хуудсууд тухай бүр шинэчлэгдэж чадахгүй байсан.

### **-Төслийнхний гол зорилго болох нээлттэй цэцэрлэгийн цаашдын дүр төрхийг дүрсэлбэл?**

-Цэцэрлэгийн үйлчилгээний талаарх мэдээлэл ил тод, багш ажилчид, эцэг эхчүүд санал бодлоо илэрхийлэх оролцох боломжтой гэдгийг төслийн багийнхан маань харуулахыг хичээж байна.

Бид хамтдаа ардчилсан ёсонд суралцаж, цэцэрлэгийн үйлчилгээг чанартай болгон, хууль, дүрэм журам, стандартын дагуу хүргэхэд анхаарч байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангаж

ажиллаж байгаа туршлагаа дөрвөн дүүргийн цэцэрлэгүүдтэй хуваалцах зорилгоор “Нээлттэй цэцэрлэг” хэлэлцүүлэг, дөрвөн дүүргийн 110 цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч нарт “Цэцэрлэгийн сайн засаглал ба мэдээллийн ил тод байдал” сургалтыг зохион байгуулж хуримтлуулсан арга туршлагаасаа хуваалцсан.

Төсвийн нээлттэй ил тод байдлыг ханган ажиллаж байгаа талаар Багануур дүүргийн 138-р цэцэрлэгийн арга туршлагаас суралцсан. Төсвийг үйлчлүүлэгчиддээ ойлгомжтой, энгийн, сонирхолтой танилцуулдаг болсноор эцэг эхчүүдийн цэцэрлэгийн төсвийн талаарх ойлголт мэдлэгээ нэмэгдүүлсэн.

### **-Энэ туршлагаас та бүхэн ямар шинэлэг санаа оноо сургамж олж авсан бэ?**

-Эцэг эхчүүдэд өгөх мэдээллийн хүртээмж, чанарыг сайжруулах нь үйлчилгээг сайжруулах нэг чухал хүчин зүйл. Мэдээлэлтэй болж байж иргэд, эцэг эхийн үйл ажиллагаа идэвхтэй болж, оролцоо нэмэгдэнэ. Оролцоо нь зөвхөн цэцэрлэгээс санаачилсан үйл ажиллагааг дэмжих төдийгүй авч байгаа үйлчилгээгээ эцэг эхчүүд өөрсдөө хянаж болно гэдгийг олж харсан.

#### **Лавлагаа холбоос:**

[www.mones.org.mn](http://www.mones.org.mn)  
[www.kindergarten2.mn](http://www.kindergarten2.mn);  
[www.kindergarten76.mn](http://www.kindergarten76.mn);  
[www.kindergarten189.mn](http://www.kindergarten189.mn);  
[www.kids22.mn](http://www.kids22.mn)

#### **Холбоо барих:**

“Монголын эмэгтэйчүүдийн сан” ТББ  
Утас: 7711991

Электрон шуудан: [mones@mongol.net](mailto:mones@mongol.net)  
Байршил: Сүхбаатар дүүрэг 6-р хороо,  
Бага тойруу 48-р байр 305 тоот



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР :

Багийн ИНХ -Багийн иргэдийн нийтийн хурал  
БХД-Багахангай дүүрэг  
ДЕМО-Ардчиллын боловсрол төв  
ЕБС-Ерөнхий боловсролын сургууль  
ЗДТГ- Засаг даргын Тамгын газар  
ЛЭОС-Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан  
ИНБ -Иргэний нийгмийн байгууллага  
ИОК-Иргэдийн онооны карт  
ИТХ- Иргэдийн төлөөлөгчдийн хурал  
ОНХС -Орон нутгийн хөгжлийн сан  
УБЕГ-Улсын бүртгэлийн ерөнхий газар  
СБД-Сүхбаатар дүүрэг  
ТББ -Төрийн бус байгууллага  
ХҮОНЗ-Хяналт, үнэлгээний олон нийтийн зөвлөл

